



ХАСБАНК

ЖИЛИЙН
ТАЙЛАН
2021

ЗӨВХӨН
ЭХЛЭЛ

ЖИЛИЙН ТАЙЛАН 2021

Эрхэм зорилго

Эрдэнэт хүмүүн, Эх дэлхий, Эрүүл ашгийг эрхэмлэн харилцагчдадаа үнэ цэнтэй санхүүгийн үйлчилгээг хүргэж, насан туршийн түнш нь байх болно.

Хэтийн зорилт


Бид Монголдоо дэлхийн түвшний санхүүгийн үйлчилгээтэй байгууллага болно.

Агуулга

2021 оны онцлох	4
ТУЗ-ийн даргын мэндчилгээ	6
Гүйцэтгэх захирлын мэндчилгээ	8
Тогтвортой өссөн 20 жил	
Санхүүгийн гүйцэтгэл	12
20 жилийн онцлох үйл явдлууд	14
Хувьцаа эзэмшигчдийн бүтэц	16
Төлөөлөн удирдах зөвлөл	17
Гүйцэтгэх удирдлага	20
Олон улсын үнэлгээ	22
Санхүүжүүлэгч, түнш байгууллагууд	23
Энэ бол ЗӨВХӨН ЭХЛЭЛ	
Иргэдийн Банк	24
Бизнес Банк	28
Лизинг	30
Цахим шилжилт	32
Эко Банк	36
Мэдээллийн технологи	44
Нийгмийн хариуцлага	46
Санхүүгийн үзүүлэлт	
Бизнесийн орчин	49
Макро эдийн засгийн төлөв	50
Банкны салбар	52
Санхүүгийн үзүүлэлт	54
Дотоод аудит	56
Эрсдэлийн удирдлага	57
Хүний нөөц	60
Банкны засаглал	64
Аудитлагдсан санхүүгийн тайлан	
Харуут бус аудиторын тайлан	80
Аудитлагдсан санхүүгийн тайлан	82

2021 оны ОНЦЛОХ

2021 онд ХасБанк 333.2 тэрбум төгрөгийн үнэ цэнийг бий Монгол Улсын эдийн засагт бий болголоо.



Хадгаламж
эзэмшигчдэд
төлсөн хүү
100.4

Хувьцаа
эзэмшигчдэд
75.3

Төлсөн
татвар, НДШ
54.4

Хадгаламжаас бусад
эх үүсвэрийн хүүнд
61.0

Бэлтгэн
нийлүүлэгчдэд
29.9

Цалин, урамшуулал
31.7

Цэвэр ашиг (₮)
75.3 тэрбум
▲123.4%

Нийт хөрөнгө (₮)
3.5 их наяд
▲3.9%

Нийт зээл (₮)
1.85 их наяд
▲26.2%

Харилцах, хадгаламж (₮)
2.23 их наяд
▲11.1%

Өөрийн хөрөнгийн өгөөж
24%
▲12%

Гадаад эх үүсвэр (₮)
638 тэрбум
▼26.4%



Тогтвортой

Санхүүгийн үйлчилгээ авах боломжоор хязгаарлагдмал иргэдэд хүрч үйлчлэх зорилгоор үйл ажиллагаагаа эхэлж байсан ХасБанк 20 нас хүрлээ. Бидний 20 жилийн түүх банк хэрхэн эрүүл, тогтвортой өсөж болдогийн сайн жишээ.



Хүнлэг

Цар тахлын улмаас өрхийн орлого, бизнесийн үйл ажиллаанд нь бэрхшээл учирсан харилцагчдынхаа зээлийн нөхцөлд өөрчлөлт оруулах ажлыг үргэлжлүүлэн хийхийн зэрэгцээ хугацаатай хадгаламж цуцлах, ЗГ-ын нэг удаагийн мөнгөн тусламж авах хүсэлтүүдийг тухай бүр онлайнгаар хүлээн авч, шийдвэрлэлээ.



Дижитал

2021 онд ХасБанк интернэт банк, дижитал аппликейнаа бүрэн шинэчилж урьд өмнө байгаагүй боломжуудыг нэвтрүүллээ. Одоо нийт гүйлгээний 97% нь дижитал сувгаар хийгдэж, зээл авах, данс нээх, карт захиалахын тулд банк руу явах шаардлагагүй болсон.



Хүртээмжтэй

Хорио цээрийн дэглэм тавигдсаны дараа үйл ажиллагаагаа сэргээж, хүчин чадлаа нэмэгдүүлэхэд нь бизнес эрхлэгч нартаа дэмжлэг үзүүлэх зорилгоор ажлын байрыг нэмэгдүүлэх 3%-ийн хүүтэй зээл, репо санхүүжилт зэрэг төрөөс хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдээс гадна бизнес дэмжих саруудыг зарлан амжилттай хэрэгжүүллээ.



Нээлттэй банк

Бид технологид суурилсан санхүүгийн үйлчилгээ /fintech/ үзүүлэх бизнесүүдийг дэмжин, нээлттэйгээр хамтран ажилладаг. Энэ хугацаанд Candy/ Monpay төлбөрийн карт, Red point, NEG app, 360 finance, Social POS, Qpay, Most Money зэрэг харилцагчдад санхүүгийн үйлчилгээг улам хялбар, ойр дөт болгож, илүү боломж олгох үйлчилгээнүүдийг хамтран нэвтрүүлсэн.



Байгальд ээлтэй

ХасБанк 2009 онд банкны салбартаа анхны эко банкны хэлтсийг байгуулж, 2013 оноос хүлэмжийн хийг бууруулах зээлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд эдгээр хөтөлбөрүүдийн дүнд нийт 2.1 сая тонн хүлэмжийн хийн ялгарлыг бууруулсан нь 152 сая ширхэг мод тарьж, 10 жилийн турш ургуулсантай ижил үр дүн юм. Нэг га-д 300 мод тарьсан гэвэл 152 сая ширхэг мод нь Улаанбаатар хотын газар нутгаас 1.1 дахин том газар нутгийг тэр чигт нь бүрхэнэ.



Бэлтгэгдсэн

ХасБанк IPO хийн, олон нийтэд нээлттэй компани болоход урьдчилан бэлтгэгдсэн банк. 2021 онд Банкны тухай хуульд орсон өөрчлөлтийн дагуу нээлттэй хувьцаат банк болох бэлтгэлээ хангаж, төлөвлөгөөгөө Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэн, баталгаажуулсан хэдий ч ХасБанкны хувьд 10-аад жилийн өмнөөс нээлттэй компани болох алсын хараа боловсруулан ажиллаж, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, засаглалын зарчмуудаа үүнд чиглүүлж ирсэн.



Найдвартай

Нэг хувьцаа эзэмшигч 20%-аас илүүгүй хувь эзэмших тухай хуулийн шаардлагыг одоогоор хангаж буй системийн хэмжээний цорын ганц банк бөгөөд энэ нь нэг иргэн эсвэл байгууллага давамгай шийдвэр гаргах боломжгүй, компанийн засаглал зөв, ил тод, үйл ажиллагаа явуулахад боловсронгуй хялбар байхад чиглэгдсэн.

ТУЗ-ийн даргын мэндчилгээ



Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахал хоёр дах жилдээ үргэлжилж, хүн бүрийн амьдрал ахуйд нөлөө үзүүлснээр өнгөрөгч 2021 он бас нэгэн сорилтын жил болж өнгөрлөө. Монгол Улс 2020 оны турш Ковид-19 цар тахлаас амжилттай сэргийлж чадсан бол 2021 он бид бүгдэд маш хүндээр туслаа.

Хэдийгээр Монгол Улс ард иргэдээ дархлаажуулалтад амжилттай хамруулж чадсан ч өнгөрсөн хугацаанд бид хэд хэдэн удаагийн хатуу хөл хорио, төрөл бүрийн хязгаарлалтад зохицож ажиллах шаардлагатай байлаа. Энэ бүх хорио цээрийн дэглэм харилцагч, ажилтнуудад маань, мөн нийгэмд бүхэлд нь сөрөг үр дагавар үлдээжээ. Энэ амаргүй цаг үед манай хамт олон харилцагчдын эрүүл мэнд, тэдний бизнесийн үр өгөөжийн төлөө өөрийн хүчин чармайлт, мэргэжлийн ур чадвараа дахин харуулж чадсан юм.

Бидний Ковид-19 цар тахлын улмаас эдийн засгийн хүндрэлтэй тулгарсан 8,000 орчим харилцагчдынхаа хэрэглээний зээл, бичил болон ЖДҮ-ийн зээл, орон сууцны зээлийн нөхцөлийг өөрчилж дэмжжээ.

2019 оны эхээр хэрэгжүүлж эхэлсэн стратегийг хүндхэн нөхцөл байдлын үед ч чанд баримталж чадсаны ачаар Банк 2021 онд бахархмаар амжилттай ажилласныг дуулгахад таатай байна. Сүүлийн гурван жил үйл ажиллагааны зардал болон зээлийн чанарт онцгой анхаарал хандуулж чадсанаар бидний цэвэр ашиг 2021 онд 75.3 тэрбум төгрөгт хүрч өөрийн хөрөнгийн өгөөж 24 хувь болж нэмэгдэв. Чанаргүй зээлийн эзлэх хэмжээ 4.5 хувьд хүрсний зэрэгцээ эрсдэл даах харьцааг бид 118.6 хувь болгон нэмэгдүүлээд байна.

Банкны банкны өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийн хэмжээг бууруулж чадсан төдийгүй эдгээрт тавигдах шаардлагыг ч чангатгах арга хэмжээг авсан. Олон жилийн хугацаанд хувьцаа эзэмшигчдэдээ олгоогүй явсан ногдол ашгийн хуваарилалтыг бид 2020 онд хийж чадлаа.

2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нэгдүгээр зэрэглэлийн хөрөнгийн харьцааг 17.4% болгосон нь салбартаа тэргүүлэгч болоод зогсохгүй Монголбанкны журамд заасан 9 хувиас 8.4 нэгж хувиар дээгүүр байна.

Санхүүгийн амжилттай үр дүнгээс гадна урт хугацааны стратегийн төлөвлөгөөнд тусгасны дагуу ХасБанк болон ХасЛизинг компаниудыг нэгтгэх, мөн дүрмийн сангийн хэмжээг 100 тэрбум төгрөг болгон нэмэгдүүлж, хоёр ч томоохон ажлын ард гарчээ.

Харилцагчдад банкны үйлчилгээг гар утсаараа илүү найдвартай, түргэн шуурхай хүргэх үүднээс өнгөрсөн жил бид Дижитал банкны шинэ платформыг нэвтрүүлсэн. Харилцагчдын маань 20 гаруй хувь тус шинэ платформыг хэрэглэж байгаа бөгөөд 5 сая гаруй гүйлгээ хийжээ. Харилцагчдад үзүүлэх үйлчилгээг улам илүү сайжруулахын тулд бид цаашид ч технологийн салбарт хөрөнгө оруулалт хийх болно.

Монгол Улсын иргэн бүрд ХасБанкны хувьцааг хөрөнгийн бирж дээр нээлттэй ил тод байдлаар худалдаж авах, ХасБанкны өсөлтийн өгөөжийг хүртэх боломжийг олгохоор зэхэж байна. Бид хувьцааг санал болгох ажлын хүрээнд Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байгаа бөгөөд цаашид цаг тухайд нь мэдээлэх болно.

Би хамт олноороо үнэхээр их бахархаж, тэдэнд талархаж байгаагаа энэ завшааныг ашиглан дахин илэрхийлж байна. 2022 он мөн л хүндхэн жил болно, тиймээс бидэнд тайвшрах эрх байхгүй.

Төгсгөлд нь, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд бидний дундаршгүй эрч хүчний эх үүсвэр болж, байнга дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ удирдлагаар ханган ажиллаж байдаг хувьцаа эзэмшигчдэдээ талархлаа илэрхийлж байна.

Санжай Гүпта
ТУЗ-ийн дарга

Гүйцэтгэх захирлын мэндчилгээ



Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид, харилцагч, хамтрагч нараа,

Сүүлийн 20 жилийн хугацаанд бидэнд тулгарсан хамгийн их сорилт бэрхшээлтэй цаг үед сэтгэл харамгүй дэмжсэн Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТУЗ)-ийн дарга ноён Санжай Гупта, ТУЗ-ийн гишүүд болон хувьцаа эзэмшигчдэдээ дахин талархал илэрхийлж энэхүү захидлаа эхэлье. 2020 оныг хүндхэн жил гэж байсан бол 2021 оны хувьд өмнөхөөсөө ч илүү сорилттой байлаа.

Түүнчлэн удирдлагын багтаа, ХасБанк болон Тэнгэр Санхүүгийн нэгдлийн нийт 1,500 ажиллагсадаа онцгой талархал илэрхийлэхийг хүсэж байна. Тэд туйлын таатай бус нөхцөл байдалд бүх хүч чармайлтаа гаргаж харилцагчдаа үйлчилсэн. 2021 онд хэд хэдэн удаагийн “тэг” зогсолт, хөл хорио тогтооход Хасчууд маань харилцагчдаа банкны үйлчилгээг тасралтгүй хүргэсээр байсан нь бахархуштай.

Энэхүү захидалдаа КОВИД-19 цар тахлын үед бидэнд тулгарсан сорилтууд болон Банкны тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтөөр банк нь олон нийтэд нээлттэй компани болох шаардлагыг хэрэгжүүлэх бэлтгэл ажлуудтай холбоотой сорилтуудын талаар дурдъя. Түүнчлэн стратегийн гол гол санаачилгууд, тэдгээрийн хэрэгжилт болон харилцагчид, ажилтнуудаа хамгаалах арга хэмжээнүүдийн талаар бодлоо хуваалцъя. Мөн нээлттэй хувьцаат компани болох бидний дараагийн аялалд бэлтгэх явцад 2022 оны төсөөллийг та бүхэнтэй хуваалцъя.

ХасБанкны 20 жил: Даруухан, Бахархам Эхлэл

Хорин жилийн өмнө ХасБанк нь нэг сая ам.долларын хөрөнгөтэй НҮБ-ын төслөөс гараагаа эхэлсэн. Харин 2021 оны эцсийн байдлаар 3.5 их наяд төгрөгийн хөрөнгө бүхий системийн банк болон тэлж, цэвэр ашиг 75.3 тэрбум төгрөг, өөрийн хөрөнгийн өгөөж 20 гаруй хувьтай байна. Бид орон даяар 70 гаруй салбартай бөгөөд хүмүүс гар утаснаасаа банкны сүлжээнд нэвтрэх боломжийг бүрдүүлсэн цахим сувгуудаар нийт нэг сая гаруй харилцагчид үйлчилгээ үзүүлж байна.

2021 оны 4 дүгээр улиралд бид банкныхаа 20 жилийн ойг тэмдэглэж, олон жил ХасБанкны ололт амжилтыг хамтран бүтээлцэж өөрийн хувь нэмрийг оруулсан ажилтнууддаа хүндэтгэл үзүүлсэн. Мөн 2021 оны 12 дугаар сард харилцагч нартаа талархал илэрхийлэх хүлээн авалт зохион байгуулах завшаан бидэнд тохиосон юм.

Энэхүү боломжийг ашиглан ТУЗ-ийн дарга асан ноён Ч.Ганболд, Гүйцэтгэх захирал асан ноён Ч.Ганхуяг, М.Болдоо, Ч.Бат-Очир нарт хүчирхэг манлайлал, өнгөрсөн 20 жилийн түүхэн он жилүүдэд ХасБанкны ололт амжилтад үнэлшгүй чухал хувь нэмэр оруулсанд талархлаа илэрхийлье.

Тодорхой бус байдал үргэлжилсээр: КОВИД 19-ийн хямрал, Харилцагч, Ажилтнуудаа хамгаалах нь

2019 оны эхнээс бидний баримталж эхэлсэн стратеги зөв зүйтэй болох нь дахин харагдаж байна. 2019 онд хүрсэн амжилтаа 2020 онд ч үргэлжлүүлэх эрч хүчийг бид мэдэрсэн. Стратегийн өөрчлөлтийн үр нөлөө 2021 онд илүү тод болж, бид өмнө нь хүрч байгаагүй санхүүгийн гайхалтай үр дүнд хүрлээ.

Дэлхий нийтийг хамарсан тахал эрүүл мэндийн хямралаар эхэлсэн хэдий ч удалгүй эдийн засаг, улмаар нийгмийн хямрал болсон нь дижитал өөрчлөлтийг хурдасгаж түлхэц болсон. КОВИД 19-ийн эсрэг вакцин нэвтрүүлснээр энэ нь амьдралын шинэ хэв маяг болж байна.

2021 онд орон нутагт КОВИД-19 дэгдэж Монгол Улсын Засгийн газраас урьдчилан сэргийлэх шуурхай арга хэмжээ авч улсын хил болон сургууль, олон нийтийг хамарсан арга хэмжээ, аж ахуйн нэгжүүдийг хааж, хатуу хорио цээрийн дэглэм тогтоосон.

Дотооддоо хорио цээр болон хилийн хорио тогтоосон нь бизнес эрхлэгчдэд том сорилт болж орлогыг нь бууруулсан төдийгүй, зарим тохиолдолд огт орлогогүй болгож байв. Иргэд ажилгүй болж, богиносгосон цагаар ажилласан заримынх нь сарын орлого мэдэгдэхүйц буурч байв. Тэд ипотека болон бусад зээлээ төлж чадахгүйд хүрсэн. Ийм хүнд хэцүү үед харилцагчдаа дэмжихийн тулд бид шуурхай арга хэмжээнүүд авч хэрэгжүүлсэн. Эдийн засгаа сэргээх, ажлын байрыг хадгалахад дэмжлэг үзүүлэх Засгийн газраас хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдэд банк идэвхтэй оролцсон.

Банкны хувьд бид нэлээд сорилттой тулгарсан. Нэгд, хөл хорионы үеэр банкнууд нийтэд нээлттэй байх ёстой тул бид өөрсдийн ажиллагсад болон үйлчлүүлэгчдийнхээ эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах ёстой байв. Банкны салбар болон төв байрандаа аюулгүй байдлын дэг журмыг хатуу мөрдөж эхэлсэн. Үүнд хүн хоорондын зай баримтлах, барилга байгууламжид тогтмол давтамжтай ариутгал хийх, амны хаалт заавал зүүх, биеийн халуун хэмжих, гар ариутгах, мөн ажилтнуудад өвчтэй байсан өдрүүдэд нь цалин олгох зэрэг болно. Мөн төв оффисын ихэнх ажиллагсад болон зарим салбарын ажилтнуудад гэрээсээ ажиллах зохицуулалт хийсэн. Бид үйл ажиллагаагаа хурдан жигдрүүлж бизнесийн тасралтгүй байдлыг түргэн шуурхай хангахад бүх хүчээ дайчилж ажилласан хамт олноороо би бахархаж байна.

Хоёрт, Монголбанкны КОВИД 19-ийн нөхцөлд бүтцийн өөрчлөлтийн удирдамжийн дагуу бид цар тахалд нэрвэгдсэн харилцагчдынхаа зээлийн нөхцөлийг цаг тухайд нь өөрчлөхөд анхаарсаар ирсэн. Манай багийн зүгээс харилцагчдын зээлийн нөхцөл өөрчлөх хүсэлтийг цахимаар хурдан шуурхай хүлээн авах зохицуулалт хийж нийт салбар, тооцооны төвүүд, харилцагчийн үйлчилгээний төв болон төв албаны ажилтнууд зээлийн бүтцийг өөрчлөхөөр илүү цагаар болон амралтын өдрүүдэд ажилласан. Хүнд хэцүү үед ажилдаа үнэнч байж, хэрэгцээ шаардлага гарсан үед нь харилцагчдаа үйлчлэх үүргээ ямагт эрхэмлэдэг бүх ажилтнууддаа талархал илэрхийлье.

Гуравт, арилжааны банкнуудын хувь эзэмшлийн бүтэц болон IPO-той холбоотой банкны шинэ хууль батлагдахын өмнө ХасБанкийг өөрийн байр суурь бүхий хөрөнгөтэй, эрүүл ашигтай, нөөц сантай, дижитал технологид оруулсан хөрөнгө оруулалттай, хувьцаа эзэмшигчдэдээ өндөр өгөөжтэй, тогтвортой ногдол ашигтай байхаар зорьж байна.

Дөрөвт, стратегийн чухал үе шатуудыг тэмдэглэхэд бид компанийн бүтцийн өөрчлөлтийн хүрээнд ХасЛизинг компанийг ХасБанктай амжилттай нэгтгэлээ. Энэхүү нэгдэл нь хамтын хүчин чармайлтыг сайжруулж, лизингийн үйл ажиллагааны санхүүжилтийн зардлыг бууруулж, хөрөнгө өсгөх боломж олгоно. Ингэхдээ ХасЛизинг брэндийн лизингийн бизнес шугам хэвээр үлдэнэ.

Эцэст нь, банкны удирдлага болон ТУЗ-ийн зүгээс 2022 оны 7 дугаар сарын 01-ний дотор IPO гаргах төлөвлөгөөг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороонд өргөн барьсан. Энэхүү ажлын хүрээнд өнгөрсөн онд компанийн бүтцийн хэд хэдэн өөрчлөлтийг амжилттай хийж 2022 оны 6-р сарын 30-ны өдрийг хүртэл IPO хийх тухай хуулийн шаардлагыг хэрэгжүүлж энэхүү үйл явцыг албан ёсоор эхлүүлсэн.

Гүйцэтгэх захирлын мэндчилгээ

➤ 2019-2021 оны тойм стратеги: Бүтээмжийг сайжруулах нь

2019 оны стратегийн үзэл баримтлалд бид дараах тулгуур асуудлуудад түлхүү анхаарсан.

1. Банкны үндсэн зарчмуудыг баримтлах. ХасБанкны үндэс суурийг бататгахын зэрэгцээ цаашид өсөж хөгжих өөрсдийн байр суурийг тодорхойлох нь бидний 2019 оны гол асуудал байв. Санхүүгийн хатуу чанд сахилга, хяналттай эрсдэлтэйгээр ашигтай ажиллах нь бидний өсөлтийн зорилго байв.
2. Бид хуримтлагдсан ашгаараа нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийг органикаар нэмэгдүүлснээр зохицуулах байгууллагаас тогтоосон хөрөнгө удирдах шинэ удирдамжийг мөрдөхийг зорьсон. Хувьцаа эзэмшигчдээс нэмэлт хөрөнгө татахгүйгээр нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн доод шинэ шаардлагыг дагаж мөрдөх.
3. Зээлийн чанарт анхаарч, хангалттай нөөцөөр хангах. Энэ зорилтыг хэрэгжүүлэхийн тулд бид үйл ажиллагааны ашгаа дорвитой нэмэгдүүлэх шаардлагатай болсон. Дэлхий нийтийг хамарсан цар тахлын улмаас бид КОВИД 19-ийн нөлөөлөлд өртсөн зээлүүдэд эрсдэлийн нөөц сан байгуулах шаардлага үүссэн.
4. Хувьцаа эзэмшигчдэд хүртээх үнэ цэнийг сайжруулж, өөрийн хөрөнгийн өгөөжийг 20 хувиас дээш хэмжээнд байлгах. Өөрийн хөрөнгийн өгөөж хамгийн багадаа 20 хувьтай байлгахын тулд бид нэгд, пассивын зохистой удирдлагад анхаарч цэвэр хүүгийн орлого (2.7%)-ыг өмнөх түвшинд нь хүргэж сэргээх шаардлагатай болсон, хоёрт, Банкны үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлж зардал орлогын харьцаа (83.9%)-г 50-иас доош хувь болгон сайжруулахын тулд санхүүгийн хатуу сахилга баттай бодлого баримталсан.
5. Цахим өөрчлөлтийг хурдасгаж, мэдээллийн технологийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх. Олон жилээр сунжруулсан мэдээллийн технологийн асуудлуудыг шийдвэрлэх том даалгавар бидэнд байсан: Мэдээллийн технологийн зардал нэмэгдэж, иргэдийн зээл өрсөлдөх чадваргүй болсоор байв. Мэдээллийн технологийн давуу талыг ашиглах нь иргэдийн зээлийг нэмэгдүүлэх гол тулгуур юм. Цахим өөрчлөлтийг хурдасгах нь банканд богино хугацаанд чухал үүрэгтэй төдийгүй мөн урт хугацааны ирээдүйд зайлшгүй хэрэгтэй. Энэ зорилтыг биелүүлэхийн тулд бид цахимжуулах, автоматжуулах санаачилгад анхаарлаа хандуулсан. Бидний эхлүүлсэн цахим өөрчлөлтийн гол төслүүдэд банкны үндсэн системийн өөрчлөлт, мобайл банкны шинэ платформ нэвтрүүлэх, зээл олгох, зээл ангилах төрөл бүрийн үнэлгээний хэрэгслийг бий болгох, чухал процессуудыг автоматжуулах зэрэг багтсан.
6. Ногоон Уур амьсгалын сангаас (GCF) магадлан итгэмжлэгдсэн банкны хувьд иргэд, бизнес эрхлэгчдэд зориулсан зээлийн хөтөлбөрөөр дамжуулан уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, нөлөөг сааруулах санаачилгыг дэмжих амлалтаа үргэлжлүүлэх.

Бүтээмжийг сайжруулах нь. Стратегийн хэрэгжилтийн үр дүнд бид 2021 онд санхүүгийн болон үйл ажиллагааны өндөр үр дүнд хүрснийг дуулгахад таатай байна.

ХасБанк 75.3 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, өөрийн хөрөнгийн өгөөж 23 хувьд хүрсэн нь зорилтот сегментүүдийн тогтвортой өсөлт, эрсдэлийн ухаалаг удирдлага, зардлын бүтцийг сайжруулсан, хөрөнгийн үр ашигтай зарцуулалттай холбоотой.

Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт 17.4 хувьд хүрсэн нь зохицуулах байгууллагын тавьж буй хөрөнгийн шаардлагаас 490 суурь нэгжээр илүү байгаа нь биднийг цаашдын өсөлтөд хүчирхэг болгож байна. Эрсдэлийн удирдлага, зээлийн андеррайтерын бодлого, журмыг сайжруулахад үлэмж их нөөцийг зарцуулж, чанаргүй зээл болон Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө (ӨБҮХХ)-ийг идэвхтэй удирдсанаар чанаргүй зээл 4.4 хувьд барьж чадсан. Мөн чанаргүй зээл болон ӨБҮХХ-ийн нөөцийн сан 118.6 хувьтай байв.

Бид гадаадын өндөр үнэтэй ам.долларын эх үүсвэрийг эргүүлэн төлж, эрсдэлээс хамгаалагдаагүй валютын нийт эрсдэлийг бууруулах замаар өр төлбөрийн бүтцийг улам оновчтой болгож актив пассиваа удирдах арга барилаа сайжруулсаар байна. Үүний үр дүнд хүүгийн цэвэр орлого 5.3 хувь болсон.

Сүүлийн хэдэн жилийн хугацаанд бид үйл ажиллагааны суурь зардлыг сайтар судалж, зардал хэмнэх хэд хэдэн санаачилга гаргасан. Зардлын бүтцийг тогтмол дүнгээр бус, хувьсах хэмжигдэхүүн болгон өөрчилснөөр зардал орлогын харьцаа өнгөрсөн жил 49.9 хувь байсан бол 42 хувь болж сайжирсан.

Манай тайлан тэнцлийн бүтэц, санхүүгийн болон үйл ажиллагааны загварууд нь бидний цаашдын өсөлтийн тулгуур болно гэдэгт удирдлагын баг итгэлтэй байна.

➤ Бидний сургамж, хуримтлуулсан туршлага

Бэлтгэлтэй бай. Сүүлийн хэдэн жилийн туршлагаас бид “Гэнэтийн том зүйлд хэзээд бэлэн байх” гэсэн дүгнэлт хийсэн. 2019-2021 оны стратегийг хэрэгжүүлэх явцад Стратеги нь бидний хийхийг зорьсон эсвэл төлөвлөсөн зүйл гэхээс илүүтэйгээр бодитойгоор эрэмбэлж, гүйцэтгэх тухай юм гэдэгт суралцсан. Банкны шинэчлэл, хөрөнгө удирдах шинэ удирдамж, КОВИД-19 зэрэг шинээр үүссэн нөхцөлд бид хэд хэдэн удаа стратегиа өөрчлөх шаардлагатай болсон. Шинэ бүтээн байгуулалт, гэнэтийн зүйлтэй тулгарч стратегиа өөрчилсөн ч ХасБанкныхаа зорилго, хэрэгжүүлэх гэж буй урт хугацааны зорилтуудаа бид мартаагүй. Энэ бол амжилтад хүрэх нууц жор гэдэгт би итгэлтэй байна.

Стратеги болон яаралтай асуудлын уялдаа. Сүүлийн гурван жилийн бидний амжилтын шалтгаан нь манай Хувьцаа эзэмшигчид, ТУЗ, Удирдлагын зүгээс компанийн алсын хараа, стратегийн уялдаа холбоо юм. Олон нийтэд хувьцаа арилжаалж бизнесийн шинэ мөчлөгт орж байгаа энэ үед шинэ стратегийн уялдаа холбоог үргэлжлүүлэх нь нэн чухал юм.

Бизнес бол орчин үеийн дайн гэдэгтэй хэн нэгэн маргаж болох юм. Бид хамтдаа өөрсдийн зорилгыг “дайнд ялах” гэж тодорхойлсон тул эдгээр зорилгодоо хүрэхийн тулд өөрсдийн бүхий л хүч чадал, чадавхыг ашиглах ёстой байв. Бид стратегиа боловсруулж хэрэгжүүлэхдээ энэ бол үхэл амьдралын асуудал юм гэж хандсан. Ирээдүй рүү хийх бидний аялал эрчтэй, хойшлуулшгүй байх болно.

Цаг үеэ олсон шийдвэрүүд. Ирээдүйн тухай бидний мэтгэлцээнүүд салбарын хөгжлийн хандлагыг төдийлөн авч үзээгүй. Эдүгээ бараг хүн бүр санхүүгийн үйлчилгээний салбарын хамгийн сүүлийн үеийн чиг хандлагын талаар тодорхой ойлголттой гэдэгт бид итгэдэг. Бидний үзэж байгаагаар стратегийг хэрэгжүүлэх цаг хугацааны талаар, цагаа олсон шийдвэр гаргах тухай бид мэтгэлцэх ёстой. ХасБанкны амжилтад туйлын чухал зүйл бол бид цаг алдалгүйгээр стратегиа хэрэгжүүлэх шаардлага юм.

➤ Дижитал өөрчлөлт

КОВИД-19 тахал нь зөвхөн банкнууд төдийгүй бүх салбарын дижитал өөрчлөлтийг хурдасгав. Үйлчлүүлэгчдийн хувьд гар утсыг юуны түрүүнд сонгох болсноор компаниудад хурдан шуурхай бөгөөд харилцагчдад ээлтэй үйлчилгээг санал болгох шахалтыг бий болгосон. Ихэвчлэн КОВИД 19-өөс шалтгаалж саатсан бидний удаан хүлээсэн Дижитал банкны шинэ платформ зах зээлд нэвтэрсэн. Одоо иргэдийн хувьд банкны салбараар зочлохгүйгээр манай дижитал банкны платформыг ашиглан санхүүгийн ихэнх үйлчилгээг авах боломжтой болсон бөгөөд нийт гүйлгээний 95 гаруй хувь нь дижитал сувгаар дамжин хийгдэж байна.

Өнгөрсөн нэг жилийн хугацаанд бид дижитал банкны идэвхтэй хэрэглэгчдийнхээ тоог 50 хувиар нэмэгдүүлсэн. Дижитал банк, картын гүйлгээний тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 96 хувь, картын гүйлгээ 65 хувиар тус тус өссөн байна. Дижитал банкны платформд шинэ боломжуудыг үргэлжлүүлэн нэвтрүүлснээр бид дижитал банкны идэвхтэй харилцагчид болон дижитал гүйлгээний тоо ирэх жилүүдэд улам нэмэгдэнэ гэж найдаж байна.

Бид дижитал өөрчлөлтийн нэг хэсэг болгон банкны үндсэн системээ (CBS) шилжүүлэх стратегийн шийдвэр гаргасан. Шинэ CBS нь технологийн хурдан өөрчлөлтөд дасан зохицох чадвартай, тогтвортой, уян хатан арын системээр хангана. Манай CBS төслийн баг уг системийг хэрэгжүүлэхийн тулд хичээнгүйлэн ажилласан бөгөөд 2022 оны сүүлийн хагаст шилжүүлж дуусгахаар төлөвлөж байна.

Төрөл бүрийн платформуудтай тасралтгүй түншлэл байгуулахад анхаарлаа төвлөрүүлэх нь чухал бөгөөд бид системээ API-ээр дамжуулан гуравдагч талын үйлчилгээ үзүүлэгчидтэй холбох болно. Бид мобайл банкны программаа тасралтгүй сайжруулж, эцсийн боловсруулалтыг дэмжихийн тулд зээлийн оноо, баримт бичгийн менежмент, аналитик платформуор зээл олгох үйл явцаа эрс шинэчилж байх болно. Дижиталчлалын эрин зуунд үйлчлүүлэгчдийнхээ итгэлийг хангахын тулд өгөгдөл, кибер аюулгүй байдалд тасралтгүй хөрөнгө оруулалт хийх шаардлагатай байна.

Технологийн хурдацтай өөрчлөгдөж буй ертөнцөд дижитал шилжилт нь байнга хийж байх ёстой тасралтгүй үйл явц гэдгийг бид бүрэн ойлгож байгаа бөгөөд ирэх жилүүдэд ХасБанкийг илүү дижитал болгох зорилт тавин ажиллаж байна.

➤ Төлөв

Урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал, тогтвортой, найдвартай үйл ажиллагаатай банк гэдгээрээ бид зах зээлд нэр хүндтэй. Манай нэр хүндтэй хувьцаа эзэмшигчид ХасБанканд зөвхөн хөрөнгө оруулаад зогсохгүй “ноу-хау”, техникийн туслалцаа, олон улсын шилдэг туршлагыг нэвтрүүлэх замаар оюуны өмчид хөрөнгө оруулалт хийдэг.








Банкны тухай шинэ хуультай нийцүүлэн 2022 оны 6-р сард IPO хийхээр бэлтгэж байгаа энэ үед бид шинэ аяллынхаа гарааны өмнө байна. Нээлттэй хувьцаат компанийн хувьд бид банкны өсөлтийг удирдах, хөрөнгийн зах зээл болон хөрөнгө оруулагчдын хүлээлтийг удирдах Зэрэгцээ ертөнцөд “амьдрах” болно. ХасБанкны хувьд IPO амжилттай хийх нь маш чухал юм.

Бид байгууллагын хувьд өсөлтийг хэрхэн ашигтайгаар бий болгох талаар суралцаж, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийг органик байдлаар бий болгох бизнесийн загварыг бий болгосон. Түүнчлэн, манай баг хамт олон бэрхшээлийг даван туулж, шинэ дүрэм журам, КОВИД-19 дэлхийн цар тахал зэрэг гэнэтийн зүйлд бэлэн байж сурсан. Олон нийтэд нээлттэй компанийн хувьд бид харилцагчид болон түншүүддээ үнэ цэнийг хүргэх, ажилтнууддаа анхаарал халамж тавих, хувьцааны өндөр үзүүлэлтийг хангаж, тогтвортой ногдол ашигтай ажиллаж, хувьцааны үнийг дээд түвшинд хүргэхийн тулд бүхий л хүч чармайлгаа зориулах болно.

Гүмэнжавын Цэвэгжав (ТJ)

Гүйцэтгэх захирал

Санхүүгийн гүйцэтгэл



20 жилийн онцлох үйл явдлууд

2001

2001.12.27-нд ХасБанк арилжааны банкны зөвшөөрлөө авав.

**2002**

МУ-д анх удаа хүүхдэд зориулсан Ирээдүйн саятан хадгаламжийг нэвтрүүлээ.

2003

400 гаруй ажилтандаа хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр, тэтгэвэрийн нэрийн дансны үйлчилгээг нэвтрүүлээ.

2004

Хасын хүлэгүүд сагсан бөмбөгийн багийг байгуулж, тасралтгүй 18 жил дэмжив. Тус баг энэ жил 7 дахь удаагаа лигийн аварга болсон.

2006

Монголд анх удаа бүрэн интерактив ажиллагаатай 1888 дуудлагын төвийг байгуулав.

Заалны хөлбөмбөгийн “Дуулиан-2020” тэмцээнийг санаачлан зохион байгуулж эхэллээ.

2014

АХБ-аас 30 сая ам.доллар, ОПЕС-ийн Олон Улсын Хөгжлийн Сангаас 20 сая ам.долларын санхүүжилтүүд амжилттай татав.

Банкны үндсэн системээ амжилттай шинэчилж, Flexcube системрүү шилжлээ.

2013

Хүлэмжийн хийг бууруулах бизнесийн зээлийн хөтөлбөрийг эхлүүлэв. Энэ хугацаанд 2.1 сая тонн хүлэмжийн хийн ялгарлыг буурууллаа.

Мэдээллийн аюулгүй байдлын олон улсын ISO 27001 стандартыг Банкны салбартаа анх удаа нэвтрүүлээ.

2012

1 сая ам.долларын хөрөнгөтэй эхэлсэн төсөл 1 тэрбум ам.долларын активтай системийн 4 дэх том банк боллоо.

**2011**

Микро Энержи кредит байгууллагаас хүлэмжийн хий бууруулсны нөхөн төлбөр авсан анхны банк боллоо.

**2010**

Эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн нийлүүлж, агаарын бохирдлыг бууруулах зорилгоор эко зээл олгож эхэллээ.

**2009**

Хүүхэд залууст санхүүгийн боловсрол олгох тэмүүлэл, Афлатон хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж эхэлсэн нь өдгөө ЕБС-ийн хичээлд ороод байна.

АМАР Мобайл банкны үйлчилгээг зах зээлд нэвтрүүлж, гар утсаараа банкны үйлчилгээ авах боломжтой боллоо.

2015

Брэндийн шинэчлэлт хийж, харилцагч төвтэй үйлчилгээг үзүүлэн, насан туршийн банк байх зорилгыг тодорхойлов.

Төлбөрийн картан системээ бүрэн шинэчилж, Картын процессингийн төвийг байгууллаа.

Харилцагчийг хамгаалах зарчмуудыг хангасан МУ-ын анхны банк хэмээн үнэлэгдэж, батламж авлаа.

**2016**

ОУ-ын стандартын Tier 2 шаардлагыг хангасан дата төвийг байгууллаа.

НҮБ-ын Уур амьсгалын ногоон сангаас магадлан итгэмжлэгдсэн Үндэсний Хэрэгжүүлэгч Байгууллага боллоо.

IFC, FMO зэрэг 8 байгууллагаас 108.5 сая ам.долларын санхүүжилт татсан нь тухайн үедээ арилжааны нэг банканд олгогдсон хамгийн том синдикат санхүүжилт болж байв.

2017

Төлбөрийн картан мэдээллийн аюулгүй байдлын PCI DSS стандартын шаардлагыг бүрэн хангалаа.



АТМ-ийн бүх үйлчилгээ болон интернэт банкаар ХасБанкны данс хооронд хийх гүйлгээний шимтгэлүүдийг тэглэлээ.

Уур амьсгалын ногоон сангаас 20 сая ам.долларын эх үүсвэр татаж сэргээгдэх эрчим хүчний төслүүдийг санхүүжүүлэв.

**2018**

Арилжааны банкнуудад хийгдсэн Активын чанарын үнэлгээнд ХасБанк хамгийн сайн гүйцэтгэл үзүүлээ.

EBRD-аас 40 сая ам.доллар, GCF-ээс 17.6 сая ам.долларын санхүүжилт авлаа.

Технологид суурилсан санхүүгийн үйлчилгээ үзүүлэх бизнесүүдийг дэмжин, нээлттэйгээр хамтран ажиллаж эхэллээ.

**2019**

ХасБанк, УАНС-ийн эх үүсвэрээр санхүүжүүлсэн 10 мегаваттын Нарны цахилгаан станц Говьсүмбэр аймагт ашиглалтад орлоо.



IFC-аас 65 сая ам.доллар, ADB-аас 30 сая ам.долларын санхүүжилт татлаа.

2020

Ковид 19-ын улмаас зээлийн эргэн төлөлтөд нь хүндрэл учирсан харилцагчдынхаа зээлийн гэрээний нөхцөлд өөрчлөлт орууллаа.

Нидерландын Хөгжлийн Агентлагаас 100 сая ам.долларын хамтын санхүүжилт авлаа.



Хувьцаа

ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

ХасБанк нь банк санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг томоохон компаниудын нэг болох ТэнГэр Санхүүгийн Нэгдэл /ТСН/ ХХК-ийн бүрэн эзэмшлийн охин компани юм.

ТСН ХХК нь олон улсын санхүүгийн байгууллагууд, дотоодын болон гадаадын нэр хүндтэй компаниуд, хөрөнгө оруулалтын сангууд, төрийн бус байгууллагууд болон хувь хүмүүсээс бүрдсэн хувьцаа эзэмшигчидтэй ба одоогоор Монгол Улсын банк, санхүүгийн салбарт ийм олон талын хувьцаа эзэмшигчдийн бүтэцтэй цорын ганц компани юм.

20.00%	МОНГОЛЫН АЛТ (МАК) ХХК	
17.171 %	ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН КОРПОРАЦИ (IFC)	
16.812 %	ОРИКС (ORIX) КОРПОРАЦИ	
12.905 %	ЕВРОПЫН СЭРГЭЭН БОСГОЛТ ХӨГЖЛИЙН БАНК (EBRD)	
10.516 %	КАНАДЫН ҮНДЭСНИЙ БАНК (NBC)	
10.150 %	РОНОК ПАРТНЕРЗ KFT.	
6.625 %	МОНГОЛИЯ ФАЙНЕНШЛ СЕРВИСИЗ	
3.730 %	ТРИОДОС ФЭР ШЭР ФАНД	
1.593 %	НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ	
0.301 %	УЛААНБААТАР РОТАРИ КЛУБ	
0.102 %	МАГВАНЫ БОЛДОО	
0.093 %	ЧУЛУУНЫ ГАНБОЛД	

Төлөөлөн удирдах зөвлөл¹

(2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар)

ТУЗ-ийн дарга

Санжай Гүпта

ТУЗ-ийн дарга

ТУЗ-ийн гишүүд

Гүмэнжавын Цэвэгжав

ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал

Андрзеж Витак

ТУЗ-ийн гишүүн

Нямтайширийн Цэлмүүн

ТУЗ-ийн гишүүн

Морис Лам

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Баянсаны Уламбаяр

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Альбертус Браггинк

ТУЗ-ийн гишүүн

Майкл Мадден

ТУЗ-ийн гишүүн

Ив Жако

ТУЗ-ийн гишүүн


Нираж Вэдва

ТУЗ-ийн хараат бус гишүүн

¹Жилийн тайлангийн 64-р хуудас дахь Зохистой засаглалын тайлангаас дэлгэрэнгүй мэдээллийг авна уу.


Хувьцаа

ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

- Тайлбар:
- Хувь хүмүүс
 - Улс орнуудын гишүүнчлэлтэй олон улсын санхүүгийн байгууллага. Монгол Улс 1991 онд гишүүн орон болсон, 2006 онд ОУСК-ийн Суурийн төлөөлөгчийн газар Монгол Улсад байгуулагдсан.
 - Нью Йорк, Токио-гийн хөрөнгийн бирж дээр арилжаалагддаг хувьцаат компани, нийтэд мэдээлсэн 2021 оны 9 дүгээр сарын 30-ны мэдээлэл.
 - Улс орнуудын гишүүнчлэлтэй олон улсын санхүүгийн байгууллага. Монгол Улс 2000 онд гишүүн орон болсон, 2006 онд ЕСБХБ-ны Суурийн төлөөлөгчийн газар Монгол Улсад байгуулагдсан.
 - Торонто-гийн хөрөнгийн бирж дээр арилжаалагддаг хувьцаат компани, нийтэд мэдээлсэн 2021 оны 10 дугаар сарын 31-ний мэдээлэл.
 - Enviar Capital Ltd. компани ЕСБХБ, ОУСК, ОРИКС, DEG, FMO, Obviam, Mitsubishi нарын хувийг авч, 2021 оны 11 дүгээр 12-ноос эзэмшиж эхэлсэн тухай мэдэгдсэн болно.
 - Амстердамын Euronext хөрөнгийн бирж дээр хэсэгчлэн арилжаалагддаг хамтын хөрөнгө оруулалтын сан. Сангийн кастодиан болох Triodos custody B.V. компанийн нэр Legal Owner Triodos Funds B.V. болон өөрчлөгдсөн.
 - 8 Монголын Төрийн бус байгууллага . ТУЗ-ийн даргыг Улсын бүртгэлийн газарт эцсийн өмчлөгчөөр бүртгүүлсэн байгаа гэж мэдэгдсэн.
 - Монголын Төрийн бус байгууллага. Эцсийн өмчлөгчөөр үүсгэн байгуулагч болох 5 хүнийг бүртгүүлсэн гэж мэдэгдсэн.



Гүйцэтгэх удирдлага

ТУЗ-ИЙН ДАРГЫН
МЭНДЧИЛГЭЭ



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
МЭНДЧИЛГЭЭ

ТОГТВОРТОЙ
ӨССӨН 20 ЖИЛ

ЭНЭ БОЛ
ЗӨВХӨН ЭХЛЭЛ

САНХҮҮГИЙН
ҮЗҮҮЛЭЛТ

АУДИТЛАГДСАН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН



Олон улсын үнэлгээ

2021 онд ХасБанкны үнэлгээний агентлагууд болох Мүүдиз болон Фитч Рейтинг үнэлгээ хийж, ХасБанкны гадаад зээлжих зэрэглэлийг баталгаажууллаа. Ковид-19 цар тахал болон олон нийтийн дунд банк, санхүүгийн системд томоохон шинэчлэл дагуулахаар хүлээгдэж буй Монгол Улсын Банкны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр тодорхойлогдсон тус жил банкны зүгээс үнэлгээний агентлагуудтай идэвхтэй хамтран ажиллаж, ажил хэрэгчээр харилцаж ирлээ.

СҮҮЛИЙН ҮЕИЙН ЯВЦЫН МЭДЭЭЛЭЛ:

- 2021 оны 9 дүгээр сард** Мүүдиз агентлагаас ХасБанкны хандлага сөрөг байсныг макро эдийн засгийн төлөв сайжирсан болон тус банкны зээлийн эрсдэлээс хамгаалах нөөц өндөр түвшинд байгаатай холбоотойгоор тогтвортой болгон сайжруулсан.

- 2021 оны 8 дугаар сард** Фитч Рейтинг агентлаг жил тутмын үнэлгээгээрээ манай банкны өмнөх зэрэглэл В болон ирээдүйн хандлагыг тогтвортой хэвээр хадгалсан.

Moody's

“Мүүдиз” олон улсын үнэлгээний байгууллага (www.moody.com) нь дэлхийн даяар бизнесийн болон төрийн байгууллагуудын санхүүгийн судалгаа, эрсдэлийг үнэлэх үйлчилгээ үзүүлдэг.

SEP 2021	
Оролцогч талын эрсдэлийн зэрэглэл – гадаад валют	B3/NP
Оролцогч талын эрсдэлийн зэрэглэл – төгрөг	B2/NP
Хадгаламж	B3/NP
Зээлийн суурь үнэлгээ	b3
Үнэт цаас гаргагчийн зэрэглэл	B3
Хандлага	Тогтвортой

FitchRatings

“Фитч” олон улсын үнэлгээний байгууллага (www.fitchratings.com) нь дэлхийн даяар бизнесийн болон төрийн байгууллагуудын санхүүгийн судалгаа, эрсдэлийг үнэлэх үйлчилгээ үзүүлдэг.

AUG 2021	
Гадаад валютын урт хугацаат үүргийг биелүүлэх зэрэг	B/Тогтвортой
Гадаад валютын богино хугацаат үүргийг биелүүлэх зэрэг	B
Төгрөгийн урт хугацаат үүргийг биелүүлэх зэрэг	B/Тогтвортой

Moody's

Урт хугацаат гадаад валютаар хүлээсэн үүргийг биелүүлэх зэрэглэл

FitchRatings

Урт хугацаат гадаад валютаар хүлээсэн үүргийг биелүүлэх зэрэглэл



ОУСК бол Дэлхийн банкны группийн гишүүн, хөгжиж буй зах зээл дэх хувийн хэвшлийг дэмжих зорилттой дэлхийн хамгийн том хөгжлийн чиглэл бүхий байгууллага юм. ОУСК-ийн гол зорилго нь хувийн хэвшилд зориулсан санхүүгийн эх үүсвэрийг дайчлах, ядууралд нэрвэгдсэн хүмүүст ажлын байр бий болгох бизнесийг дэмжих замаар ард иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх боломжийг бий болгох явдал юм. ОУСК нь ХасБанкны хувьцаа эзэмшигч юм.

KFW DEG

1962 онд байгуулагдсан DEG нь 2001 оноос хойш KfW группийн бүрэн эзэмшлийн охин компани бөгөөд хөгжиж буй зах зээл дээр зээл эсвэл өөрийн хөрөнгө хэлбэрээр урт хугацааны эх үүсвэрийг олгодог. DEG нь хөгжиж буй болон шилжилтийн үеийн орнуудад гарааны бизнес эрхлэх санаачилгыг дэмжиж, санхүүжүүлж ажилладаг. DEG нь өөрийн хөрөнгө оруулалтынхаа, тухайн улсын хэтийн хөгжлийн нөлөөнд ихээхэн анх холбогдол өгдөг ба урт хугацааны харилцааны туршид ХасБанкаар дамжуулан Монгол Улсын эдийн засагт ЖДҮ-ийн сегментийг санхүүжүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтыг бий болгосон.



Ногоон Уур амьсгалын Сан ("GCF") нь НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн хүрээний конвенцын хүрээнд 2010 онд байгуулагдсан сан юм. GCF нь хүлэмжийн хийн ялгарлыг хязгаарлаж, цаг уурын өөрчлөлтөд дасан зохицохыг, ирээдүйд уур амьсгалд тэсвэртэй хөгжлийн замыг бий болгох талаар улс орнуудыг дэмжиж ажилладаг. Санхүүжилтийг итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжүүдээр дамжуулан олгодог бөгөөд ХасБанк нь Монгол улс дахь магадлан итгэмжлэгдсэн арилжааны анхны банк юм.

PROPARCO

Proparco бол хувийн хэвшлийн хөгжилд чиглэсэн Францын Хөгжлийн Агентлагийн ("ФА") эзэмшдэг томоохон компани бөгөөд эдийн засаг, нийгэм, байгаль орчны тогтвортой хөгжлийг дэмжсэн гол чиглэл баримтладаг. PROPARCO нь дэлхийн 90 оронд үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд 500 гаруй үйлчилгээтэй, эдгээрт нь жижиг дунд бизнес эрхлэгчдээс бичил санхүүгийн байгууллагуудыг багтаасан бус нутгийн банкны байгууллагуудад орох бөгөөд 2019 онд ХасБанкны хамтын санхүүжилтээр татан төвлөрүүлсэн эх үүсвэрийг олгогчдын нэг юм.

incofin

Инкофин хөрөнгө оруулалтын удирдлагын компани (Инкофин ХӨМ) нь хөгжиж буй орнуудын бичил санхүүжилт олгодог бизнесүүдийг дэмждэг хөрөнгө оруулалтын сангуудад зөвлөгөө өгдөг байгууллага юм. Бичил санхүүгийн бизнесүүд нь банк тогтмол хүрч ажиллах боломжгүй хүмүүс, хувиараа бизнес эрхлэгч нарт зээл, хадгаламж, даатгалын зэрэг санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг. Бичил санхүүгийн чиглэл дотроо хөдөө орон нутгийн санхүүжилтэд мэргэшсэний хувьд Инкофин ХӨМ-ийн гол зорилго бол илүү алслагдмал орон нутагт амьдардаг, мөн хөдөө аж ахуйн салбарт идэвхтэй ажилладаг хүмүүст хүрч дэмжлэг үзүүлэх явдал юм. Инкофин ХӨМ 66 орны 300 гаруй байгууллагыг санхүүжүүлж, дэмжиж ажилладаг.

FRONTERA CAPITAL

Frontera Capital нь хилийн чанадад хөрөнгө оруулалт хийх зорилготой хөрөнгө оруулалтын компани юм. Frontera-г санхүүгийн өндөр туршлагатай мэргэжилтнүүдээс бүрдсэн үндсэн баг байгуулсан. Frontera нь дэлхийн хэмжээнд 125 оронд тогтмол орлогын зах зээлийн эрсдэлд тохируулсан өгөөж, валют, хугацаа, корпорацийн эрсдэлийн хөрөнгө оруулалтын хэтийн төлөвийг шалгаж, үнэлэх зорилгоор байгуулагдсан.

FMO

Нидерландын Хөгжлийн Санхүүгийн Компани ("FMO") нь Голландын засгийн газрын олонхын хувь эзэмшдэг турван А үнэлтээтэй, хөгжлийн банк юм. FMO нь гарааны бизнесийн хөгжлийг эдийн засгийн тогтвортой өсөлтийн түлхүүр бөгөөд улмаар ард түмний амьжиргааны түвшин сайжирна гэж үздэг. FMO-ийн үндсэн чиг үүрэг бол эрсдэлийн хөрөнгө оруулалтаа урт хугацааны төслүүдэд болон ирээдүйд нөлөө бүхий салбарт чиглэсэн урт хугацааны хөрөнгө оруулалт хийх явдал юм.

IBEC

Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны банк ("IBEC") нь 1963 онд байгуулагдсан олон улсын хөгжлийн санхүүгийн байгууллага юм. IBEC нь түүний гишүүн найман орны аж ахуйн нэгжүүдийн эдийн засгийн хөгжил, гадаад худалдааны харилцааг дэмжихэд чиглэдэг. IBEC нь экспорт импортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгжийг санхүүжүүлэх зорилгоор 100 сая ам.долларын хамтын ажиллагааны гэрээг байгуулсан байгаа.



ОПЕК-ийн Олон улсын хөгжлийн сан ("OFID") нь 1976 онд байгуулагдсан олон улсын хөгжлийн санхүүгийн байгууллага юм. OFID нь дэлхий даяар нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд дэмжлэг үзүүлэх зорилгоор төр, хувийн болон худалдааны салбарын санхүүжилтийг олгодог. 100 сая ам.долларын хамтын ажиллагааны санхүүжилтийн хэлэлцээрт, худалдааны санхүүжилтийг дэмжих эх үүсвэрийн гэрээг ХасБанктай байгуулсан.

SIFEM

Швейцарын хөрөнгө оруулалтын сан ("SIFEM") нь Швейцарын засгийн газрын 2005 онд байгуулагдсан хөгжиж буй орнуудыг дэмжих зорилттой санхүүгийн байгууллага юм. SIFEM нь ажлын байр бий болгож буй бизнес буй орнуудад санхүүжилт үзүүлэх замаар хөгжиж буй орнуудад урт хугацааны тогтвортой, хүртээмжтэй эдийн засгийн өсөлтийг бий болгодог. Тус санг 2016 оноос хойш ХасБанктай амжилттай хамтран ажиллаж, идэвхтэй харилцааг бий болгосон хөрөнгө оруулалтын мэргэшсэн зөвлөх Obviam удирддаг.

DEVELOPING WORLD MARKETS

Хөгжиж буй дэлхийн зах зээл ("DWM") нь АНУ-д суурилсан хөрөнгө оруулалтын удирдлагын компани бөгөөд эдийн засгийн тогтвортой хөгжлийг дэмжих чиглэлтэй зөвхөн хөгжиж буй зах зээлд хөрөнгө оруулалт хийдэг байгууллага юм. 1994 онд байгуулагдсан үүсгэн байгуулагчдын хувийн өмчлөлтэй ба Голланд, Герман, Япон гэх мэт олон улсын зах зээлээс өнөөг хүртэл 2 тэрбум гаруй ам.долларын санхүүжилтийг босгосон бөгөөд тэдгээрийн хөрөнгө оруулалтыг удирддаг.

BIO

BIO нь хөгжиж буй болон/эсвэл шинээр хөгжиж буй орнуудын хүчирхэг хувийн хэвшлийг дэмжиж, тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд өсөлт, тогтвортой хөгжилд хүрэх боломжийг олгодог хөгжлийн санхүүгийн байгууллага юм. BIO-ийн стратеги нь санхүүгийн салбар, аж ахуйн нэгж, дэд бүтцийн төслүүдэд төвлөрч, хөгжлийн үр нөлөөг оновчтой болгох, тогтвортой төслүүдийг дэмжих гэсэн гурван үндсэн зорилготой.

ADB

Азийн хөгжлийн банк ("АХБ") нь 1966 онд байгуулагдсан, 1991 оноос хойш Монгол Улсыг эгнээндээ багтаасан 68 гишүүн бүхий бус нутгийн хөгжлийн банк ба боловсрол, хүрээлэн буй орчин, дэд бүтэц, бус нутгийн хамтын ажиллагаа, санхүүгийн салбар гэсэн үндсэн чиглэлтэй үүсэж байсан бол хувийн хэвшлийн санхүүжилт сүүлийн 10 жилд ихээхэн хэмжээгээр өсөж, одоо үндсэн хөрөнгийн 20 орчим хувийг эзэлж байна.

European Bank for Reconstruction and Development

Европын сэргээн босголт, хөгжлийн банк ("ЕСБХБ") нь олон улсын хөгжлийн хөрөнгө оруулалтын банк бөгөөд 1991 онд байгуулагдсан санхүүгийн байгууллага юм. Үндсэн чиг үүрэгтээ байгаль орчны хариуцлагыг багтаасан анхны олон улсын банк бөгөөд 40 хувийн санхүүжилтээ ногоон хөрөнгө оруулалтад зориулах хэтийн зорилтоо 2017 онд хүрчээ. ХасБанк болон ЕСБХБ-ны хоорондын урт хугацааны харилцаат хамтын ажиллагаанд хөрөнгө оруулалт, эх үүсвэр болон худалдааны санхүүжилт зэрэг багтана.



АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Санхүүгийн Корпораци ("DFC") хуучнаар OPIC) буюу Америкийн хөгжлийн банк нь 1971 оноос үүсэлтэй байгууллага юм. DFC нь хөгжиж буй дэлхийн өмнө тулгараад байгаа хамгийн хүнд сорилтуудын шийдлийг санхүүжүүлэх зорилгоор хувийн хэвшилтэй хамтран ажилладаг ба ажлын байр бий болгогч жижиг бизнес эрхлэгчид эмэгтэй гарааны бизнес эрхлэгчдийг дэмжиж ажилладаг. ХасБанк нь эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор 2017 онд DFC-с санхүүжилт авсан байна.

finnfund

Финландын аж үйлдвэрийн хамтын ажиллагааны сан ("FinnFund") нь Финландын төрийн болон хөрөнгийн зах зээлийн санхүүжилттэй хөгжлийн санхүүгийн компани юм. Finnfund нь эрсдэлийн хөрөнгө, урт хугацааны зээл, хөгжиж буй орнуудын хэрэгжүүлж буй төслүүдийн санхүүжилтийг олгож, улмаар тогтвортой хөгжлийг хангах төслийн хөрөнгө оруулалтынхаа бүх ашгийг ахин санхүүжилтээр эргэж олгох бодлого баримталдаг. Finnfund болон ХасБанктай харилцаагаа 2019 онд гүйцэтгэсэн хамтын санхүүжилтээр бэхжүүлж бататгасан байна.

sympiotics

Symbiotics бол хөгжиж буй орнуудын бичил, жижиг, дунд үйлдвэрлэл аж ахуй (БЖДҮ) болон дундаж болон түүнээс доош орлоготой өрхийг дэмжиж, санхүүжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг тэргүүлэгч хөрөнгө оруулалтын компани юм. Тус компани нь хөрөнгө оруулалтын цогц үйлчилгээний төвлөрлийг бий болгосон байдаг ба хувийн хэвшлийн эх үүсвэрийн удирдлага, зөвлөх үйлчилгээ зэргийг санал болгодог юм. Одоогийн байдлаар олон тооны эзлэдэгчдийг хамарсан 25 гаруй санг удирддаг.

Иргэдийн Банк

➤ Иргэдийн зээл

Бид харилцагчдаа орлогын төрлөөр нь сегментчилж бизнесийн орлоготой иргэд, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл, бизнесийн цар хүрээнд тохирсон санхүүгийн бүтээгдэхүүнүүд болох бизнесийн зээл, жижиг бизнесийн зээл, бичил зээлийг санал болгон ажиллахаас гадна орчин үеийн санхүүгийн хэрэгслүүд болох баталгаа, аккредитивын бүтээгдэхүүнүүдээр хамтран ажиллаж байна. Цалингийн орлоготой иргэдэд цалингийн зээл, худалдан авалтын зээл, кредит карт гэх мэт бүтээгдэхүүнүүдийг санал болгон борлуулж байна.

Тайлант онд иргэдийн зээлийн багц 25%-иар өсөж 1.3 их наяд төгрөгт хүрлээ. 2020 онтой харьцуулахад бизнесийн зээлийн багц 27.1%, хэрэглээний зээлийн багц 25.9%-иар тус тус өссөн байна. Иргэдийн нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн түвшинг 1.4%-р бууруулж, 4.5%-д хүргэсэн нь банкны салбарт тэргүүлэх үзүүлэлт юм.

Монгол Улсын засгийн газраас хэрэгжүүлсэн “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хүрээнд ХасБанк бизнес эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжүүдэд “Ажлын байрыг дэмжих 3%-ийн зээл” болон Монголбанкнаас хэрэгжүүлсэн “РЕПО санхүүжилтийн зээл”-үүдийг дэмжин оролцож нийт 3,127 харилцагчид 209 тэрбум төгрөгийн зээлийг олгож, 17 мянган ажлын байрыг хадгалж үлдэхэд хувь нэмрээ орууллаа.

МИК-ийн ипотекийн зээл олголтыг үргэлжлүүлж 2021 онд 50.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Монголбанкнаас хүлээн авч, нийт 1,175 харилцагчид 77.8 тэрбум төгрөгийн зээл олгов. Түүнчлэн цар тахлын хуультай уялдан гарсан Монголбанкны шийдвэрийн дагуу орон сууцны зээлийн гэрээнд өөрчлөлт оруулах харилцагчийн хүсэлтийг онлайнаар хүлээн авч нийт 5,991 зээлдэгчийн 281.2 тэрбум төгрөгийн зээлийн гэрээнд өөрчлөлт оруулснаар зээлийн дарамтыг бууруулж, өрхийн санхүүд дэмжлэг үзүүллээ.

Ковид цар тахал, халдвараас сэргийлэх хатуу хөл хорионы улмаас олон бизнес бэрхшээл сорилттой нүүр тулж, энэ нь ялангуяа хувиараа бизнес эрхлэгчдэд маш хүнд туссан. Хэдийгээр оны хоёрдугаар хагаст хөл хорио тавигдаж, нийгмийн харилцаа, бизнесийн үйл ажиллагаа сэргэж эхэлсэн ч олон мянган бизнес эрхлэгчдэд зайлшгүй санхүүгийн дэмжлэг хэрэгтэй байсан. Иймд ХасБанк тэдгээр хувиараа бизнес эрхлэгч харилцагчдаа бизнесээ сэргээхэд нь бодит дэмжлэг үзүүлэх зорилгоор “Бизнесээ сэргээж дахин эхлэхэд ХасБанк хамт” гэсэн уриатай аяныг зарлаж орон даяар хэрэгжүүлэн эргэлтийн хөрөнгийн зориулалттай, нэг жилийн хугацаатай, 10.8% хүүтэй 30 тэрбум төгрөгийн зээлийг 1,615 харилцагчид олголоо.

Үүнээс гадна ХасБанк нь харилцагчаа хамгаалах зарчим, нийгэмд хүлээсэн хариуцлагын хүрээнд ковидын хүндрэлд өртсөн 2,150 гаруй бизнес эрхлэгчийн хүсэлтийг цахимаар хүлээн авч, зээлийн гэрээний нөхцөлд өөрчлөлт оруулж хүнд үед бизнесийн хэвийн үйл ажиллагааг тасалдуулахгүй байхад дэмжлэг үзүүллээ.

Иргэдийн зээлийн багц
1.3 их наяд

▲ 25%

Чанаргүй зээл
4.5%

5,991 зээлдэгчийн
281.2 тэрбум

төгрөгийн Орон сууцны
зээлийн гэрээний
нөхцөлийг өөрчлөв.

Иргэдийн Банк



Харилцах, хадгаламж
2.23 их наяд
▲11.2%

Харилцах,
хадгаламж эзэмшигч
894,000
үүнээс 204,000 нь
хүүхдийн хадгаламж

Харилцах,
хадгаламжийн
7,000
данс цахимаар нээгдсэн

Харилцах, хадгаламж

Иргэдээс татсан харилцах, хадгаламжийн багц өмнөх оноос 11.2% буюу 225 тэрбум төгрөгөөр өсөж 2.2 их наяд төгрөгт, нийт харилцах, хадгаламж эзэмшигчийн тоо 894 мянгад хүрсний 204 мянган хадгаламж эзэмшигч нь улс орны ирээдүй болсон хүүхдүүд байна.

Тайлант хугацаанд засгийн газраас хэрэгжүүлсэн хөнгөлөлттэй зээл, төсөл хөтөлбөрүүд болон хүн бүрд 300 мянган төгрөг олгосон зэрэгтэй уялдан харилцагчдын харилцах дансаар хийгдэх төлбөр тооцоо нэмэгдэж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16%, хадгаламжийн данс 13%-иар тус тус өсжээ.

ХасБанк нь дижитал банкны шинэ хувилбарыг нэвтрүүлж бүх төрлийн харилцах, хадгаламжийн бүтээгдэхүүнийг зайнаас нээх боломжийг харилцагч нартаа олгож 7 мянган харилцагчийн харилцах, хадгаламжийн дансыг цахимаар нээлээ. Мөн хөрөнгө оруулагч иргэн, аж ахуй нэгж байгууллагууддаа зориулж Хувьцааны хуримтлал хадгаламжийн шинэ бүтээгдэхүүнийг нэвтрүүллээ.

Хугацаатай хадгаламж эзэмшигчдэд илүү таатай боломжийг санал болгож дижитал банкаар дамжуулан авдаг Хадгаламж барьцаалсан зээлийн дүнг 50 сая төгрөг болгон нэмэгдүүллээ.

Салбарын удирдлага

2021 онд Улаанбаатар хотод нийт 36, орон нутагт 42 салбар, нэгжээр банкны үйлчилгээг үзүүлэв.

Цар тахлын сорилттой цаг үед бид харилцагчдадаа банкны бүтээгдэхүүн үйлчилгээг тасралтгүй, хурдан шуурхай, найдвартай хүргэх дээр гол анхаарлаа хандуулж ажиллахын зэрэгцээ халдвар тархахаас сэргийлж салбар, тооцооны төвүүдэд тогтмол хугацаанд ариутгал, халдваргүйжүүлэлт хийж ажиллалаа.

Хатуу хөл хорионы үед салбар, нэгжүүд ажиллахгүй үед ажилтнуудаа зайнаас ажиллах боломжийг бүрдүүлж мөн Харилцагчийн үйлчилгээний төвийн нөөцийг нэмэгдүүлж, харилцагчийн төлбөр, тооцоо, санал, хүсэлтийг түргэн шуурхай шийдвэрлэж ажилласан.

Орон нутгийн салбар тооцооны төвүүдээр дамжуулан төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлж, дараах төсөл хөтөлбөрөөр хамтран ажиллаа. Үүнд:

- Увс аймгийн засаг даргын тамгын газартай хамтран аймаг, орон нутгийн иргэдийг зах зээлийн ханшаас доогуур үнэтэй махаар хангах зорилгоор мал, мах бэлтгэж, нөөцлөх үйлдвэр бүхий харилцагчдад 635 сая төгрөгийн хүүгийн хөнгөлөлттэй эргэлтийн хөрөнгийн зээл олгож хамтран ажиллав.
- Дорнод аймгийн Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг санхүүжүүлэх механизмыг бий болгох, санхүүгийн таатай орчныг төрийн байгууллагуудын оролцоотойгоор бүрдүүлэх, улмаар орон нутагт ажлын байр нэмэгдүүлэх, хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэх, эдийн засгийн өсөлтийг хангах чиглэлээр нийт 583 сая төгрөгийн зээлийг жилийн 12%-ийн хөнгөлөлттэй хүүтэйгээр олгов.



Улаанбаатар хот

HUB салбар	6
Салбар	29
Өргөтгөл	2



Орон нутаг

Салбар	39
Өргөтгөл	2

Нийт **78**

Бизнес Банк

Корпорейт
зээлийн багц
343 тэрбум
▲15%

Чанаргүй
зээлийн багц
5.5%
▼400bps

Бизнес банкны газар нь дэлхий нийтэд нүүрлэсэн Ковид-19 цар тахлын үед корпорейт харилцагчдынхаа хөрвөх чадварт анхаарч эргэлтийн хөрөнгийн болон хөрөнгө оруулалтын санхүүжилтийг үргэлжлүүлэн хийж, харилцагчдынхаа бизнесийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг дэмжиж ажиллалаа. Цар тахлын хүндрэлтэй энэ цаг үед бид харилцагчдынхаа өдөр тутмын банкны үйлчилгээг тасралтгүй ханган ажиллах үүднээс дижитал банкны үйлчилгээнд бүрэн шилжиж уян хатан үйлчилгээг үзүүлж чадсаны зэрэгцээгээр цар тахлын нөлөөгөөр санхүүгийн хүндрэлд орсон бизнес эрхлэгчдийнхээ зээлийн нөхцөлийг цаг алдалгүй өөрчилж тэдэнд санхүүгийн хүндрэлээс гарахад нь тусалцаа үзүүлэн ажиллалаа. Өнгөрөгч хугацаанд корпорейт харилцагч нар нь санхүүгийн бэрхшээлийг даван туулах чадвар илүү өндөртэй болохоо харуулсан бөгөөд 2021 оны эцсийн байдлаар корпорейт зээлийн багцын зөвхөн 11% нь нөхцөл өөрчилсөн байна.

Хэдийгээр бид цар тахлын нөлөөгөөр харилцагчидтайгаа дижитал сувгаар дамжуулан зайнаас ажилласан хэдий ч бэрхшээл биднийг харилцагчидтайгаа илүү өргөн хүрээнд хамтран ажиллаж харилцаагаа шинэ түвшинд гаргах боломжийг бий болгож өглөө. Ийнхүү хичээн ажилласны үр дүнд, 2021 онд корпорейт зээлийн багцыг 15%-аар өсгөж 343 тэрбум төгрөгт хүргэсэн, чанаргүй зээлийн багцыг 400 bps-ээр бууруулан 5.5 хувьд хүргэж багцын чанарыг сайжруулах зорилтдоо хүрч чадлаа. Сүүлийн жилүүдэд тасралтгүй хэрэгжүүлсэн ханшийн эрсдэлээс харилцагчийг хамгаалж гадаад валютын зээлийн багцыг бууруулах ажлыг харилцагчийг хамгаалах бодлогын хүрээнд үргэлжлүүлэн хийснээр гадаад валютын зээлийн багц 2021 онд 40%-аар буурсан байна.

Бизнес банк нь өөрийн өргөн корреспондент сүлжээгээр дамжуулан дотоод, гадаадын худалдааны санхүүжилтийн цогц шийдлүүдийг харилцагчдадаа санал болгодог. Худалдааны санхүүжилтийн бүтээгдэхүүнүүдээс банк нь импорт, экспортын аккредитив мөн тендэрийн баталгаанаас эхлэн төлбөрийн баталгаа хүртэлх

бүх төрлийн баталгаа гаргах үйлчилгээг санал болгож байна. ХасБанк нь хүнс болон үйлдвэрлэлээс эхлэн олон салбарт дэмжлэг үзүүлж ирснээрээ Монгол Улсын худалдаанд чухал хувь нэмэр оруулдаг байгууллага гэдгээрээ бахархдаг. Бизнес банкны худалдааны санхүүжилтийн шийдлүүдийн ачаар манай олон харилцагчийн кредит үнэлгээ сайжирсан.

Сүүлийн хоёр жил үргэлжилсэн цар тахал, тасалдсан нийлүүлэлтийн сүлжээний улмаас хүндрэлтэй байсан ч ХасБанк 2021 онд нийт 20 сая ам.долларын гүйлгээг дэмжиж ажилласан. Импортын аккредитивын нийт үнийн дүн 2020 онтой харьцуулахад 15 хувиар өссөн ч баталгааны нийт үнийн дүн 20 гаруй хувиар буурсан байна. 2022 оны эдийн засгийн нөхцөл байдлын хандлага дэлхийн хэмжээнд эерэг байгаа тул Бизнес банкны худалдааны санхүүжилтээс олох шимтгэлийн орлого ирэх онд нэмэгдэх төлөвтэй байна.

Бизнес банк нь дэлхийн хамгийн том зэс, алтны ордуудын нэг болох Оюу Толгойтой хамтран ажиллаж, ханган нийлүүлэгчид нь бага хүүтэй, түргэн санхүүжилтийг санал болгодог. Нийлүүлэгчид нь Оюу Толгойгоос авах авлагаа барьцаанд тавьж, цөөхөн бичиг баримтаар богино хугацааны зээл авах боломжтой. Оюу Толгойн далд уурхайн олборлолт идэвхжиж эхэлмэгц Банкны авлагын санхүүжилтийн зээлийн багц өсөх өөдрөг төсөөлөлтэй байна.



ХасБанк Сүү ХК-тай 2013 оноос эхлэн бизнесийн харилцааг эхлүүлэн хамтран ажиллаж ирсэн бөгөөд харилцагчийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн санхүүгийн үйлчилгээг цогцоор нь хүргэж ирлээ.

Энэ хугацаанд тус компанийн үйлдвэрлэлийн дэд бүтцээ шинэчлэн сайжруулах, шугамын өргөтгөл хийх, шинэ шугам нээх, малчид, фермерүүдээс хүлээн авдаг шингэн сүү бэлтгэлийн системээ сайжруулах зэрэг хөрөнгө оруулалтуудад ХасБанк ЕСБХБ-тай хамтран эрсдэл хуваах санхүүжилтийг үе шаттай олгож ирлээ.

Сүү ХК эрсдэл хуваах гэрээний 1-р транчийн 9.9 сая ам.доллартай тэнцэх төгрөгийн зээлийн санхүүжилтийг 2019 онд, 2-р транчийн 4.8 сая ам.доллартай тэнцэх төгрөгийн зээлийн санхүүжилтийг 2021 онд тус тус авч, зориулалтын дагуу өндөр үр дүнтэй ашигласнаар бүтээгдэхүүний нэр төрөл нэмэгдэж, чанар сайжран, борлуулалтын орлого, цэвэр ашиг тогтвортой өссөөр байна. 2021 онд Сүү ХК-ийн цэвэр ашгийн дүн 9.4 тэрбумд хүрч, санхүүжилт анх авч байсан өмнөх 2018 онтой харьцуулахад 174%, өмнөх онтой харьцуулахад 133%-аар өссөн үзүүлэлттэй байна.

Зээлийн хөрөнгө оруулалтын үр дүнд үйлдвэрлэлийн бүтээмж дээшлэн, борлуулалт, ашигт ажиллагаа нэмэгдэн, дэд бүтцийн хүчин чадал сайжирснаас гадна хөрөнгө оруулалтын үр дүнд цахилгаан ашиглалтыг 40-50%, ус ашиглалтыг 33% бууруулж байгаль орчинд ээлтэй үйлдвэр болоход нь томоохон түлхэц болохоор тооцоолж байна.

Лизинг

2021 онд олгосон
нийт лизинг
168 тэрбум
Зах зээлд эзлэх хувь
30.1%

Нийт лизингийн багц
196 тэрбум
▲60%

➤ Лизингийн газар (ХасЛизинг)

2021 онд ХасБанк, Тэнгэр Санхүүгийн Нэгдлийн Хувьцаа эзэмшигчид болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шийдвэрээр ХасЛизинг компанийг ХасБанктай нэгтгэн, тус банкны Лизингийн газар болгон өөрчиллөө. Лизингийн газар нь дэлхийд нэр хүндтэй брэндийн тоног төхөөрөмж, суудлын автомашин, хүнд даацын техникийг албан ёсоор борлуулдаг бэлтгэн нийлүүлэгч байгууллагатай хамтран ажиллаж, санхүүгийн түрээс (лизинг)-ээр харилцагчдад түргэн шуурхай олгодог онцлогтой.

2021 онд нийт 168 тэрбум төгрөгийн лизинг харилцагчдад олгосон бөгөөд лизингийн нийт зах зээлийн 30 орчим хувийг бүрдүүлж байна. Лизингийн багцын өсөлт өмнөх оны мөн үеэс 60%-аар өсөж 196 тэрбум төгрөгт хүрсэн ба ХасБанкны нийт зээлийн багцын 11%-ийг бүрдүүлж байна.

Бид харилцагчийн цаг завьг хэмнэх үүднээс шаардлагатай бичиг баримтыг цахим хэлбэрээр бүрдүүлэх, бизнесийн байршил дээр нь очиж үйлчлэн, шуурхай уян хатан шийдвэр гарган ажиллаж байгаа нь харилцагч болон нийлүүлэгч байгууллагуудын сайн харилцааг бий болгох гол хүчин зүйл болж байна.

Лизингийн салбарт Ковид-19 цар тахал дараах байдлаар нөлөө үзүүлээ:

➤ Үйлдвэрлэгч, нийлүүлэгчдэд үзүүлсэн нөлөө

Цар тахлын нөлөөгөөр дэлхийн бүх автомашин болон техникийн үйлдвэрлэгч нар хагас дамжуулагч (semiconductor)-ын хомсдолд орж, үйлдвэрлэлийн хэмжээ буурсан мөн Монгол Улсад борлуулагч албан ёсны бэлтгэн нийлүүлэгчдийн татан авалт, тээвэрлэлт саатан, хугацаандаа явагдах боломжгүй байв.

Хэдийгээр автомашин, машин механизмын импорт саатсан, төлөвлөсөн хугацаандаа орж ирэхгүй хүндрэлтэй нөхцөл байдалтай байсан боловч бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудтай хамтарч ажилласны үр дүнд лизингийн нийт олголтыг өмнөх оноос 200% хувиар өсгөн, зах зээлд эзлэх хувиа амжилттай ахиулж чадлаа.

➤ Харилцагчдад үзүүлсэн нөлөө

Цар тахлын нөлөөллийг бууруулах зорилгоор Засгийн газар болон Монголбанкнаас авч хэрэгжүүлсэн шийдвэрүүдийг хэрэгжүүлж ажиллалаа. Цар тахлын улмаас бизнесийн үйл ажиллагаанд хүндрэл учирсан 6 тэрбум төгрөгийн лизингийн багцын эргэн төлөлтийн хуваарьт өөрчлөлт оруулав.

Хэдийгээр цар тахлын улмаас бизнесийн үйл ажиллагаанд хязгаарлалт тогтоосон, сөрөг нөлөөлөл өндөртэй байсан боловч Лизингийн Газрын хувьд харилцагчдын хэрэгцээ шаардлагад нийцсэн шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлсэн, эрсдэлийн удирдлагыг амжилттай хэрэгжүүлсэн жил байлаа.



Б.Бат-Очир
Хонгорбаян транс ХХК-ийн Гүйцэтгэх захирал

Манай компани анх 1997 онд Баянхонгор аймгаас Улаанбаатар хотруу фургон машинаар зорчигч тээврийн үйлчилгээ хийж бизнесийн гараагаа эхлүүлсэн бөгөөд 2004 онд анхны хүнд даацын өөрөө буулгагч машин худалдан авч, хөрс зөөвөрлөх ажил хийж эхлэн уул уурхайн салбартай холбогдож, энэ салбарын хүн болсон.

Нэг өөрөө буулгагч машинаа нэмээд 2-3 болгосон байсан ч энэ салбарт ажиллахад зайлшгүй экскаватор шаардлагатай болсон. ХасЛизинг-тэй холбогдсон түүх маань анхны Hyundai 500 маркийн экскаваторыг Лизингээр авч бизнесээ өргөжүүлсэн явдал байсан.

Тухайн үед банкнуудад хандсан боловч зээл олгохын тулд үл хөдлөх хөрөнгийн барьцаа шаарддаг, тэр шаардлагыг хангахгүй байсан. Өөрийн хэдэн машинаараа Лизингийн урьдчилгаагаа бүрдүүлэн, ХасЛизинг-ээс шинэ Экскаватор лизингээр авсан маань миний бизнесийн гол хөгжих гарцыг нээж өгсөн.

ХасЛизингээс манай компани 14 удаа нийтдээ 12 тэрбум төгрөгийн техник, тоног төхөөрөмжийн Лизинг авч, үйл ажиллагаагаа өргөжүүлсэн. Одоогоор нийт 4 ширхэг том оврын Hitachi экскаватор, 18 ширхэг өөрөө буулгагч, туслах дэмжих чиглэлийн 20 орчим техникээр жилдээ 12 сая метр.куб хөрс хуулах хүчин чадалтай, 80 гаруй ажилтантай томоохон олборлогч компанийн нэг болж үйл ажиллагаагаа амжилттай явуулж байна.

ХасЛизинг компанийн тоног төхөөрөмжийн Лизингийн үйлчилгээг ашиглан өнөөдрийн амжилтад хүрсэндээ баярлаж явдаг.

Онцлох ажлууд:


Орон сууцны шуурхай зээлийн үйлчилгээг нэвтрүүллээ
ХасБанкны Орон сууцны зээлийн нөхцөл, шийдвэрлэх процессыг Лизингийн аргачлалын дагуу өөрчлөн, түргэн шуурхай байдлаар 1 өдрийн дотор шийдвэрлэдэг шинэ бүтээгдэхүүнийг зах зээлд гарган, үл хөдлөх хөрөнгийн зуучлагч байгууллагуудтай хамтран ажиллаж эхэлсэн.

Toyota-Q хөтөлбөр
Toyota Sales Mongolia компанитай хамтран нийлүүлэгч байгууллагаас борлуулсан Монгол Улсад ашиглагдаж буй сайн чанарын автомашиныг нийлүүлэгчийн засвар үйлчилгээний дүгнэлт, баталгааг үндэслэн хоёрдогч зах зээлд борлуулахад зориулсан зээлийн үйлчилгээг нэвтрүүллээ.

Энэ үйлчилгээ нь шинээр өөрийн харилцагчийн бааз суурийг бэлтгэхээс гадна нийлүүлэгч байгууллагуудаа дэмжин ажиллаж буй давуу талтай.

Лизингийн багцын чанар
Зах зээлд эрэлттэй, бизнесийн олон салбарт ашиглагддаг, зах зээлд түргэн борлогдох чадвартай сайн хөрөнгүүдийг нийлүүлэгч байгууллагуудаас шинээр нь лизингээр олгож байгаа нь багцын чанарыг амжилттай удирдах гол хүчин зүйл юм. Харилцагчдын үйл ажиллагаа явуулж буй бизнесийн салбар бүрд тохируулан лизингээр олгосон хөрөнгийн төвлөрлийг оновчтой удирдсанаар, чанаргүй лизингийн багцыг түүхэн доод түвшинд буюу нийт багцын 0.6%-д хүргэсэн амжилттай тухайн жилийг үдлээ.

Цахим шилжилт




Дижитал банк

Хэрэглээний технологи асар хурдацтай шинэчлэгдэж, цар тахал дотоодод дэгдэж хатуу хөл хорио тогтоосонтой холбоотойгоор харилцагчдын зан төлөвт хурдацтай өөрчлөлт орсон энэ тайлант хугацаанд бид зайнаас харилцагч бүртгэх, харилцах, хадгаламжийн данс нээх, хадгаламж барьцаалсан зээл авах, карт захиалах, картын пин код солих, картгүйгээр АТМ-с зарлага гаргах, дансны тодорхойлолт авах гэх мэт олон шинэ боломжуудыг агуулсан шинэчилсэн дижитал банкны аппликейшн болон веб хувилбарыг олон нийтэд танилцууллаа.

Тайлант хугацаанд дижитал банкаар хийгдсэн гүйлгээ өмнөх онтой харьцуулахад 65%-р өссөн бөгөөд цахим сувгийн гүйлгээ нь нийт ХасБанкны хэмжээнд хийгдсэн гүйлгээний 95%-г эзэлж байгаа нь цар тахлын үед харилцагч нартаа банк, санхүүгийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэж чадсан гэж дүгнэж байна.

Бид 2017 оноос хойш ХасБанкны данс хооронд хийгдэх гүйлгээний шимтгэлийг 0 болгосон ба 2021 онд нийт 919 сая төгрөгийн шимтгэлийн хэмнэлтийг харилцагчдадаа үзүүлсэн байна.

▲ **65%**
Дижитал банкаар
хийгдсэн нийт гүйлгээ



Цахим ШИЛЖИЛТ

Карт эзэмшигч
▲55%

Картын гүйлгээ
▲56%

Төлбөрийн карт

Стратегийн түншлэл болон нээлттэй банк зарчмынхаа хүрээнд бид финтек байгууллагуудтай хамтран ажиллаж харилцагчдадаа шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээ тогтмол санал болгож ирсний үр дүнд ХасБанкны төлбөрийн карт хэрэглэгчдийн тоо сүүлийн 5 жилд 55%, гүйлгээний дүн 56%-иар өссөн үзүүлэлттэй байна. Бид тайлант хугацаанд шинэчлэгдсэн Монпэй картыг зах зээлд танилцуулсан бөгөөд тус карт нь цахим мөнгөний данс эсхүл банкны дансаа нэг дороос сонгож төлбөр тооцоонд ашиглах боломжтой цорын ганц карт юм. ХасБанкны төлбөрийн картууд нь contactless буюу зайнаас унших технологид бүрэн шилжсэнээр цар тахлын үед хүн хоорондын зайгаа баримталж төлбөр тооцоогоо саадгүй гүйцэтгэх боломжийг бүрдүүлсэн.



ПОС

Мерчантууд
▲47%

ПОС-ын гүйлгээ
▲200%

Сүүлийн таван жилд мерчантын тоо 47%-иар өссөн бөгөөд 2021 оны эцсийн байдлаар бид ПОС төхөөрөмжийн тоогоор системийн хэмжээнд 3-т орж, ПОС төхөөрөмжөөр дамжуулан харилцагчдад хүрч үйлчилж байна. ХасБанктай хамтран ажилладаг томоохон худалдаа, үйлчилгээний байгууллагуудаас худалдан авалт хийхдээ ХасБанкны ПОС төхөөрөмж дээр уншуулаад 10-25%-г буцаан авах боломжийг харилцагчдад олголоо. Мөн ПОС төхөөрөмжөөс НӨАТ хэвлэх үйлчилгээг шинээр нэвтрүүллээ. Хэдийгээр цар тахлын нөлөөллөөр бизнесийн байгууллагуудын үйл ажиллагаа хумигдсан, тэр дундаа хатуу хөл хорио 50 хоног үргэлжилсэн боловч мерчантын гүйлгээний тоо өмнөх оноос 15%-иар өслөө.



АТМ

Тайлант хугацаанд бид АТМ-ын хэвийн үйл ажиллагааг 99%-д хүргэж ажилласнаар цар тахал, хатуу хөл хорионы үеэр харилцагчдадаа санхүүгийн үйлчилгээг тасалдалгүй, тогтвортой үзүүллээ. 2017 оноос хойш ХасБанкны АТМ дээр ХасБанкны данс хооронд шилжүүлэг хийх, үлдэгдэл шалгах, бэлэн мөнгө авах үйлчилгээг шимтгэлгүй болгосон ба энэхүү тайлант хугацаанд мөн нийт 161 сая төгрөгийн хэмнэлтийг харилцагчдадаа үзүүлсэн байна.



Хамтын ажиллагаа

ХасБанк нээлттэй банк зарчмынхаа хүрээнд гуравдагч байгууллагууд болох финтек компаниудтай хамтран ажиллаж дэвшилтэт технологи болох нээлттэй API, төлбөр тооцооны систем АСН-ийг санал болгосноор харилцагчдад төлбөрийн шинэ үйлчилгээ, бизнесийн шинэ боломжуудыг өргөн хүрээнд хүргэх боломжийг олгон ажиллаж байна. Тус хамтын ажиллагааны хүрээнд 360 финанс, HiPay, МонПэй цахим мөнгө, Thunes, Ард кредит, MostMoney зэрэг байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэн харилцагчдынхаа хэрэгцээ, хүсэл шаардлагад нийцсэн, хүртээмжтэй, өдөр тутмын банкны үйлчилгээг энгийн бөгөөд хялбар хүртэх боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.



ХасБанкны уур амьсгалын санхүүжилтын төслүүд нь Уур амьсгалын ногоон сан болон Олон улсын оролцогч талуудтай амжилттай хамтран ажиллах замаар уур амьсгалын өөрчлөлтийн гол асуудлуудыг шийдэж байна.

Байгаль орчны хариуцлага

➤ Тогтвортой шийдлүүдийг нэвтрүүлэх нь

ХасБанк нь төсөл хөтөлбөр болон зээлийн бүтээгдэхүүнээрээ дамжуулан карбоны ялгарлыг бууруулах зорилгоор бодит шийдлүүдийг нэвтрүүлэн ажиллаж байна. Бидний хэрэгжүүлж буй үйл ажиллагаа нь олон улсад тулгамдаж буй асуудлуудыг шийдэх, тогтвортой ирээдүйг бий болгох Нэгдсэн Үндэстний Байгууллагын Тогтвортой Хөгжлийн Зорилготой (ТХЗ) нийцэж байгаа юм.

ТХЗ	ХасБанкны үйл ажиллагаа	ТХЗ	ХасБанкны үйл ажиллагаа
1 Ядуурлыг устгах: 	Ядуурлыг устгах: ХасБанкны төсөл, хөтөлбөрүүдийн хүрээнд хэрэгжүүлж буй хөнгөлөлттэй эко зээл, хүүгийн татаастай эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн нь эцсийн хэрэглэгчдэд боломж болон хүртээмжийг нэмэгдүүлдэг.	6 Инноваци болон дэд бүтцийг нэмэгдүүлэх: 	Инноваци болон дэд бүтцийг нэмэгдүүлэх: ХасБанк нь том хэмжээний нарны цахилгаан станцыг бүрэн санхүүжүүлсэн Монголын анхны арилжааны банк болсон.
2 Эрүүл мэндийг дэмжих: 	Эрүүл мэндийг дэмжих: Эрчим хүчний хэмнэлттэй (ЭХХ) бүтээгдэхүүн борлуулах хөтөлбөрийн хүрээнд 173,852 ЭХХ-тэй бүтээгдэхүүнийг 150,489 өрхөд борлуулж нүүрсхүчлийн хий болон агаарын бохирдлыг бодитоор бууруулсан.	7 Тэгш бус байдлыг бууруулах: 	Тэгш бус байдлыг бууруулах: Мерси Кор Олон Улсын байгууллагатай хамтран туршилтын журмаар хэрэгжүүлсэн Ногоон бэлчээрийн төсөл нь Монголын бэлчээрийн доройтолтой газар нутгийн малчдад уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах зорилготой юм.
3 Жендэрийн эрх, тэгш байдлыг хангах: 	Жендэрийн эрх, тэгш байдлыг хангах: Уур Амьсгалын Ногоон Сантай хамтран хэрэгжүүлж буй Хүлэмжийн хийг бууруулах бизнес зээлийн хөтөлбөрийн 50-иас доошгүй хувь нь эмэгтэй бизнес эрхлэгчдэд чиглэсэн байдаг. Тус тоо 2018 оны байдлаар 77.9% -д хүрсэн.	8 Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих: 	Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих: ХасБанкны Эко автомашины зээлийн хөтөлбөр нь 1,067 утаа бага ялгаруулдаг тээврийн хэрэгслийн худалдан авалтын санхүүжилтыг олгосон байхад бизнесийн зээл нь агаарын бохирдлыг бууруулсан байна.
4 Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах: 	Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах: ХасБанкны хамтран санхүүжүүлсэн 10 МВт-ын хүчин чадалтай Нарны цахилгаан станц нь 25 жилийн ашиглалтын хугацаанд ойролцоогоор 4.3 тэрбум литр усыг хэмнэнэ.	9 Хариуцлагатай эрэгтлэгч дэмжих: 	Хариуцлагатай хэрэгтлэгч дэмжих: Уур амьсгалын Ногоон сантай хамтран хэрэгжүүлж буй зээлийн хөтөлбөрүүд нь бизнес болон өрхийн байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг эрчим хүчний хэмнэлттэй худалдан авалтаар бууруулах боломжийг олгож байна.
5 Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх: 	Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх: ХасБанкны хамтран санхүүжүүлсэн 10 МВт-ын хүчин чадалтай нарны цахилгаан станц нь 15,395 мВт/жил бага нүүрстөрөгч бүхий эрчим хүчийг Төвийн Бүсийн Эрчим Хүчний Системд нийлүүлж байна.	10 Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах: 	Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах: Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах Үндэсний хүлээсэн үүрэг болон Ногоон Хөгжлийн бодлогын хүрээнд хүлэмжийн хийг бууруулж байна.

➤ Нийгэм болон хамтрагч байгууллагуудыг байгаль орчны тогтвортой байдлыг хангахад чиглүүлэх

Бид байгууллагын нийгмийн хариуцлага болон урт хугацааны тогтвортой хөгжлийг үндэс болгон Нийгэм болон Байгаль Орчны Бодлогыг боловсруулан мөрдөн ажиллаж байна.

ХасБанк нь тогтвортой хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэгч байгууллагын хувьд банкны үйл ажиллагааны экологи болон нийгэмд үзүүлэх нөлөөг хянах зорилгоор 2002 оноос эхлэн ISO 14001 стандартын дагуу Байгаль Орчин Нийгмийн Хариуцлагын Удирдлагын Тогтолцоог (БОНХУТ) нэвтрүүлсэн билээ. ХасБанкны нийт ажилчид БОНХУТ-ны талаар сургалтанд хамрагдаж, зээл олголт, худалдан авалт зэрэг банкны үйл ажиллагаанд хэрэгжүүлж байгаа ба уг удирдлагын тогтолцоог 2008, 2011, 2014, 2018 онуудад шинэчилсэн болно.

Улс орон даяар хэрэгжүүлж буй өөрсдийн үйл ажиллагаанаас нийгэм, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдээллийг системтэйгээр цуглуулж, стратегийн ач холбогдол бүхий хувьцаа эзэмшигчид болон хөрөнгө оруулагчдад байгаль орчин, нийгмийн тайланг тогтмол хүргүүлдэг. Бид эрчим хүч, түлш, усыг үр ашигтай ашиглах, цаасны хэрэглээ болон хог хаягдлыг багасгах зэрэг байгаль орчноо хамгаалах арга хэмжээнүүдийг санаачлан хэрэгжүүлж байна.



Эко банк



➤ Эко банкны санаачлага

ХасБанкны Эко банкны хэлтэс нь тогтвортой санхүүжилт, эрчим хүчний хэмнэлтийн тооцоолол, хүлэмжийн хийн ялгарлын суурь үзүүлэлтийг тогтоох чиглэлээр мэргэшин ажиллаж буй Монгол улсын банкны систем дэх цорын ганц банкны нэгж юм. Эко банкны хэлтэс нь 2009 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, Карбоны санхүүжилт болон тогтвортой эрчим хүчний санхүүжилт гэсэн үндсэн гурван чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

➤ Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх

ХасБанкны төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь Ногоон зээлийн хөтөлбөрүүдийн үр нөлөөг өргөжүүлэх, өмнөх хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хянах зорилгоор чадавх бэхжүүлэх, зээлийн хөтөлбөрийг олон нийтэд таниулан сурталчлах үйл ажиллагаануудад чиглэсэн байдаг.

2021 онд Уур Амьсгалын Ногоон Сантай хамтран хэрэгжүүлж буй Хүлэмжийн хийг бууруулах бизнесийн зээлийн хөтөлбөрийн тав дахь жил тохиож байна. Хөтөлбөрийн хүрээнд санхүүгийн болон эрчим хүчний хэмнэлтийн талаар мэдлэг, мэдээлэл түгээх зорилгоор Банкны харилцагч жижиг дунд бизнес эрхлэгч нарт чадавхи бэхжүүлэх сургалт, зээлийн мэргэжилтнүүдэд зориулан ногоон зээлийг тодорхойлох, тус ажлыг хялбарчлах зорилгоор эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмжийн жагсаалт боловсруулах болон бизнес эрхлэгч нарт зориулан жил бүр Ногоон санхүүжилтийн форумыг уламжлал болгон зохион байгуулдаг. Гэвч КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах зорилгоор Улсын хэмжээнд хэрэгжүүлсэн гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт үе шаттайгаар шилжсэнээр олон нийтийг хамарсан арга хэмжээ болох Ногоон санхүүжилтын форумын зохион байгуулалт энэ жил цуцлагдсан. Харин харилцагч нарт зориулсан төлөвлөгөөт сургалтуудыг цар тахалын нөхцөл байдалтай уялдуулан оролцогч хүний тоонд хязгаар тавьж системтэй зохион байгуулан ажиллав.

Мөн Уур амьсгалын Ногоон сантай хамтран Эрчим хүчний хэмнэлттэй хэрэглээний зээлийн хөтөлбөр (EECLP) –ийг хоёр дахь жилдээ амжилттай хэрэгжүүлээд байна. Төслийн хүрээнд Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яамтай цэвэр халаалтын шийдэл, байшин сууцны дулаалгын хэрэглээний зээлийг хүүгийн татаасаар дэмжин ажиллах хамтын ажиллагааны гэрээг байгуулсан юм. Түүнчлэн, халаагуурын зээлд хамрагдсан иргэдийн хуучин зуухыг хураан авч устгалд оруулах ажлыг зохион байгуулах; эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмжийн талаар олон нийтэд мэдээлэл түгээх зорилгоор гэр хорооллын өрхийн түвшинд мэдлэг, мэдээлэл солилцох зөвлөгөөнүүдийг зохион байгууллаа.

ХасБанк нь Монголын Тогтвортой Санхүүжилт Холбоотой хамтран эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны урьдчилгаа төлбөрийн 30 хүртэл хувийг буцалтгүй тусламж хэлбэрээр зээлдэгч нарт олгох хөнгөлөлттэй амины орон сууцны зээлийн хөтөлбөрийг хоёр дахь жилдээ амжилттай зохион байгуулав. Энэхүү хөтөлбөр нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Монголын анхны ногоон барилгыг санхүүжүүлсэн бөгөөд цаашдаа Монгол Улсад эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцыг стандартчилахад чиглэсэн урт хугацааны түнш байх болно.

“Эрдэнэт хүмүүн, Эх дэлхий, Эрүүл ашиг” хэмээх эрхэм зорилгынхоо хүрээнд ХасБанк нь Байгаль Орчин, Аялал Жуулчлалын яамтай хамтран өрх, аж ахуйн нэгжүүдэд хөнгөлөлттэй ногоон зээлийг улс орон даяар олгож буй гурван банкны нэг бөгөөд өнөөгийн байгаль орчны тулгамдсан асуудал болох агаар, хөрсний бохирдлыг бууруулахад чиглэсэн 25 төрлийн технологийг санхүүжүүлж байна.



Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх хүрээнд хийгдсэн онцлох ажлууд:

- **2010-2015:** Эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн борлуулах хөтөлбөрийг хэрэгжүүлснээр гэр хорооллын өрхийн 80 орчим хувьд ХасБанкны бүтээгдэхүүн борлуулалтын цэгээр дамжуулан эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүнүүдийг татаастай үнээр борлуулсан.
- **2013-2021:** Хүлэмжийн хийг бууруулах бизнесийн зээлийн хөтөлбөрийг амжилттай өргөжүүлж, үргэлжлүүлэн хэрэгжүүлснээр нийт 1,697,991.45 тонн хүлэмжийн хийг бууруулаад байна.
- **2017-2021:** Хүлэмжийн хийг бууруулах бизнесийн зээлийн хөтөлбөрийн хүрээнд чадавх бэхжүүлэх, хөтөлбөрийг олон нийтэд сурталчилан таниулах арга хэмжээнүүдийг үргэлжлүүлэн зохион байгуулав. 2021 онд 502 салбарын ажилтныг, 121 харилцагчдыг санхүүгийн болон эрчим хүчний хэмнэлтийн сургалтанд хамруулаад байна.
- **2018:** ХасБанк нь Уур амьсгалын ногоон сангийн Үндэсний хэрэгжүүлэгч байгууллагын чадавхи бэхжүүлэх хөтөлбөрийн гүйцэтгэгчээр ажилласан бөгөөд энэ хүрээнд нийт 18 сургалт, семинарыг амжилттай зохион байгуулж, хөтөлбөрт оролцогч талуудаас 782 хүнийг хамруулсан байна. Ингэснээр Уур амьсгалын ногоон сангийн Үндэсний хөтөлбөрийн талаарх ойлголт оролцогч талуудын дунд нэмэгдэж, Үндэсний хөтөлбөрийг нийтээр хүлээн зөвшөөрөхөд чухал нөлөө үзүүлсэн билээ.
- **2019:** 110МВт-ын хүчин чадалтай Сүмбэр нарны цахилгаан станцын барилга угсралтын ажил дуусч, 2019 оны 3 дугаар сараас эхлэн цахилгаан эрчим хүчний нэгдсэн сүлжээнд эрчим хүч нийлүүлж эхлэв.
- **2019:** Эрчим хүчний хэмнэлттэй хэрэглээний зээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд энэ хүрээнд уг хөтөлбөрийг олон нийтэд сурталчлан таниулах ажлыг эхлүүлээд байна. Ногоон санхүүжилтийн гуравдугаар чуулганыг зохион байгуулснаас гадна Сэргээгдэх эрчим хүчний 10-р форумыг ивээн тэтгэж, ХасБанкны дотоод ажилчдын чадавхийг бэхжүүлэх ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулав.
- **2019:** Монголын Ногоон Санхүүгийн Корпораци (MGFC) байгуулахад дэмжлэг үзүүлэх Төслийг батлуулж, мөн онд хийж гүйцэтгэв. Төслийн хэрэгжилтийн явцад хамтран оролцогчид болох Монгол Улсын Засгийн газар болон тэргүүлэгч банкуудтай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан.
- **2019-2021:** Гэр хорооллын бүсэд хэрэгжих “Мини Гридд/Офф Грид- Халаалтын бие даасан шийдэл” төсөл нь 2019 онд Уур Амьсгалын Ногоон Сангийн төсөл хөгжүүлэх санхүүжилтэд хамрагдан хэрэгжиж эхэлсэн. Уг төслийн зорилго нь гэр хорооллын айл өрхийн хэрэгцээнд нийцсэн, Монголдоо анхдагч бизнес загварыг боловсруулах явдал юм. Хэдийгээр 2020 онд дэлхий дахинд дэгдсэн КОВИД-19 цар тахал төслийн хэрэгжилтийн хугацааг хойшлуулахад нөлөөлсөн боловч төслийг 2021 онд амжилттай хэрэгжүүлж дуусгасан.
- **2020-2021:** Эрчим хүчний хэмнэлттэй хэрэглээний зээлийн хөтөлбөрийн хүрээнд Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яамтай гэрээ байгуулж харилцагчдад зээлийн таатай нөхцөлийг бүрдүүлсэн.
- **2020:** Нийслэлийн ЗДТГ-тай хамтран эрчим хүчний хэмнэлттэй хэрэглээний зээлийн талаарх мэдээллийг олон нийтэд таниулан сурталчилах зорилгоор 630 орчим хэсгийн ахлагч нарт өдөрлөг зохион байгуулав.
- **2021:** Нийслэлийн НЗДТГ-тай хамтран нийслэлийн бохирдол ихтэй хоёр дүүргийн 147 хэсгийн ахлагч нарт мэдээлэл түгээх зөвлөгөөнийг үргэлжлүүлэн зохион байгуулав.
- **2020-2021:** Монголын Тогтвортой Санхүүжилт Холбоотой хамтран эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны зээлийн туршилтын төслийг хоёр дахь жилдээ амжилттай хэрэгжүүлэв.

Эко банк

Карбоны санхүүжилт

ХасБанк нь Эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн борлуулах хөтөлбөрийн хүрээнд карбон кредитийг НҮБ-ын Цэвэр хөгжлийн механизм болон Карбоны сайн дурын зах зээлд бүртгүүлэн нөхөн олговор хүлээн авах ажлыг “МикроЭнержи Кредитс” компанитай үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна. Карбон кредитийг байгууллагын нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэх гэж буй корпорациуд болон нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулах зорилтдоо хүрэхээр зорьж буй улс орнуудадад зарж борлуулах боломжтой байдаг. ХасБанкны карбон кредитийн голлох худалдан авагч нь Шведийн Засгийн газар, Микрософт корпораци нар юм.

Карбоны санхүүжилтийн хүрээнд хийгдсэн онцох ажлууд:

- 2009: Карбоны нөхөн төлбөрийг авч эхлэх зорилгоор МикроЭнержи компанитай хамтын ажиллагааны гэрээ байгуулав.
- 2011: Төслийн хүрээнд бий болсон карбон кредитийг Нүүрстөрөгчийн сайн дурын зах зээлд бүртгүүлснээр анхны карбоны нөхөн төлбөр хүлээн авав.
- 2013: Цэвэр хөгжлийн механизмд Эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн борлуулах төслүүдээ бүртгүүлснээр карбон кредитээ борлуулах боломж бүрдлээ.
- 2015: ЭХХ-тэй бүтээгдэхүүн борлуулах төслийн үр дүнд бий болсон карбон кредитээ Шведийн Засгийн газарт худалдах гэрээ байгуулав.
- 2016-2019: Төслүүдийн үр дүнд бий болсон карбон кредитийг Цэвэр хөгжлийн механизмд 2016 онд бүртгүүлснээс хойш нийт 350,000 карбон кредитийг бүртгүүлээд байна.
- 2021: Цаашид 150,086 VER кредитийг хувийн өмчлөлд худалдах ажлыг эхлүүлэв.



Ванчигийн ОЙДОВ |

Эрчим хүчний хэмнэлттэй, нийтэд хүртээмжтэй амины орон сууц

ХасБанкны Эрчим Хүчний Хэмнэлттэй Хэрэглээний Зээлийн хөтөлбөрийн хүрээнд иргэн В.Ойдов нь эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц /АОС/-ыг нийтэд хүртээмжтэй байдлаар бариулсан. Эрчим хүчний хэмнэлттэй барилга нь битүүмжлэл, нарны энерги буюу дулааныг хүлээн авах цонх, ухаалаг агаар сэлгэлт болон халаалтын систем, мөн дулаан тусгаарлах, нөөцлэх материал гэх гол технологийн шийдлүүдээс бүрддэг.

Монголын Тогтвортой Санхүүжилт Холбоотой хамтран хэрэгжүүлсэн эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцын зээл нь зураг төслийн түвшинд болон гүйцэтгэлийн дараа эрчим хүчний аудит хийлгэдэгээрээ онцлог бөгөөд харилцагчдад чанартай урт хугацааны хөрөнгө оруулалт хийхэд анхааран ажиллаж байна.

В.Ойдовын амины орон сууц нь суурь үзүүлэлтээс 47% эрчим хүчний хэмнэлттэй ба гадна болон дотоод тохижилт нь хүртээмжтэй байдлаар буюу шат довжоогүй налуу замтай гадна шийдэл, дотоод засал нь тусгай хэрэгцээт хүмүүсд тохирсон дэд бүтцийн шийдэлтэйгээр /өргөн хаалга, хүртээмжтэй ариун цэврийн өрөө, босгогүй хаалга/ баригдсан.

Тогтвортой Санхүүжилт

ХасБанк нь 2009 онд Эко банкны хэлтсийг байгуулж, тогтвортой санхүүжилтийн үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн ба олон улсын байгууллагуудтай идэвхтэй хамтран ажилласны үр дүнд бизнес эрхлэгчид болон иргэдэд эрчим хүчний хэмнэлттэй, сэргээгдэх эрчим хүчний технологиудыг санхүүжүүлэх хөнгөлөлттэй зээл олгож ирсэн.

2021 оны хувьд Хүлэмжийн Хийг Бууруулах Бизнесийн Зээлийн хөтөлбөр, Эрчим Хүчний Хэмнэлттэй Хэрэглээний Зээлийн Хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж ажилласан.

Эрчим Хүчний Хэмнэлттэй Хэрэглээний Зээлийн Хөтөлбөрийн зорилго нь иргэдийн цахилгаан халаагуур, байшингийн дулаалга зэрэг эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүнүүдийн хэрэглээг нэмэгдүүлэх юм. Тус хөтөлбөр нь өрхийн түвшинд ногоон технологийн сонголтыг нэмэгдүүлэх ач холбогдолтой учраас ард иргэдэд ногоон технологийн хэрэглээний талаарх мэдээлэл түгээн ажиллаж байна.

Тогтвортой санхүүжилтийн хүрээнд хийгдсэн онцлох ажлууд:

- 2009: Нидерландын Хөгжлийн Банкны (FMO) 6.5 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлэр дамжуулан 1,778 айл өрхөд Эрчим Хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүнүүдийг хэрэглээний зээлээр олгосон.
- 2012-2021: Бизнес эрхлэгчдэд зориулсан Эко зээл олгогдож эхэлснээр бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид, борлуулагчид, хэрэглэгчид эрчим хүчний хэмнэлттэй болон сэргээгдэх эрчим хүчний бүтээгдэхүүнийг хөнгөлөлттэй зээлээр худалдан авах, борлуулах боломж бүрдсэн.
- 2012 онд, Даян Дэлхийн Уур Амьсгалын Хамтын Ажиллагааны Сангаас (GCPF) тогтвортой санхүүжилтийг дэмжих зорилгоор 20 сая ам.долларын эх үүсвэр хүлээн авсан.
 - Тогтвортой эрчим хүчний санхүүжилтийн цар хүрээг өргөжүүлэх зорилгоор 2014 онд Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкны Монголын Тогтвортой Эрчим Хүчний Санхүүжилт (МонСЭФФ)-ийн 10 сая ам.долларын эх үүсвэр хүлээн авсан.
 - 2017 онд Уур Амьсгалын Ногоон Сангаас Хүлэмжийн Хийг Бууруулах Бизнесийн Зээлийн хөтөлбөрийн хүрээнд 19.5 сая ам.долларыг зээлийн зориулалтаар, 500,000 ам.долларыг хөтөлбөр хөгжүүлэлтийн зориулалтаар тус тус хүлээн авсан.
 - 2013 оноос эхлэн нийт 127.9 тэрбум төгрөгийг эрчим хүчний хэмнэлттэй шийдлүүдийг дэмжих зорилгоор бизнес эрхлэгчид, аж ахуйн нэгжүүдэд олгож, хүлэмжийн хийн ялгарлыг 1,697,991.45 тонноор бууруулсан.
 - 2014-2018: Даян Дэлхийн Уур Амьсгалын Хамтын Ажиллагааны Сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэгч РеспонсАбилити байгууллагатай хамтран Эко автомашины зээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, шатахууны зардлыг хэмнэх авто машиныг зах зээл дээрхээс бага хүүтэйгээр санхүүжүүлэх боломжийг бүрдүүлж, 2018 онд хөтөлбөр дуусахад 1,067 харилцагчид 5.2 сая ам.долларын санхүүжилт олгосон байна.
 - 2018: ХасБанк нь Мерси Кор Олон Улсын байгууллагатай хамтран Ногоон бэлчээр туршилтын төслийг хэрэгжүүлж эхэлсэн. Тус хөтөлбөрийн гол зорилго нь малын тоо толгойгоо багасгахыг зөвшөөрсөн малчдад хөнгөлөлттэй зээл олгох, чадавхийг бэхжүүлэх замаар байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах, газрын доройтлыг арилгах улмаар малын эрүүл мэндийг сайжруулах, амьжиргааг нь тогтвортой болгоход чиглэсэн байв. Төсөл нь Цвейцарын Хөгжлийн Агентлагийн Ховдод хэрэгжүүлж буй төсөлтэй ижил төстэй юм.
 - 2019-2021: Эрчим Хүчний Хэмнэлттэй Хэрэглээний Зээлийн Хөтөлбөрийг амжилттай эхлүүлж, 9.0 сая ам.долларыг зээлд, 1.0 сая ам.долларыг хөтөлбөр хөгжүүлэлтэд зориулан авахаар УАНС-тай гэрээ байгуулсан. 2021 оны байдлаар тус зээлийн хөтөлбөр нь 9,500 тонн хүлэмжийн хийг бууруулсан ба хөтөлбөр хэрэгжих нийт хугацаанд хүлэмжийн хийн ялгарлыг 469,574 тонн хүртэл хэмжээгээр бууруулах боломжтой юм.

Уур Амьсгалын Ногоон Сан

ХасБанк нь НҮБ-ын Уур Амьсгалын Өөрчлөлтийн Суурь Конвенц (UNFCCC)-ийн хүрээнд уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицоход чиглэсэн үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор байгуулагдсан Уур амьсгалын Ногоон сан (GCF)-гийн магадлан итгэмжлэгдсэн Монголын анхны арилжааны банк юм.

Уур Амьсгалын Ногоон Сан нь ХасБанкны тогтвортой санхүүжилтийн хамгийн том түнш байгууллага юм. ХасБанкны 2019 онд хэрэгжүүлж эхэлсэн Эрчим хүчний хэмнэлттэй хэрэглээний зээлийн хөтөлбөр нь Хялбарчилсан батлах загвар (SAP)-аар батлагдсан анхны хувийн хэвшлийн санхүүжилтийн санал болсон юм. Харин, Сумбэр Нарны Цахилгаан станц нь 2019 оны 3-р сард Төвийн бүсийн эрчим хүчний системтэй холбогдсон нь УАНС-тай хамтран хэрэгжүүлсэн төслүүдээс амжилттай гүйцэтгэж дууссан эхний төсөл хөтөлбөр болсон юм.

2020 онд ХасБанкны дөрөв дахь төслийн санал болох FP153 “Монголын Ногоон Санхүүжилтын Корпораци” (МНСК)-ийг Уур амьсгалын Ногоон сангийн Удирдах зөвлөлийн ээлжит хурлаар батлуулав. МНСК нь уур амьсгалын санхүүжилтыг дэмжих гол хөшүүрэг болох Монголын анхны ногоон санхүүгийн байгууллага бөгөөд Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого Алсын хараа 2050-д тусгагдсан “Байгальд ээлтэй ногоон төсөл, үйл ажиллагааг санхүүжүүлэх төр, хувийн хэвшлийн хамтарсан үндэсний ногоон санхүүгийн тогтолцоог байгуулж хөгжүүлэх” зорилтын хүрээнд үүсгэн байгуулагдах юм. Төслийн хэрэгжилтэд Монгол Улсын Засгийн газар, УАНС болон дотоодын арилжааны банкууд хамтран ажиллах бөгөөд энэхүү олон улсын байгууллага, засгийн газар, хувийн хэвшлийн 3 талт хамтын ажиллагаа нь Монгол улсын ногоон санхүүжилтын хөгжлийг дэмжих, чадавхийг бэхжүүлэх, эрх зүйн орчинг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой байна.

ХасБанк болон Уур Амьсгалын Ногоон Сангийн хамтын ажиллагааны хүрээнд хийгдсэн онцлох үйл явдлууд:

- 2016: ХасБанк нь хөгжиж буй орнуудаас Уур Амьсгалын Ногоон Сангийн хамгийн анхны магадлан итгэмжлэгдсэн байгууллага болсон.
- 2016: FP028: Уур Амьсгалын Ногоон Сангаас Хүлэмжийн Хийг Бууруулах Бизнесийн Зээлийн хөтөлбөр хэрэгжүүлэх зорилгоор 19.5 сая ам.долларын зээлийн эх үүсвэр, хөтөлбөр хөгжүүлэлт, хэрэгжүүлэх зорилгоор 500,000 ам.долларын санхүүжилт авах гэрээ байгуулсан.
- 2017: FP028: Хүлэмжийн Хийг Бууруулах Жижиг дунд Бизнесийн Зээлийн хөтөлбөрийн санхүүжилтийн ХасБанк хүлээн авсан нь УАНС-аас төслийн саналыг бүрэн олгосон анхны тохиолдол боллоо.
- 2017: ХасБанкны хоёр дахь төслийн санал болох FP046: Сэргээгдэх Эрчим Хүчний Хөтөлбөрийг УАНС баталж, 8.65 сая ам.долларын санхүүжилт хийхээр болов. Уг төслийн хүрээнд ХасБанк нь том хэмжээний нарны цахилгаан станцыг бүрэн санхүүжүүлсэн анхны арилжааны банк болсон юм.
- 2018: ХасБанкны гурав дахь төслийн санал болох SAP004: Эрчим Хүчний Хэмнэлттэй Хэрэглээний Зээлийн хөтөлбөрийг УАНС баталж 9 сая ам.долларын зээл, хөтөлбөр хөгжүүлэлтийн хүрээнд 1 сая ам.долларын санхүүжилт хийхээр уг төслийг батлав. ХасБанк нь Хялбарчилсан батлах загвараар төслийн саналаа батлуулсан анхны хувийн хэвшлийн магадлан итгэмжлэгдсэн байгууллага болсон.
- 2018: Бэлэн байдлын дэмжлэгийн хөтөлбөрийн хүрээнд УАНС-ийн Үндэсний Эрх Бүхий Байгууллага болон Үндэсний зохицуулагчийн Уур Амьсгалын Ногоон сантай стратегийн чиглэлийн хүрээнд хамтын ажилагааг хөгжүүлэх, мөн улсын хэмжээнд хэрэгжих хөтөлбөрүүдэд бэлтгэхэд түнш байгууллагаар ХасБанк шалгаран, амжилттай ажилласан билээ.
- 2019: Сумбэр Нарны Цахилгаан станцын бүтээн байгуулалт 2019 онд бүрэн дуусч, Төвийн Бүсийн Эрчим Хүчний Системтэй 2019 оны 3-р сард холбогдсон. Ашиглалтанд орсон цагаас эхлэн нитй 30,242 МВт эрчим хүчийг ТБЭХС-д нийлүүлж, хүлэмжийн хийн ялгарлыг 24,103 тонноор бууруулсан. Нарны цахилгаан станц нь 20,000 гаруй өрхийг сэргээгдэх эрчим хүчээр хангах хүчин чадалтай бөгөөд 25 жилийн ашиглалтын хугацаанд жилд 171 сая литр усыг хэмнэж, 306,745 тонн хүлэмжийн хийг бууруулах юм.
- 2019: Уур Амьсгалын Ногоон Сантай хамтарсан Монголын Ногоон Санхүүжилтийн Корпорац (МНСК)-ийг байгуулахад дэмжлэг үзүүлэх төслийг амжилттай батлуулж 4 сарын хугацаанд хэрэгжүүлж дуусгав.
- 2019-2021: Гэр хорооллын бүсэд хэрэгжих “Мини Гридд/Офф Грид- Халаалтын бие даасан шийдэл” төсөл нь Уур Амьсгалын Сангийн төсөл хөгжүүлэх санхүүжилтэд хамрагдаж 2021 онд амжилттай хэрэгжиж дуусав.
- 2020: ХасБанкны дөрөв дахь төслийн санал болох FP 153: Монголын Ногоон Санхүүжилтийн Корпораци (МНСК)-ийн төслийг 5 сая ам.долларын хувьцааны санхүүжилт, 20 сая ам.долларын зээлийн эх үүсвэр, хөтөлбөр хэрэгжүүлэх зорилгоор 2 сая ам.долларын санхүүжилт хийхээр уг төслийг батлав.
- 2020-2021: Бэлэн байдлын дэмжлэгийн хөтөлбөрийн хүрээнд “Монгол Улс: УАНС-тай уялдаа холбоо, хамтын ажиллагааг бэхжүүлж, улсын хэмжээнд хэрэгжих хөтөлбөрүүдийг Үндэсний зорилтот хувь нэмэр болон Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан шинэчлэх” төсөлд түнш байгууллагаар ХасБанк шалгарав. Бэлэн байдлын төслийн хүрээнд Монгол улсын дунд болон урт хугацааны хөгжлийн бодлогод уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, сааруулахад чиглэсэн арга хэмжээг тусгаж өгсөн.
- 2020-2021: Бэлэн байдлын дэмжлэгийн хөтөлбөрийн хүрээнд “Эрчим хүчний хэмнэлттэй техник, технологийн даатгалын бүтээгдэхүүн боловсруулах” төсөлд түнш байгууллагаар ХасБанк шалгарав. КОВИД-19 цар тахлын хоригоос үүдэн төслийн хэрэгжилт 2021 он хүртэл хойшилсон болно.

Эко Банкны Стратегийн тэргүүлэх чиглэлүүд

Бид Эко Банкны стратегийн тэргүүлэх чиглэлүүдийг ирэх жилүүдэд дараах байдлаар тодорхойлно:

Тэргүүлэгч:

ХасБанкны эрхэм гурван зорилго “Эрдэнэт хүмүүн, Эх дэлхий, Эрүүл ашиг”-ын Эх дэлхий зорилгын тэргүүн хэрэгжүүлэгч болох.

Манлайлагч:

Нэгдсэн Үндэсний байгууллагын Уур Амьсгалын Ногоон Сан (УАНС)-гийн анхны магадлан итгэмжлэгдсэн үндэсний хэрэгжүүлэгч байгууллагын хувьд ХасБанкыг Монголын ногоон санхүүжилтын манлайлагч байр суурьд хүргэх.

Нэгдэл:

ХасБанкны одоогийн бүтээгдэхүүний шугамд нийцүүлэн Ногоон санхүүжилтийг хэрэгжүүлэх бүтцийг бий болгох.

Өргөжин тэлэлт:

Нарны цахилгаан станц, ус хамгаалах зэрэг томоохон дэд бүтцийн төслүүдэд шинэ хэрэглэгчдийг татах зорилгоор урт хугацааны ногоон санхүүжилтийн эх үүсвэрийг татах.

Хамтын ажиллагаа:

Нийгэм, байгаль орчинд ээлтэй хөрөнгө оруулалтын боломжийг бүрдүүлэх замаар Монголын Банкуудын Холбоог нэгтгэж Монголын Ногоон Санхүүгийн Корпораци төслийг хэрэгжүүлнэ. ТоС санаачилгын хүрээнд МБХ-г үргэлжлүүлэн тэргүүлэн ажиллана.

Мэдээллийн ТЕХНОЛОГИ

Ковид-19 цар тахлын нөхцөл байдалд банкны сүлжээний аюулгүй байдал, найдвартай ажиллагааг хангах сайжруулалтыг хийж, хуучин сүлжээний хамгаалалтын төхөөрөмжийг (Firewall) шинэ өндөр хүчин чадал бүхий төхөөрөмжөөр сольж, нийт ажилтнуудаа зайнаас ажиллах нөхцөлийг сайжруулав.

Харилцагчдадаа үзүүлж буй бүтээгдэхүүн үйлчилгээгээ өргөжүүлж, цахим шилжилтийг дэмжих зорилгоор хөрөнгийн удирдлага (Treasury), төлбөр тооцоо (Payment), гадаад худалдааны санхүүжилт (Trade Finance), картын системүүдийг агуулсан олон улсын стандартад бүрэн нийцсэн Finacle системийг нэвтрүүлж дуусгахаар ажиллаж байна.

Картын системийн тогтмол сайжруулалтын хүрээнд VISA Enhancement сайжруулалтууд хийгдэж, картын системийн аюулгүй байдал, тасралтгүй, найдвартай ажиллагааг нэмэгдүүлэв.

Кибер аюулгүй байдлын хамгаалалтын системүүд болох өгөгдөл алдагдахаас сэргийлэх (Data Loss Prevention), давуу эрхийн удирдлага (Privileged Access Management), зөөврийн төхөөрөмжийн удирдлага (Mobile Device Management)-ын системүүдийг тус тус банкны үйл ажиллагаанд шинээр нэвтрүүлэв.

Цар тахалтай холбоотойгоор зохицуулагч байгууллагуудаас гаргасан шийдвэрийн дагуу МИК-ийн зээлийн хугацааг хойшлуулах, зээлийн нөхцөл өөрчлөх ажлыг автоматжуулан хугацаанд нь амжилттай гүйцэтгэлээ.



Банкны үндсэн системээс дансны мэдээллийг Монголбанкны дансны нэгдсэн санд автоматаар нийлүүлэх CAM (Central Address Module) системийн хөгжүүлэлтийг гүйцэтгэв.

Андройд ПОС-оор хийгдсэн И-баримтын гүйлгээний баримтыг татварын систем рүү илгээх үйлдлийг автоматжуулж, төлбөрийн карт, MonPay картыг хүлээн авдаг болгов.

Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын Яамны хүсэлтээр нийгмийн хариуцлагын хүрээнд зорилтот бүлгийн иргэдэд хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний шинэчлэл буюу зөвшөөрөгдсөн дэлгүүр болон супермаркетууд дахь ХасБанкны ПОС терминал дээр хүнсний талон уншдаг болгов.

Банкны төв алба болон салбаруудын дотоод сүлжээний аюулгүй байдлыг хангах "Port Security" төслийн дараагийн үе шатыг амжилттай нэвтрүүллээ.

ХасБанкны төв байрны засварын ажлын хүрээнд компьютерын сүлжээ, дагалдах тоног төхөөрөмжүүдийг бүрэн шинэчиллээ.

Банкны үндсэн болон дэд системүүдийн найдвартай ажиллагааг хангах, системийн доголдол гарсан нөхцөлд системүүдийг хурдан шуурхай нөөц төв рүү шилжүүлэх боломжийг бүрдүүлэх "Array Application Delivery Controller" төхөөрөмжийг нэвтрүүллээ.

Банкны үндсэн болон нөөц дата төвийн сервер, хадгалах төхөөрөмжийг өндөр хүчин чадал бүхий цомхон, орчин үеийн HCI дэвшилтэт технологиор сайжруулж системүүдийн тасралтгүй, найдвартай, хэвийн ажиллагааг нэмэгдүүлэв.

Үндэсний Цахим Гүйлгээний Төвийн картын гүйлгээний систем шинэчлэгдсэнтэй холбоотойгоор ХасБанкны картын систем дээр нэмэлт өөрчлөлтүүдийг хийж, банк хоорондын төлбөрийн картын өсөн нэмэгдэж буй ачааллыг хангах, банкнуудын картын системүүдтэй нийцтэй ажиллах, шинэ төрлийн гүйлгээнүүдийг дэмжих боломжийг нэмэгдүүлэв.

Интернэт банкны системийг шинэчлэх зорилгоор онлайнаар данс нээх, карт захиалах, нөхөн авах, картын пин код солих, зайнаас бүртгүүлэх, гүйлгээний нэмэлт төрөл зэрэг боломжуудыг агуулсан шинэ Дижитал банкны төслийн иргэдэд зориулсан "Retail" модулийг амжилттай нэвтрүүлэв.

Нийгмийн хариуцлага

ХасБанк нь Эрдэнэт хүмүүн, Эх дэлхий, Эрүүл ашиг гэсэн гурван тулгуурт зарчмын хүрээнд Нийгмийн хариуцлага болон Байгаль орчныхоо өмнө хүлээх хариуцлагыг мөрдлөг болгон өөрийн бизнесийн үйл ажиллагаагаар дамжуулан нийгэмд хөрөнгө оруулах, байгаль орчныг хамгаалах үйлсэд хувь нэмэр оруулан ажиллахын зэрэгцээ хууль бус, ёс зүйгүй, байгаль орчинд хортой бизнесийн үйл ажиллагааг санхүүжүүлэхээс татгалзан нийгэм болон байгаль орчны менежментийн бодлогыг хэрэгжүүлдэг.

Санхүүгийн хүртээмжийг дэмжих

Бичил бизнес эрхлэгч харилцагчдаа бизнесээ сэргээхэд нь бодит туслалцаа үзүүлэх зорилгоор “Бизнесийг дэмжих сарууд”-г зарлан орон даяар хэрэгжүүлж, 30 хүртэлх сая төгрөгийн зээлийг сарын 0.9% /жилийн 10.8%/ буюу зах зээл дээрх хамгийн бага хүүгээр олгосноос гадна ажлын байрыг дэмжих 3%-ийн хүүтэй зээлийн хөтөлбөрт нэгдэж бичил, жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжлээ.

Зайнаас банкны үйлчилгээ авах боломжуудыг илүү өргөтгөн сайжруулж, Дижитал банкны шинэ хувилбарыг нэвтрүүлснээр данс нээх, карт захиалах, дансны тодорхойлолт авах гэж банканд ирэх шаардлагагүй болсон бөгөөд зарим төрлийн зээлүүдийг онлайнаар олгож байна. Шинэчлэгдсэн дижитал апп ашиглахад Мобиком, Скайтел, Жи-Мобайлын хэрэглэгчдэд дата үнэгүй болов.



Sport

ХасБанк багийн спортыг талархан дэмжиж, түгээн дэлгэрүүлэхэд анхаарч ирсэн бөгөөд сагсан бөмбөгийн Хасын хүлэгүүд багийг 2004 онд байгуулан, тасралтгүй 18 жил дэмжиж байна.

Мөн и-спортын хөгжилд хувь нэмрээ оруулах, энэ спортоор хичээллэгч, сонирхогч хүүхэд залуус, баг тамирчдыг дэмжих, олон улсын тэмцээн уралдаанд амжилт гаргаж, эх орныхоо нэрийг гаргахад нь түлхэц болох зорилгоор Монголын И-спортын холбоотой хамтран ДОТА 2-ын аварга шалгаруулах тэмцээнийг амжилттай зохион байгууллаа.

Харилцагчаа хамгаалах

Коронавирусийн тархалтаас сэргийлэн тогтоосон хязгаарлалт, хорио цээрийн улмаас бизнесийн үйл ажиллагаа доголдож, зээл төлөхөд хүндрэл үүссэн бизнес эрхлэгч харилцагчдаа ХасБанк санхүүгийн бэрхшээлийг даван туулахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор зээлийн гэрээний нөхцөлд өөрчлөлт оруулж, үндсэн төлбөрийг хойшлуулах, хугацааг сунгах, хугацаа хэтэрсэн тохиолдолд торгуулийн хүү, алдангиас чөлөөлөх шийдвэрүүдийг гарган ажиллаж байна.



Байгаль орчин

Эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчин ээлтэй ногоон бизнес, эко хэрэглээг дэмжих эко хэрэглээний болон хүлэмжийн хийг буруулах бизнесийн зээлийн хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “ТЭРБУМ МОД” үндэсний хөдөлгөөнд нэгдэж, Баруун салааны Бумбатын булагийн орчимд мод тарьлаа.



Боловсрол

ХасБанкны ТУЗ-ийн гишүүн асан Питер Морроугийн нэрэмжит “Оюутны тэтгэлэгт хөтөлбөр”-ийн шилдэг оюутнуудыг тодруулж, тэтгэлэг өглөө. 7 дахь жилдээ зохион байгуулагдаж буй уг тэтгэлэгт хөтөлбөр нь банк, санхүү, эдийн засаг, бизнесийн удирдлага, дата аналисын чиглэлээр амжилттай суралцаж буй, цаашид арилжааны банканд ажиллах хүсэл сонирхолтой чадварлаг, өсөх ирээдүйтэй оюутнуудыг нээн илрүүлж, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, ажлын гараагаа оновчтой, зөв эхлүүлэхэд нь туслах зорилготой бөгөөд Монгол Улсын шилдэг их, дээд сургуулиудад амжилттай суралцаж буй 3, 4-р дамжааны оюутнууд хамрагддаг юм.

Дэлхийн хуримтлалын өдөртэй холбогдуулан олон төрлийн заавар зөвлөгөөг хүүхэд багачуудыг оролцуулан бүх насны хүмүүст зориулсан санхүүгийн мэдлэг олгох сарыг өнгөрүүлэв.



Соёл урлаг

HYP entertainment, Хуур music-тэй хамтран шинэ залуу дуучин, үг, ая зохиогч, “singer, song writer” артистуудыг дэмжин, сонсогчдод хүргэх “HYP Stage” дуут контентыг нийтэд цацаж залуу уран бүтээлчидыг дэмжин соён гэгээрүүлэх төслийг амжилттай хэрэгжүүлэв.

Санхүүгийн үзүүлэлт

Бизнесийн орчин

2020 оны онцлох үйл явдал болох Ковид-19 тахал нь 2021 онд дамжиж үргэлжилснээр олон улсын эмх цэгцтэй байдал улам ихээр алдагдаж, даяан дэлхий өнцөг булан бүрд нийгэм, эдийн засгийн урьд өмнө байгаагүй (6.1 сая гаруй хүн нас барсан) хүндрэл бэрхшээлтэй байдал бий болов. Вирусийн цоо шинэ төрөл, хувирлаас үүдэлтэй давлагаанууд цуварч, тухай бүрдээ шинэ сорилтуудыг дагуулж байсан боловч дэлхий даяарх хувийн болон төрийн эрүүл мэндийн байгууллагуудын хамтын ажиллагааны үр дүнд олон тооны вакциныг 2021 оны эхэн үеэс амжилттайгаар боловсруулж улмаар нэвтрүүлж эхэлсэн.

Өнөөдрийн байдлаар дэлхийн 4.57 тэрбум хүн амын 60 орчим хувь нь (ихэнх төрлийн вакцинд 2 тун тарилга хийх шаардлагатай байдаг) аль хэдийн вакцинд хамрагдсан байна. Гэсэн хэдий ч өдөрт 660 мянга гаруй шинэ тохиолдол бүртгэгдэж буй нь хэдийгээр ерөнхийдөө буурах хандлагад орсныг илтгэж буй авч дахин нэг шинэ төрөл үүсэх боломж өндөр хэвээрээ тул цар тахлын аюулыг бүрэн давах болоогүйг нотолж байна.

Үнэн хэрэгтээ засгийн газруудын зүгээс урт хугацааны турш сунжирсан хил дамнасан хязгаарлалт, дотоодын эдийн засгийн хамгаалалтын бодлогын улмаас дэлхий дахинд шинэ дэг журам тогтож олон улсын худалдааны урсгал асар их гажуудав. Улмаар нийлүүлэлтийн гинжин хэлхээ тасалдаж, аялал жуулчлал гэх мэт тухайлсан бизнесийн салбарууд нэн доройтож, инфляцын өсөлтөөс болж ард иргэдийн санхүүгийн байдал хүндрэсэн тул эргээд сэргэн босох замнал урт бөгөөд удаан байх нь дамжиггүй.

Монгол Улсын Засгийн газар 2020 оны 4-р сард тусгай “цар тахлын” хуулийг баталж, түр хугацаанд шуурхай арга хэмжээ авах гүйцэтгэх засаглалын эрхийг зөвшөөрснөөр цар тахлын нөлөөлөлтэй тэмцэх зорилгоор дотоод нөөц бололцоо тусламжийг төвлөрүүлэх, макро эдийн засгийн бодлогын арга хэмжээнүүд хэрэгжүүлэх зэрэг багтаж хэдийгээр 2022 оны 2-р сард үндэсний онцгой байдлын статусыг дотооддоо хэвийн үйл ажиллагаанд шилжүүлсэн боловч өнөөдрийн байдлаар зарим хэрэгжүүлсэн арга хэмжээг 2022 он дуустал сунгасан байна.

Арилжааны банкны салбар нь Монгол Улсын эдийн засгийн тулгуур салбаруудын нэг болохын хувьд системийн тогтолцоонд янз бүрийн зохицуулалт, төсөв санхүүгийн аливаа арга хэмжээг хэрэгжүүлэх гол суваг нь байсаар ирсэн бөгөөд эдгээр арга хэмжээнд зээлийн эргэн төлөлтийн түр зогсоох зохицуулалт, Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөр, түүнчлэн Ковид-19-ээс өмнө хүчин төгөлдөр болсон Банкны тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтөөр шийдвэрлэсэн системийн хүрээнд банкны бүтцийг өөрчлөхийг тууштай хэрэгжүүлэх зэрэг багтсан.

Монгол улсын системийн ач холбогдолтой банкуудын нэг ХасБанк нь энэхүү хүнд хэцүү цаг үед эдгээр арга хэмжээг идэвхтэй зохион байгуулж, хэрэгжилтийг хурдасгахад манлайлахын сацуу компанийн хариуцлагатай засаглалын хүрээнд ажилтнууддаа шаардлагатай дэмжлэг туслалцааг тасралтгүй үзүүлсээр байна. Хамгийн гол нь эрсдэлийн оновчтой бөгөөд урьдчилан шийдвэрлэх санаачилгатай удирдлагын үр дүнд бид үйл ажиллагаа болон санхүүгийн аль алины хувьд уян хатан боловч тогтвортой байх нөхцөл боломжийг бүрдүүлж, харилцагч, хувьцаа эзэмшигчдийнхээ эрх ашгийг чандлан сахих үүргээ тогтмол хангаж ажилласан.


Иймд үйл ажиллагааны орчинд тулгарч буй сорилтуудыг үл харгалзан, өөрсдийн дотоод нөөц бололцоог ашиглан төрийн шууд тусламж дэмжлэггүйгээр, гол харьцаа үзүүлэлтүүдээ сайжруулан бүх үеийн дээд амжилтаа тогтоосон нь бахархууштай явдал бөгөөд бидний өнөөгийн стратеги зорилтууд үр дүнтэй байгааг харуулж байна.

Макро эдийн засгийн төлөв

Монгол Улсын эдийн засаг Ковид-19 цар тахлын эсрэг арга хэмжээнүүд, түүнчлэн хэд хэдэн удаагийн хөл хорионы улмаас 2020 онд агшаад байсан бол Үндэсний Статистикийн Хорооны урьдчилсан мэдээгээр 2021 онд 1.4%-иар өссөн байна. Хэдийгээр олон улсын байгууллагууд 2021 оны эдийн засгийн өсөлтийг дунджаар 4.5% байхаар төсөөлж байсан ч бодит эдийн засгийн гүйцэтгэл төсөөллөөс доогуур гарсан нь Ковид-19 вирусн шинэ хувилбар, хилийн боомтууд дээрх ачаа тээвэрлэлтийн удаашрал гэх зэрэг тодорхой бус байдлуудаас шалтгаалав.


Үйлдвэрлэлийн аргаар тооцсон эдийн засгийн өсөлтийг эдийн засгийн секторуудаар задалж харвал хөдөө аж ахуй, тээвэр болон барилгын салбарууд агшсан нь эдийн засгийн өсөлт төсөөллөөс бага байхад нөлөөлсөн бол худалдаа, үйлчилгээ болон бүтээгдэхүүний цэвэр татварын өсөлт эдийн засгийн өсөлтөд эерэг хувь нэмэр оруулсан байна.

Эдийн засгийн өсөлт, салбаруудын оруулсан хувь нэмэр



Монгол Улсын Засгийн Газрын зүгээс 2020 оноос Ковид-19-с шалтгаалсан эдийн засгийн удаашрал, бизнесийн тааламжгүй нөхцөл байдлын эсрэг сангийн болон мөнгөний бодлогын хүрээнд томоохон арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж эхэлсэн. 2021 онд энэхүү арга хэмжээ үргэлжлэхээс гадна гуравдугаар сард Засгийн Газраас “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наяд”-ын гурван жилийн хугацаатай хөтөлбөрийг зарласнаар жижиг, дунд үйлдвэрлэл, уул уурхайн бус экспорт, барилга, хөдөө аж ахуй зэрэг гол салбаруудад болон стратегийн төслүүдэд хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн нөхцлийг арилжааны банкнуудаар дамжуулан санал болгож эхэлсэн нь эдийн засаг өмнөх оны мөн үеэс сэргэж 1.4 хувиар тэлэхэд нөлөөллөө. Нөгөө талаас БНХАУ-ын хэрэгжүүлж буй ковидын эсрэг хатуу бодлогын хүрээнд тайлант оны 10 дугаар сараас худалдааны голлох боомтууд дээрх эрдэс бүтээгдэхүүний экспорт удааширч эхэлсэн нь эдийн засгийн өсөлтийг төсөөллөөс доогуур гарахад нөлөөлсөн.


Инфляц



Хэрэглээний үнийн индексээр илэрхийлэгдсэн инфляц 2021 оны 2-р улирлаас эхлэн огцом нэмэгдэж, оны эцсийн байдлаар 13.4% -д хүрсэн нь 2014 оноос хойшхи хамгийн өндөр үзүүлэлт байв. Тодруулбал, хил гааль дээрх ачаа тээвэрлэлтийн саатал, газрын тосны олон улсын зах зээлийн үнийн өсөлт, малын халдварт өвчний дэгдэлт зэрэг нийлүүлэлтийн гаралтай хүчин зүйлс үнийн өсөлтөд голлон нөлөөллөө. Түүнчлэн Монгол Улсын Засгийн газар болон Монголбанкнаас хэрэгжүүлсэн арга хэмжээнээс үүдэн мөнгөний нийлүүлэлт 13.8 хувиар өссөн нь эрэлтийн талаас ч мөн инфляц өндөр гарахад нөлөөлсөн. Дэлхийн ихэнх улс орнууд нийлүүлэлтийн тасалдлаас үүдэн мөн өндөр инфляцтай нүүр тулж байна. Цаашлаад ирэх онд үүсээд буй дэлхийн улс төрийн тогтворгүй нөхцөл байдлаас үүдэн газрын тосны үнийн өсөлт, импортын удаашрал зэрэг нь инфляц өндөр түвшинд хадгалагдах хүлээлтийг бий болгож байна.

2020 онд импортын хэмжээ нэлээдгүй буураад байсан бол 2021 онд цар тахлын эсрэг арга хэмжээний хүрээнд тавигдсан хязгаарлалтууд суларч, цаашлаад импортын голлох бүтээгдэхүүн болох газрын тосны үнэ нэмэгдсэнээр нийт импортын хэмжээ 29.4%-иар өссөн үзүүлэлттэй гарлаа. Харин уул уурхайн бүтээгдэхүүний экспортын биет хэмжээ буурсан хэдий ч түүхий эдийн үнэ огцом нэмэгдсэнээр экспортын нийт орлогыг дэмжиж, гадаад худалдааны тэнцэл 2.4 тэрбум ам.долларын ашигтай гарахад нөлөөлөв.


Худалдааны тэнцэл (тэрбум.доллар)



Урсгал дансны алдагдал өндөр байсан нь төлбөрийн тэнцэл (гадаад валютын албан нөөц (ГВАН)-ийн өөрчлөлт) 2021 онд 222 сая ам.долларын алдагдалтай гарахад нөлөөллөө. Улмаар гадаад валютын албан нөөц (ГВАН) оны сүүлийн хагаст 7.7%-иар буурч, оны эцэст 4.3 тэрбум ам.долларт хүрсэн.

2021 оны туршид төгрөгийн ам.доллартай харьцах ханш 2,850 орчимд тогтвортой байлаа.

ГВАН болон долларын ханш




Банкны салбар

2021 оны байдлаар Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй арилжааны банкнуудын нийт хөрөнгө 40.9 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 11.9%-иар өссөн бол өөрийн хөрөнгө 4.0 их наяд төгрөгт хүрч 7.0%-иар өссөн. Мөн тайлант онд банкнуудын ашигт ажиллагаа нэмэгдэж системийн хэмжээнд тухайн оны ашиг 548.6 тэрбум төгрөгт хүрснээр өмнөх оноос даруй 1.9 дахин нэмэгдсэн байна. Монголбанкны мэдээллэснээр банкны секторын хэмжээнд зохицуулагч байгууллагаас тавьдаг эрсдэлийн хязгаар үзүүлэлтүүд болох өөрийн хөрөнгө, хөрвөх чадвар болон заавал байлгах нөөцийн нормын хязгаар үзүүлэлтүүдийг хангаж ажилласан байна.

Банкны салбарын нийт зээлийн хэмжээ 2021 оны эцсийн байдлаар 20.7 их наяд төгрөгт хүрч өмнөх оны эцэстэй харьцуулахад 21.3%-иар өслөө. Нийт зээлийн үлдэгдлийн 10.4 их наяд төгрөг (50.3%) нь иргэдэд, 9.8 их наяд төгрөг (47.5%) нь хувийн байгууллагад, 0.5 их наяд (2.2%) нь бусад секторт олгогдсон байна. Тайлант онд хувийн байгууллагад олгосон зээлийн үлдэгдэл 23.8%, иргэдэдэд олгосон зээлийн үлдэгдэл 21.8%-иар тус тус жигд өсчээ. Банкны салбарын зээл ийнхүү өсөхөд Монгол Улсын Засгийн Газраас хэрэгжүүлж буй “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хүрээнд олгогдсон хөнгөлөлттэй зээлүүд болох ажлын байрыг дэмжих зээл, репо санхүүжилтын зээл болон ипотекийн зээлийн олголт голлох нөлөөг үзүүллээ.


2021 оны 12 дугаар сарын байдлаар төгрөгийн шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 14.3% болж өмнөх жилийн мөн үеэс 0.5 нэгж хувиар буурсан бол, гадаад валютын шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 7.8% болж өмнөх оны мөн үеэс 1.6 нэгж хувиар буурсан байна. Харин шинээр татсан төгрөгийн хадгаламжийн хүү 2021 оны 12 дугаар сарын байдлаар 5.76% болж өмнөх оны мөн үеэс 2.6 нэгж хувиар буурсан байна. Ийнхүү төгрөгийн хадгаламжийн хүү буурахад цар тахлын үед 2022 оны 6 дугаар сарыг дуустал харилцах болон хугацаагүй хадгаламжид хүү тооцогдохгүй болсон нь голлон нөлөөлж байна.

Банкны салбарын зээлийн хэмжээ болон зээлийн хүү



Нийт зээлийн хэмжээ өссөн, эдийн засаг цар тахлын нөхцөл байдлаас аажмаар сэргэж эхэлсэнтэй холбоотой банкны салбарын чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 2021 оны 12 дугаар сарын байдлаар 10.0%-д хүрч өмнөх оны мөн үеэс буурсан бол хугацаа хэтэрсэн зээлийн хувьд 4.5% болж буурчээ. Ингэснээр банкны салбарын зээлийн чанарын үзүүлэлтүүд Ковид-19 цар тахлын өмнөх үе буюу 2019 оны түвшинд хүрч ирлээ.

Банкны салбарын чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээл, нийт зээлд эзлэх хувиар



Санхүүгийн үзүүлэлт

Цэвэр ашиг (₮)

75.3 тэрбум

▲123.4%

Хүүгийн орлого (₮)

157.8 тэрбум

▲32.2%

➤ Гүйцэтгэлийн дээд амжилт

ХасБанк 2021 онд 75.3 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь жилийн 123%-ийн өсөлт бол 24.0%-ийн өөрийн хөрөнгийн өгөөж 2020 онтой харьцуулахад хоёр дахин өссөн үзүүлэлт юм.

Татварын болон зээлийн эрсдэлийн сангийн өмнөх ашиг 107.1 тэрбум төгрөгт хүрч, 43.5 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь цэвэр хүүгийн орлого эрс сайжирч, эрсдэлийн сан бүрдүүлэх оновчтой удирдлагын үр дүнд сангийн зардлын түвшин буурсны үр дүн болно.

Санхүүгийн салбарт үүссэн нөхцөл байдал болон төрийн хэрэгжүүлсэн арга хэмжээнээс улбаалан зээлийн хүүгийн хэмжээ ерөнхийдөө буурснаар хүүгийн орлого багассан боловч пассивын оновчтой удирдлагын үр дүнд хүүгийн зардалд илүү их хэмнэлт хийгдэж, цэвэр хүүгийн орлого 32.2%-иар өсөж, 157.8 тэрбум төгрөг хүрчээ.

Хүүгийн бус орлого 18.9 тэрбум төгрөг (2020 онд 16.9 тэрбум төгрөг) ба үүнд хураамж, шимтгэл гэх мэт бусад үндсэн бус үйлчилгээний орлого хамаарах бөгөөд энэ нь нийт үйл ажиллагааны орлогын 10 орчим хувийг эзэлж байна. Мөн 2021 онд арилжааны орлого 6.2 тэрбум төгрөг хүрсэн нь 2020 онтой харьцуулахад бараг гурав дахин өссөн үзүүлэлт бөгөөд жилийн туршид хөрвөх чадварын хэмжээ өндөр байж, улмаар гүйцэтгэсэн гүйлгээний хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой юм.

2019 оны 2-р хагасаас хэрэгжүүлсэн зээлийн эрсдэлийг бууруулах дунд хугацааны стратеги бодлогын хүрээнд зээлийн чанаргүйдлээс үр ашигтайгаар урьдчилан сэргийлсэн удирдлагын оновчтой шийдлийн үр дүнд чанаргүй зээлийн нийт зардал 4.6 тэрбум төгрөг байгаа нь 2020 оныхоос даруй 4.3 дахин бага буюу нийт зээлийн багцын чанарын чадавх сайжирсан нь эрсдэлийн сангийн хүрэлцээний харьцаа үзүүлэлт ~103%-иас ~119% хүртэл өссөн түүхэн дэх хамгийн өндөр үзүүлэлтээр бататгагдаж байна.

Үйл ажиллагааны зардлын хувьд Банк нь бүх зардлын төрлүүдийн хувьд ашигт ажиллагааг тогтмол сайжруулахад анхаарч ажилласаар байгаа тул үйл ажиллагааны зардал, орлогын харьцааг 8.0%-иар бууруулж 41.9%-д хүргэж чадав.

Нийгмийн эрүүл мэндийн даатгал, эрчим хүч зэрэг нийтийн үйлчилгээний төлбөрийг түр хугацаанд хүчингүй болгох гэх мэт төрөөс хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд үйл ажиллагааны зардалд хэмнэлт буй болсон хэдий ч Банк нь тэдгээрийг ажилтнуудынхаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх аюулгүй байдлын хангамжийг тасралтгүй хангах, цалин урамшууллыг нэмэгдүүлэхэд бүрэн зориулав.

Үүгээр ялангуяа анхан шатны албан тушаалын ажилтнуудад ихээхэн хүртээмжтэй байсан нь бизнесүүд цалин урамшууллаа танасан цар тахлын хүндрэлтэй үед өндөр ач холбогдолтой байв.

➤ Санхүү, үйл ажиллагааны өндөр бүтээмж

Системийн нөлөө бүхий 5 банкны нэг, ХасБанк нь нийт 3,500 тэрбум төгрөгийн активтай бөгөөд 2021 оны 149 тэрбум төгрөгийн өсөлтийг 2,228 тэрбум төгрөгийн хэмжээ бүхий иргэд, аж ахуйн нэгжүүдийн харилцах, хадгаламжийн 11%-ийн өсөлтөөр бүрдүүлж энэ нь цаашлаад 2 жил гаруй хугацааны турш буураад байсан харилцагчдад олгосон зээлийн багцыг өсгөхөд нөлөөлж 1,850 тэрбум төгрөгт хүргэсэн байна (өнгөрсөн оноос 26%-иар өссөн).

Удирдаж буй нийт харилцах, хадгаламжийн 20 орчим хувийг гадаад валютын хадгаламж, түүнчлэн харилцах болон хугацаагүй хадгаламжийн данснууд нийлээд мөн адил 20 орчим хувь эзэлж байгаа нь 2020 оны түвшинтэй ижил байгаа юм.

Бусад үндсэн эх үүсвэрт 638 тэрбум төгрөгийн гадаад өрийн эх үүсвэр, 139 тэрбум төгрөгийн дотоодын эх үүсвэр буй бөгөөд энэ нь эдийн засгийн тодорхой салбарыг дэмжсэн тусгай зориулалтын зээлийг санхүүжүүлэх төрөөс олгосон эх үүсвэр ба Ковид-19-тэй холбоотой засгийн газрын хөтөлбөрүүдтэй уялдан тухайн жилд 56 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Гадаад эх үүсвэр нь олон улсын нэр хүнд бүхий санхүүгийн байгууллагуудаас татан төвлөрүүлсэн зээлийн өр ба ХасБанкны нийт пассивын бүтцийн 21%-ийг эзэлсэн нь өмнөх жилээс 16%-иар буурсан үзүүлэлт буюу сүүлийн 5 жил дэх хамгийн бага хэмжээ юм. Банк нь богино хугацааны түргэн борлогдох Төв Банкны үнэт цаасны активын суурь сайтай байсан тул 2020, 2021 оны цар тахлын үед шинээр санхүүжилт төвлөрүүлээгүй.

Үнэт цаас дахь бидний хөрөнгө оруулалт жилийн эцсийн байдлаар зах зээл дээрх нийт багцын 10.5%-тай тэнцэх хэмжээний буюу 910 тэрбум төгрөг байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 300 тэрбум төгрөгөөр буурсан нь зээлийн багцад шилжсэн багцын органик өсөлтийн дэмжлэг болжээ.

Өмнөх онд 73% байснаас 83% болж өссөн зээл болон харилцах, хадгаламжийн нийт багцын харьцаа үзүүлэлт нь арилжааны банкнуудын хувьд бизнесийн үндсэн бүтээгдэхүүний бүтцийг харуулсан харьцаа буюу өөрөөр хэлбэл хүүгийн өгөөжтэй активын суурийг (хөрөнгө оруулалт ороогүй) хүүгийн зардал бүхий пассивын хэмжээнд (гадаад эх үүсвэр ороогүй) харьцуулсан гол үзүүлэлт юм.

➤ Өмнөхөөсөө илүү хүчтэй суурь

Монголбанкнаас арилжааны банкнуудын санхүүгийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг зохицуулах зорилгоор банкны салбарт төрөл бүрийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг тогтоосон байдаг. ХасБанк нь эдгээр зохистой харьцааны шалгууруудыг тогтмол бүрэн хангаад зогсохгүй ихэнх тохиолдолд давуулан биелүүлсэн.

1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн эрсдэлээр жигнэсэн активд харьцуулсан зохистой харьцаа өнгөрсөн 12 сарын дотор 16.9%-иас 17.4%-иар дээшилсэн байгаа нь 9%-ийн зохистой харьцааны хамгийн бага түвшний хэм хэмжээтэй харьцуулахад хангалттай байж, нөөц хөрөнгийн хэмжээ улам сайжирсныг илтгэж байна. Энэхүү хөрөнгийн эерэг хуримтлалыг цэвэр хүүгийн орлогын хэмжээ нэмэгдэж, зээлийн эрсдэлийн сангийн зардлын дарамт буурснаас бизнесийн ашигт ажиллагаа сайжирснаар тайлбарлаж болно. Түүнчлэн зардлын сахилга баттай бодлогын үр дүнд үйл ажиллагааны зардал хэмнэгдэж, өгөөжийг улам бүр нэмэгдүүлсэн.

ХасБанк нь гадаад валютын цэвэр үлдэгдэлийг ямагт бага байлгахыг зорьдог ба санхүүгийн тайлант оны эцсийн байдлаар 15%-ийн зохистой харьцааны шалгууртай харьцуулахад 1.1%-ийн нээлттэй валютын позицийн харьцаатай (нэгж тухайлсан валютын цэвэр үлдэгдэлийг капиталтай харьцуулна) байгаа бөгөөд гадаадаас татан төвлөрүүлсэн валютын эх үүсвэрүүд Монголбанкны своп хэлцэлд хамрагдаж ханшийн эрсдэлээс хамгаалагдсан байдаг.

144%-тай байгаа манай зээлийн төвлөрлийн харьцаа (өөрийн хөрөнгийн 5%-иас дээш зээлийн хэмжээ нийт зээлийн багцад харьцуулна) нь зохистой харьцааны дээд түвшний хэмжээ болох 300%-ийн талаас доогуур буюу ялангуяа бизнесийн орчин хямралтай байгаа эрсдэлийн хувьд одоогийн нөхцөлд зээлийн чанарын эрсдэл, нөлөөлөл бага байна гэж үзэж болно. Үүний нэгэн адил манай харилцах, хадгаламжийн төвлөрлийн харьцаа (том 10 харилцах, хадгаламжийн нийлсэн дүнг нийт багцад харьцуулна) 7.1% буюу зохистой харьцааны 25%-иас 3.5 дахин доогуур байна.

Жилийн туршид хөрвөх чадварын харьцаа нийт 10.5%-иар буурч, оны эцэст 44.3% хүрсэн хэдий ч энэ нь хамгийн багадаа 25% байх ёстой зохистой харьцааны шалгуурыг маш сайн давуулан хангаж байгаа юм. Банк нь тухайн жилийн хугацаанд зээл олголтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, өр төлбөрийг барагдуулах замаар хөрвөх чадварын илүүдлийг бууруулж чадсан ч харьцаа үзүүлэлтээ 35%-иас илүү түвшинд барих зорилт тавин ажиллаж байна.

Дотоод аудит

Дотоод аудитын газрын зорилго, бүтэц зохион байгуулалт

Дотоод аудит (ДА) нь банкны дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын үр дүнтэй байдлыг үнэлж, үйл ажиллагааны бүх түвшинд дотоод хяналтыг сайжруулах зөвлөмж өгч, хэрэгжилтийн явцыг хянан ТУЗ-ийн Аудитын хороо болон Гүйцэтгэх удирдлагад тогтмол тайлагнадаг.

2021 онд Дотоод аудитын газар бүтцийн өөрчлөлт хийж Газар дээрх аудитын хэлтэс болон Арга аргачлал мониторингийн алба байгуулсан.

ДА нь Олон улсын Дотоод аудиторчуудын институт (The Institute of Internal Auditors)-ийн гаргасан Олон улсын мэргэжлийн практикийн хүрээ (International Professional Practices Framework), Ёс зүйн дүрмийг үндсэн үйл ажиллагаандаа баримтлан хамгаалалтын гуравдугаар бүсийн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

2021 оны онцлог үйл ажиллагаа

Цар тахлын сорилттой тулгарсан 2021 онд ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооноос баталсан төлөвлөгөөний дагуу эрсдэлд чиглэсэн зарчмыг баримтлан Төв Албаны 7 процессын аудит, Мэдээллийн технологийн 4 аудит хийж гүйцэтгэсэн ба орон нутгийн 12 салбарын аудитыг зайнаас хийж үр дүнг танилцууллаа. Эдгээрээс дурдвал Цар тахлын үеийн Бизнесийн тасралтгүй үйл ажиллагааны аудит болон Харилцагчийн үйлчилгээний үйл ажиллагааны аудитуд нь Ковидын үед учирч болзошгүй эрсдэлүүдийг илрүүлэх, үнэлэх, залруулах, хяналтын тогтолцоог сайжруулахад ихээхэн хувь нэмэр оруулсан онцлог аудитуд байв.

Зайны хяналтыг хөгжүүлэх, үргэлжилсэн аудитын суурийг тавих зорилгоор газар дээрх салбарын хяналтыг датанд суурилсан зайны аргачлалд бүрэн шилжүүлж, үйл ажиллагаандаа туршин нэвтрүүлээ. Цар тахлын үед банкны үйлчилгээг зайнаас харилцагчдад хүргэж байсантай холбоотойгоор банкны үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг илрүүлэх, сэргийлэх чиглэлээр зайны хяналтын тайлан, мэдээллүүдийг боловсруулан үйл ажиллагаанд ашиглалаа. Мөн цар тахлын үед Монгол Улсын засгийн газраас хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдтэй холбоотой зээлийн хяналтуудыг хийж, үйл ажиллагааг сайжруулах зөвлөмжийг өгч ажиллав.

Ажилтнуудын сургалт хөгжлийн чиглэлээр Олон Улсын Дотоод Аудиторуудын институтээс зохион байгуулсан зайны сургалтууд, онлайн хөтөлбөрүүдэд ДА-ын ажилтнуудыг тогтмол хамруулдаг бөгөөд 2021 онд Мэргэшсэн Санхүүгийн Аудитор /CFSA - Certified Financial Services Auditor/ цолыг 1 аудитор хүртсэн байна.

Эрсдэлийн удирдлага

ХасБанкны эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээний хүрээнд эрсдэлийн төрөл, хэмжээг тодорхойлж, эрсдэлийн үйл ажиллагааг зохицуулдаг.

Эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээг үр дүнтэй, тодорхой бий болгох нь өгөөж болон хүлээх эрсдэлийн хоорондох зохистой тэнцвэрийг хадгалахын зэрэгцээ Банкны хэмжээнд эрсдэлийн соёлыг бэхжүүлэхэд дэмжлэг болдог.

Эрсдэлийн удирдлагын засаглал

ХасБанк нь Төлөөлөн удирдах зөвлөлийн дэмжлэгтэйгээр эрсдэлийн удирдлагын сайн засаглалыг бий болгож чадсан. Банкны эрсдэлийн засаглалыг дараах хороодоор дамжуулан хэрэгжүүлдэг. Үүнд:

Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн эрсдэлийн удирдлагын хороо: ТУЗ-ийг төлөөлөн эрсдэлийн асуудлууд дээр бие даасан, эцсийн хяналт тавьж ажилладаг.

Эрсдэлийн удирдлагын хороо: Банкны гүйцэтгэх удирдлагын дэргэдэх хороо бөгөөд эрсдэлийн үйл ажиллагаа, эрсдэлийн удирдлагын тогтолцооны хэрэгжилт болон Банкны хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэмжээг дагаж мөрдөж байгаа эсэхэд хяналт тавьж, үнэлж дүгнэж ажилладаг.

Үйл ажиллагааны эрсдэлийн хороо: Банкны хяналтад суурилсан үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын тогтолцоо болон үйл ажиллагааны эрсдэлийн зөвшөөрөх хэм хэмжээнд хяналт тавин ажилладаг.

Зээлийн удирдлагын хороо: Тогтоосон эрх хэмжээний хүрээнд зээлийн саналуудыг шийдвэрлэхэд төвлөрөн ажилладаг.

Эрсдэлийн удирдлагын тогтолцоо

Банкны эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь хамгаалалтын 3 бүсийн зарчимд суурилсан ба эрсдэлийг хариуцах, хянах чиг үүргийг дараах байдлаар тодорхойлдог. Үүнд:



Хамгаалалтын нэгдүгээр бүс

(Бизнес нэгжүүд болон түүнд дэмжлэг үзүүлэх нэгжүүд) нь эрсдэлийг хариуцах эзэн байх бөгөөд өөрийн үйл ажиллагааны эрсдэлийг үнэлэх, эрсдэлд хяналт тавих, эрсдэлийг бууруулах чиг үүрэгтэй.



Хамгаалалтын хоёрдугаар бүс

(Эрсдэлийн удирдлага, хяналтыг хэрэгжүүлэгч нэгжүүд) нь эрсдэлд хяналт тавих чиг үүргийнхээ хүрээнд эрсдэлийн удирдлагын тогтолцоог бий болгох, холбогдох бодлого, журмыг боловсруулах, эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэм хэмжээ, эрсдэлийн хязгаар үзүүлэлтийг тогтоох, эрсдэлийн цар хүрээг хянах чиг үүргүүдийг хэрэгжүүлдэг. Мөн энэхүү чиг үүргийнхээ хүрээнд, хамгаалалтын хоёрдугаар бүс нь хамгаалалтын нэгдүгээр бүсийн хяналтын үйл ажиллагаа болон шийдэлд хяналт тавих ба тогтмол зааварчилгаагаар ханган ажилладаг.



Хамгаалалтын гуравдугаар бүс

(Дотоод аудит) нь хараат бус үнэлэлт, дүгнэлт өгөх чиг үүрэгтэй бөгөөд банкнаас хэрэгжүүлж буй эрсдэлийн цар хүрээг үнэлэх, удирдах арга хэмжээ үр дүнтэй байгаа эсэх болон хамгаалалтын нэг, хоёрдугаар бүсийн үйл ажиллагаа үр дүнтэй байгаа эсэхийг үнэлэх байдлаар эрсдэлд суурилсан арга барилын талаарх хараат бус баталгаагаар ТУЗ-ийг хангадаг.

Эрсдэлийн удирдлага

➤ Зээлийн эрсдэлийн удирдлага

Зээлийн эрсдэл гэж зээлдэгч банктай байгуулсан гэрээний үүргийг биелүүлээгүйгээс хүлээж болзошгүй алдагдлыг хэлдэг. Банк нь зээлийн бодлого, журмыг боловсруулан зээлийн эрсдэлийг удирдах зохих орчинг бий болгож, зээлийн үйл ажиллагааны оновчтой процессыг тодорхойлж, зээлийн үйл ажиллагаанд шаардлагатай хяналтын тогтолцоог бий болгох замаар зээлийн эрсдэлийг дараах байдлаар удирддаг. Үүнд:

- Зээлийн эрсдэлийг удирдах ерөнхий журмаар салбар, нэгжийн зээлийн үйл ажиллагааны цар хүрээг бизнесийн нэгжүүдтэй хамтран эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан тогтоодог.
- Салбар, нэгжийн зээлийн санал шийдвэрлэх эрх хэмжээг зах зээлийн багтаамж, чадамжид үндэслэн хуваарилан эрхийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилладаг.
- Зээлийн багцын эрсдэлийг эдийн засгийн сектор, бүтээгдэхүүний түвшинд лимит тогтоон хянаж ажилладаг.

Банк нь харилцагчдаа зээлийн дарамтад орохоос сэргийлэх, зээлийн судалгаа, шийдвэр гаргалтыг хурдан шуурхай болгох зорилгоор өргөдлийн скорингийг иргэдийн зээл олголт, рэйтингийн загварыг бизнесийн зээл олголтод ашигладаг. Мөн түүнчлэн зээлийн багцын эрсдэлийн удирдлагын хүрээнд эрсдэлийн дохионы систем (early warning system), зан төлөвийн (behavioral) болон эргэн төлөлтийн (collection scoring) скорингийн загваруудыг их хэмжээний тоон мэдээлэл дээр үндэслэн боловсруулж, үйл ажиллагаандаа нэвтрүүлээд байна. Зээлийн багцын хүлээгдэж буй эрсдэлийг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт 9-ийн дагуу тооцоолж, холбогдох эрсдэлийн санг байгуулж ил тод нээлттэй тайлагнан ажилладаг.

2021 он нь Ковид-19 цар тахалтай тэмцсэн амаргүй жил хэвээр байлаа. Банк нь цар тахалтай холбоотойгоор бизнесийн үйл ажиллагаа, орлогод нь сөргөөр нөлөөлсөн зээлдэгч нарынхаа зээлийн нөхцөлийг өөрчлөх үйл ажиллагааг үргэлжлүүлсэн.

Банк цар тахлын хязгаарлагдмал орчинд үйл ажиллагаа явуулсан ч зээл олгох үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн зээлийн багцыг өсгөхийн хажуугаар зээлийн багцын эрсдэлийг амжилттай удирдаж, зээлийн багцын чанарын үзүүлэлтийг бууруулж чадсан жил байлаа. Мөн Банк нь Засгийн газраас хэрэгжүүлсэн эдийн засгаа сэргээх цогц хөтөлбөрийн хүрээнд бизнес эрхлэгчдийн эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэх Ажлын байрыг дэмжих зээлийг олгосон.

➤ Зах зээлийн болон хөрвөх чадварын эрсдэлийн удирдлага

Жил бүр Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооноос хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээг Банкны бизнес төлөвлөгөө, стратегитэй уялдуулан шинэчлэн баталж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилладаг.

2021 онд зах зээлийн болон хөрвөх чадварын эрсдэлийн үзүүлэлтүүдийг зохицуулагч байгууллагын шаардлага болон Банкны хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээг тогтмол хангаж ажиллалаа. Банк нь хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагын хүрээнд төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа үзүүлэлтийг Монголбанкнаас тавьдаг зохистой харьцааны доод шаардлагыг бүрэн хангаж ажилласнаас гадна хөрвөх чадварын нөөц (liquidity buffer), богино хугацаат хөрвөх чадварын үзүүлэлт (short-term liquidity ratio), хөрвөх чадварын хүрэлцээний харьцаа (LCR), цэвэр тогтвортой санхүүжилтийн харьцаа (NSFR) зэрэг үзүүлэлтүүдийг хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээнд тогтмол хангаж ажиллалаа.

Хүүгийн эрсдэлийн удирдлагын хүрээнд Банкны хүүгийн өөрчлөлтөд мэдрэмтгий нийт актив пассивын зөрүү болон хүүгийн өөрчлөлтөд мэдрэмтгий байдлын шинжилгээг тогтмол хийж санхүүгийн эрсдэлийн удирдлагын тогтолцооны дагуу удирдаж ажиллалаа.

Тус хугацаанд Банк гадаад валютын позицийн Монголбанкны шаардлагыг бүрэн хангахаас гадна цэвэр нээлттэй позицийн ашиг, алдагдлын хэмжээг (Хамгийн Их Эрсдэл (Value-At-Risk)-ийн үнэлгээ) Банк хүлээн зөвшөөрөх хэмжээнд хангаж ажиллалаа.

Түүнчлэн өнөөгийн эдийн засгийн тодорхой бус байдал давамгайлсан бизнесийн орчинд шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх, тохиолдож болзошгүй гэнэтийн хүндрэлтэй нөхцөлүүдэд Банкны санхүүгийн байдал, өөрийн хөрөнгийн хүрэлцээ, хөрвөх чадварт үүсэж болох нөлөөллийг тодорхойлох зорилгоор цочролын тест (стресс тест)–ийн шинжилгээг тогтмол хийдэг.

➤ Хянан нийцүүлэлт

Банкны комплаенсын функцийн эрхэм зорилго нь тогтвортой бизнесийн үйл ажиллагааг хангах, санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор ХасБанкны Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх бодлогын хүрээнд өндөр стандартын дагуу үйл ажиллагаа явуулж, дотоод болон гадаад түншлэлээр дамжуулан Банк, харилцагчид болон олон нийтийн харилцаанд эерэг үр дүнд хүрэхэд оршино.

Комплаенсын эрсдэл гэдэг нь санхүүгийн салбарт мөрдөгдөж буй хууль тогтоомж, зохицуулагч байгууллагын шаардлага, тухайн салбарын бизнесийн болон мэргэжлийн ёс зүйн стандартыг дагаж мөрдөөгүйгээс ХасБанк нь бизнесийн үйл ажиллагааг амжилттай явуулах боломжгүй болох эрсдэлийг хэлнэ. Үүнд, ялангуяа санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэхэд чиглэсэн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, залилан болон авлига, хээл хахуультай тэмцэх зохицуулалтууд орно.

Монгол улс нь Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоогоо сайжруулах чиглэлд анхаарал хандуулан тодорхой ахиц дэвшлийг гарган ажиллаж байгаа билээ. Үүний хүрээнд Монголбанк нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Мансууруулах бодис болон зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх газар (UNODC)-аас мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зориулан тусгайлан хөгжүүлсэн goAML порталыг нэвтрүүлэх ажлыг эхлүүлсэн. ХасБанк нь Монголбанкнаас нэвтрүүлэхээр ажиллаж байгаа goAML порталд зориулан дотооддоо тайлангийн хөгжүүлэлтийг хийлээ.

Банкны Комплаенсын хэлтэс нь бүтцийн хувьд томоохон өөрчлөлтийг хийсэн онцлог жил тохиолоо. Комплаенс хариуцсан мэргэжилтний орон тоог 3 дахин нэмж, хэлтсийн нийт ажилтнуудыг ерөнхий комплаенс, гүйлгээний хяналт, харилцагчийг таньж мэдэх гэсэн гурван багт хуваан, хариуцсан чиглэлд нь мэргэшүүлэхээр бэлдэж, гаднын болон дотоодын сургалтуудад хамруулж байна. Үүний үр дүн Банкны гүйлгээний хяналтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа ихэд сайжирч, Санхүүгийн мэдээллийн алба (СМА)-нд хүргүүлдэг сэжигтэй гүйлгээний тайлангийн тоо болон чанар огцом өссөн байна.

Бид бодлого журам болон автоматжуулсан систем, хяналтыг хослуулан холбогдох эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, хэмжих, бууруулах, тайлагнах арга хэмжээ бүхий комплаенсын хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. Банкны Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх бодлогыг шинээр боловсруулан ТУЗ-өөр батлууллаа.

Банк нь мөн ажилтнууддаа хэрэгцээ шаардлагад нийцсэн сургалтыг явуулж, магадлан шалгах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Комплаенсын соёлыг сурталчлах шаардлагатай гэдэгт бид итгэдэг бөгөөд үүнийг манай Төлөөлөн Удирдах зөвлөл болон Гүйцэтгэх удирдлагын багийн хамт олны дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж байна.

➤ Үйл ажиллагааны эрсдэл

Банк нь хүний хүчин зүйл, дотоод процесс, мэдээллийн технологийн алдаа, доголдол болон гадна орчны нөлөөллийн улмаас өдөр тутамдаа үйл ажиллагааны эрсдэлтэй тулгардаг ба тэрхүү эрсдэлийг эрт илрүүлэх, бууруулах, хүлээн зөвшөөрөх түвшинд удирдах үүднээс зөв зохистой хяналтыг хэрэгжүүлж ажилладаг. Үйл ажиллагааны эрсдэл хариуцсан нэгж нь энэхүү зорилтын хүрээнд банкны процессуудын эрсдэлийг бизнес нэгжүүдтэй хамтран үнэлэх ажлыг жил бүр хийж гүйцэтгэхээс гадна 2021 онд Банкны санхүүгийн бус эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээг хянаж шинэчлэв. Түүнчлэн, урт хугацааны турш үргэлжилсэн цар тахал нь банкны үйл ажиллагаанд таагүйгээр нөлөөлсөөр байсан боловч банк төдийгүй бүхий л бизнес, байгууллагуудад өөрийн бүтээгдэхүүн, үйлчилгээгээ харилцагчдадаа цахим хэлбэрээр хүргэх боломжийг бүрдүүлэх зайлшгүй шаардлагыг бий болгосон. Энэ нь уламжлалт арга барилаа эвдэн харилцагчдадаа цахим сувгаар үзүүлэх үйлчилгээгээ нэмэгдүүлэхэд түлхэц болсон ба ингэснээр хүний үйл ажиллагаанаас хамааралтай эрсдэлийг бууруулахад томоохон алхам боллоо.

Хүний нөөц




Хүний нөөцийн удирдлага

ХасБанк олон талт ур чадвар бүхий ажилтнуудаас бүрдэх ажил хэрэгч соёлыг дэмжих, хүртээмжтэй ажиллах орчинг бүрдүүлэх, өрсөлдөхүйц хэмжээний цалин хөлс, урамшуулал олгох, шударгаар ажиллах, сурч хөгжих боломжийг ажилтнуудад олгох нь Хүний нөөцийн удирдлагын бодлого юм.


Бид төрөл бүрийн нийгмийн хөтөлбөрөөр дамжуулан ажилтнуудынхаа амьдралын чанарыг дээшлүүлэх, ажил амьдралын тэнцвэрт байдлыг хангаж ажиллахад тууштай байр суурийг баримталсаар ирсэн.

2021 оны эцсийн байдлаар ХасБанк 1,183 идэвхтэй ажилтантай ажилласан бөгөөд өмнөх онуудтай харьцуулбал 2020 онд 1,135, 2019 онд 1,195 ажилтантайгаар тус тус ажилласан. Ажилтнуудын дундаж нас 34.1, ХасБанканд ажилласан дундаж хугацаа 7.4 жил байна.

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн шаардлагын дагуу 2021 оны туршид нийт 196 ажилтны ажлын байрыг хүүхэд асрах чөлөөний хугацаанд нь хадгалсан бөгөөд хүүхэд асрах чөлөөнөөс 65 ажилтан ажилдаа эргэн орсон.



ИДЭВХТЭЙ АЖИЛТНУУД



Онцлох нь:

Харилцаа холбоог сайжруулах, идэвхжүүлэх, түргэн шуурхай мэдээлэл солилцох, нээлттэй харилцааг дэмжих зорилготой Workplace-т ажилтнууд маань хаанаас ч, хэзээ ч хоорондоо хялбархан харилцаж, халдварын нөхцөл байдалтай уялдуулан гаргаж буй аливаа шийдвэр, мэдээ, мэдээллийг цаг алдалгүй хүлээн авч чадсан.

2021 онд гэхэд Workplace-т 1.3 сая мессеж, 7.2 мянган пост, 140 мянган сэтгэгдлийг ажилтнууд маань үлдээсэн байх бөгөөд 100 орчим сонирхлын бүлгүүд үүссэн байна.

Байгууллагын соёлыг бэхжүүлэх, ажилтан бүр банкаараа бахархах, 20 жилийг ойг тэмдэглэн өнгөрүүлэх зорилгоор дараах арга хэмжээнүүдийг дотооддоо амжилттай зохион байгууллаа. Үүнд:



Хасын түүхүүд:
банкны түүхэн цуврал контентуудыг бэлтгэн ажилтнууддаа хүргэв.



ХасТанк:
шилдэг шинэ санал, санаачилгын уралдааныг амжилттай зохион байгуулсан.



Зураг түүх өгүүлнэ:
сэдвийн доор ажилтнууд маань өөрт байгаа нандин зургуудаа бусдадаа хуваалцсан.



Авъяаслаг Хасчууд :
тэмцээнийг онлайнаар амжилттай зохион байгуулж шилдэг оролцогчид маань шинэ жилийн арга хэмжээнд урилгаар оролцлоо.



ЕХасСур:
и-спортын төрлөөр ХасСур тэмцээнийг зохион байгуулж 200 ажилтан оролцлоо.



Виртуал арга хэмжээнүүд:
цахим хэлбэрээр улирлын болон жилийн тайлангийн хурлуудыг зохион байгууллаа.

Сургалт, хөгжил

Ажилтнуудын ажил, мэргэжлийн ур чадвар, мэдлэгийг сайжруулах үүднээс мэргэшсэн зэрэгт бэлтгэх сургалт, олон улсын мэргэжлийн зэрэг олгох сургалт, сургагч багшийн сургалт, хөтөлбөрүүдэд зорилтот ажилтнуудыг хамруулахаас гадна салбар, тооцооны төвийн ажилтнуудад зориулж тэдний албан тушаалд нь шаардагдах сургалтуудыг зохион байгуулж нийт 226,331 хүн/цагийн сургалтыг давхардсан тоогоор 2,010 ажилтанд зохион байгуулсан байна. (2020 онд 27,336 хүн/цаг, 2019 онд 26,840 хүн/цаг, 2018 онд 47,324 хүн/цаг).

Коронавируст халдварын онцгой нөхцөл байдалд ч гэсэн сургалтын хүртээмжийг сайжруулах, хаанаас ч хандаж сургалт авах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор банкныхаа ажилтнуудын сургалт, хөгжлийн тасралтгүй байдлыг хангахын тулд нийт сургалтын 97.8 хувийг онлайн хэлбэрээр амжилттай зохион байгуулсан нь 2020 оны 4 дүгээр улиралд олон улсын Онлайн сургалтын платформ болох TalentLMS-ийг ашиглаж эхэлсэнтэй салшгүй холбоотой. 2021 онд нийт 57 удаагийн онлайн сургалтад 1,622 ажилтныг давхардсан тоогоор хамруулж 221,403 хүн.цагийн сургалтыг зохион байгуулсан байна.

Сургалтын статистик мэдээлэл:	2021	2020
Сургалтын нийт хөрөнгө оруулалт	126.9	91.0
Нийт хүн цаг	226,331	27,336
Сургалтанд хамрагдсан ажилтны тоо	2,010	1,077

Хүний НӨӨЦ



Менежмент болон манлайллын сургалт:

- “Тодорхойгүй нөхцөл байдал дахь манлайлал” сургалтад банкны нийт удирдах ажилтнуудаа хамрууллаа.
- Гүрэн Академитай хамтран “Дэлхийн Түвшний Менежер” бэлтгэх хөтөлбөрт 20 удирдах ажилтан хамрагдлаа.

Иргэдийн банк:

- Монголын Банкны Холбоо болон ХБНГУ-ын Шпаркассэ Банкны Сангийн хамтарсан төслийн хүрээнд зохион байгуулагддаг “Банкны мэргэжилтэн бэлтгэх” хөтөлбөрт хамтарч ажиллалаа.
- Бизнесийн зээлийн мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор зээлийн судалгаа шинжилгээ, зээл олголт болон олгосны дараах хяналт зэрэг агуулгын хүрээнд ХасБанкны нийт Бизнесийн зээлийн ажилтнуудад танхимын сургалт амжилттай зохион байгууллаа.
- Салбар, тооцооны төвийн ажилтнуудад хөрөнгийн үнэлгээ хийх эрх олгох сургалтыг зохион байгууллаа.
- Салбарын ажилтнуудын мэргэжлийн мэдлэгийг сэргээх, ур чадварын түвшинг тогтоох, сургалтын хэрэгцээг тогтоох зорилгоор 2020 оноос эхлэн ур чадварын түвшин тогтоох, үнэлэх шалгалт авч эхэлсэн. 2021 онд уг шалгалтад салбарын нийт ажилтнууд хамрагдсанаас 92% нь тэнцлээ.

Хянан нийцүүлэлт:

- Тогтвортой хөгжил, ногоон эдийн засаг, Монгол Улс дахь тогтвортой санхүүжилтийн талаарх мэдлэг олгох зорилготой Тогтвортой санхүүжилтийн сургалтыг 300 гаруй ажилтнуудад онлайн хэлбэрээр зохион байгуулжээ.
- Банк санхүүгийн академитэй хамтран удирдах албан тушаалд шинээр ажиллаж буй болон банканд шинээр ажилд орсон нийт 100 гаруй ажилтныг Хянан нийцүүлэлтийн цахим сургалтад хамруулсан.

Мэдээллийн технологийн сургалт:

Банк мэдээллийн технологийн ажилтнуудаа олон улсын мэргэжлийн зэрэг авах, олон улсын түвшинд ажиллах чадвар олгох сургалтуудад хамруулахад анхаарч ажилладаг бөгөөд 2021 оны онцлог сургалтуудыг дурдвал:

- PMP, PMI certification training;
- VMWare VCP 7.0 configuration management;
- SQL, PYTHON;
- CCNA /Cisco Certified Network Associate/.

Цалин хөлс, хангамж, сайн сайхан оршихуй

Тогтвортой, өндөр гүйцэтгэлийг дэмжих цалин, урамшууллын бодлогыг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангаж, ажилтнуудынхаа цалин хөлсийг шат дараатайгаар нэмэгдүүлж, гүйцэтгэлийн урамшууллыг нийт ажилтнууддаа олголоо. Мөн урт хугацаат урамшууллын бодлогын хүрээнд Хувьцааны үнэд суурилсан урамшууллын хөтөлбөрөө үргэлжлүүлэн хэрэгжүүллээ.

Ажилтнуудынхаа санхүүгийн баталгааг хангах, ажилтанд нэмэлт тэтгэврийн хуримтлал бий болгох зорилготой хувийн тэтгэврийн хөтөлбөрийг 2007 оноос хойш амжилттай хэрэгжүүлж байна. Мөн ажилтнуудынхаа нийгмийн асуудлыг дэмжих, эрүүл мэндийг хамгаалахад зориулж жил бүр гэнэтийн осол, эрүүл мэндийн даатгалд хамруулж байна.

Тэдний ая тухтай амьдрах орчныг сайжруулах, орон сууцны зээлд хамрагдах боломж, хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд ажилтнуудад зориулсан орон сууцны зээлийн урьдчилгаа төлбөр болон хүүг буурууллаа.

Ажил амьдралын шинэ хэв маягт банкны бизнесийн тасралтгүй үйл ажиллагаа хангаж ажиллах, зайнаас болон гэрээс ажиллах боломжийг бүрдүүлж ажилтнуудынхаа эрүүл аюулгүй ажиллах орчин нөхцөлийг бий болгоход чиглэж ажиллалаа.

Коронавируст халдварын онцгой нөхцөл байдалд ажилчдынхаа эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг ханган ажиллах бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж халдвар хамгааллын хэрэгслээр хангах, коронавируст халдварыг илрүүлэх түргэвчилсэн болон PCR шинжилгээнд хамруулах, короновируст халдвараар өвчилсөн, хөл хорио тусгаарлалтад орсон ажилтнуудынхаа цалин хөлсийг 100% олгох, томуу, томуу төст өвчнөөр өвдсөн ажилтнууддаа гурав хүртэлх өдрийн цалинтай чөлөө олгох зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлсэн нь ажилтнуудынхаа цалин, орлогыг тасалдуулалгүй, эрүүл мэндийг хамгаалах бодит дэмжлэг болж, ажилтнуудын сэтгэл ханамж өндөр байна.



1 өдөр

Төрсөн өдрийн цалинтай чөлөө



2 өдөр

Гүйцэтгэх захирлын нэрэмжит цалинтай чөлөө



3 өдөр

Томуу, томуу төст өвчнөөр өвчилсөн бол 3 хүртэлх өдрийн цалинтай чөлөө

Банкны засаглал

➤ Нийтэд хувьцаа санал болгох бэлтгэл ажлын хүрээнд засаглалыг бататгах нь

Зохистой засаглал нь ХасБанкны байгууллагын соёл, үнэт зүйлсийн салшгүй хэсэг. Бид ирж буй жилд нийтэд хувьцаа санал болгохоор бэлдэж эхэлснээр ХасБанкны зохистой засаглалын хувьд 2021 он нэн чухал он болж байна.

Жилийн туршид бидний анхаарал засаглалын үйл ажиллагаагаа бататган сайжруулах, цаашид нийтэд хувьцаа нь арилжаалагддаг компани болох гэж буйн хувьд зохицуулагч байгууллага, хөрөнгө оруулагчдын илүү хатуу хяналт, шаардлагад нийцэн ажиллаж жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалахад чиглэсэн мэдээллийн шаардлагуудыг хангаж чадахуйц зохистой компанийн засаглалтай байхад чиглэсэн.

Дэлхий дахинаа тархсан Ковид-19 цар тахал манай Банкны сэргэлт, тогтвортой өсөлтийг үргэлжлүүлэн сорьсоор байна. Жилийн туршид ТУЗ, хувьцаа эзэмшигчид болон гүйцэтгэх удирдлагаас цар тахлаас үүдэлтэй хямралын нөхцөлд хариу арга хэмжээ, эдийн засаг бизнесийг сэргээх төлөвлөгөө хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажилласан бөгөөд ингэхдээ байгууллагын урт хугацааны зорилт, хувьцаа эзэмшигчид болон бусад нэгдмэл сонирхолтой талуудын урт хугацааны ашиг сонирхлыг орхигдуулахгүй байхад анхаарч ажилласан.

Хувьцаа эзэмшигчид

- Нээлттэй хувьцаат компани болох бэлтгэл ажлыг бүхий л талаас хангах, хувьцааны үнэ цэнийг урт удаан хугацаанд хадгалах зорилгоор оновчтой шийдвэрүүд гарган ажилласан байна.

ТУЗ

- Цаашид өсөлтийг дэмжих болон хадгалах зорилгоор гүйцэтгэх удирдлагад дэмжлэг үзүүлж, оновчтой шийдвэрүүдийг цаг тухайд нь гаргаж ажилласан.
- Нээлттэй компани болох хүлээлтэд хүрэхийн тулд ТУЗ-ийн хараат бус дүн шинжилгээ хийн, арвин туршлагаараа тэргүүлж удирдлагаар хангав.

Гүйцэтгэх удирдлага

- Ирээдүйд амжилттайгаар хувьцаа гаргах зорилгоор санхүүгийн н байр суурийг бататгах, активын чанарыг сайжруулахад анхаарч дотоод бүтцийн өөрчлөлтийн талаар стратегийн шийдвэр гаргасан
- Банкны өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, цахим шилжилтийг үргэлжлүүлэх, харилцагчдын үйлчилгээг сайжруулах чиглэсэн урт хугацааны зорилтуудыг үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн.

Жилийн тайланд дурдагдсан энэ хэсэг нь Компанийн засаглал, хянан нийцүүлэлтийн хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны товч тайлан бөгөөд холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын заалтуудыг дагаж мөрдөх, тайлагнах үүрэгтэй.

Банкны засаглал

➤ ЗАСАГЛАЛЫН БҮТЭЦ

ХасБанк нь Монгол Улсын санхүүгийн томоохон компаниудын нэг болох ТэнГэр Санхүүгийн Нэгдэл /TCH/ ХХК-ийн бүрэн эзэмшлийн охин компани юм. ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК нь олон улсын санхүүгийн байгууллага, дотоодын болон гадаадын нэр хүндтэй компани, хөрөнгө оруулалтын сан, төрийн бус байгууллага болон хувь хүмүүсээс бүрдсэн хувьцаа эзэмшигчдийн бүтэцтэй. ТэнГэр Санхүүгийн Нэгдэл нь ХасБанкны хувьцааг ганцаар эзэмшдэг болно.

Банкны эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд Банкны засаглалын дотоод журмын дагуу толгой компани TCH ХХК-ийн хувьцаа эзэмшигчид Банкны хувьцаа эзэмшигчийг төлөөлдөг.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт хувьцаа эзэмшигчдээс сонгогдсон төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”) нь хувьцаа эзэмшигчдийн мэдэлд хамрагдахаар тусгайлан заасан асуудлуудаас бусад бүх асуудлаар шийдвэр гаргадаг. ТУЗ нь Банкны стратеги, бодлогыг тодорхойлж, эдгээр зорилгод хүрэхэд шаардлагатай санхүүгийн болон хүний нөөцийг бүрдүүлэх төлөвлөгөөг батлах зэргээр Банкнийг стратегийн удирдлагаар хангадаг. ТУЗ нь Банкны үйл ажиллагаа хууль тогтоомж, дотоод журам, батлагдсан төлөвлөгөө, төсвийн хүрээнд Банктай нэгдмэл сонирхолтой бүх талуудын эрх ашгийн төлөө явагдаж буй эсэхэд хяналт тавьж, эрсдлийг илрүүлж, үнэлж, удирдахын тулд дотоод хяналтын зохистой тогтолцоог бүрдүүлж ажилладаг.

ТУЗ нь эрх үүргээ хэрэгжүүлж, үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулах үүднээс байнгын хороодыг байгуулж, хороод нь ТУЗ-өөс өгсөн тодорхой чиг үүргийн дагуу ТУЗ-ийн хэлэлцэх асуудлуудаар зөвлөмж дүгнэлт гаргаж ТУЗ-д танилцуулдаг, мөн ТУЗ-өөс өгсөн эрх мэдлийн хүрээнд тодорхой асуудлаар шийдвэр гаргадаг. Яаралтай эсвэл онцгой асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор бусад түр хороог байгуулж ажиллуулдаг. Банкны өдөр тутмын үйл ажиллагааг ТУЗ-өөс томилогдсон гүйцэтгэх захирал удирдаж явуулдаг. Гүйцэтгэх захирал нь Банкнийг төлөөлөн ажиллаж, хувьцаа эзэмшигчид болон ТУЗ-д тогтмол тайлагнах үүрэгтэй.

➤ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Цар тахлын халдвар тархахаас сэргийлэх олон нийтээс зай барих арга хэмжээнүүд хэрэгжиж байгаа энэ үед 2021 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг биечлэн мөн цахим хэлбэрийг хослуулсан байдлаар зохион байгуулж явуулсан. 2021 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар Ковид-19 цар тахлын нөлөө, ТУЗ болон гүйцэтгэх удирдлагаас авч хэрэгжүүлж байгаа хариу арга хэмжээнүүд, Банкны жилийн үр дүн, үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, 2021 оны аудитлагдсан санхүүгийн тайлан тэнцэлийг авч хэлэлцсэн. Хувьцааг нийтэд салан болгох ажилд илүү их ач холбогдол өгч стратеги шийдвэрүүд гаргахад анхаарч ажилласан.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар 2020 оны үр дүнгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн. Уг шийдвэр нь Банкны түүхэнд тэмдэглэгдэх үйл явдал бөгөөд хувьцааг нийтэд санал болгохоос өмнө хөрөнгө оруулагчдадзохистой ойлголтыг түгээж буй хэрэг юм. .

Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах өдрөөс өмнө зарим ТУЗ-ийн гишүүдийн хуанлийн хоёр жил гэж тогтоосон 2 жилийн бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болж байгаатай холбогдуулан ТУЗ-ийн гишүүдийн сонгуулийг Компанийн тухай хууль болон дотоод журмын заалтуудын дагуу онлайн санал хураалтаар хуралдсан хурлаар явуулсан.

Тайлант хугацаанд хувьцаа эзэмшигчид, ТУЗ болон гүйцэтгэх удирдлага шийдвэрүүдийн талаар мэдээлэл солилцож, хувьцаа эзэмшигчдийг эрхээ хэрэгжүүлэх боломжоор хангаж, хувьцаа эзэмшигчдийн шийдвэр гаргалтыг дэмжиж ажилласан.

➤ ТУЗ-ИЙН МАНЛАЙЛАЛ

2021 онд ТУЗ-өөс Банкны тогтвортой байдлыг хамгаалах, Ковидын нөхцөлд ажиллаж байгаа Банкны гүйцэтгэх удирдлагад стратегийн удирдлага, дэмжлэг үзүүлж ажилласнаас гадна нээлттэй хувьцаат компанийн үйл ажиллагаатай холбоотой шинэлэг хууль тогтоомж, дүрэм журмыг хэрэгжүүлэхэд чиглэсэн стратегийн удирдамжаар ханган ажилласан.

ТУЗ-ийн бүтэц

ТУЗ нь ТУЗ-ийн гишүүн бүрийг асуудлын хэлэлцүүлэгт оролцуулж үр дүнтэй үйл ажиллагааг хангах, нөхцөл байдлыг өргөн цар хүрээтэй харж дүгнэлт гаргаж, түүнийгээ үндэслэн оновчтой шийдвэр гаргахад ТУЗ-ийн бүтэц, гишүүдийн тоо, чадвар, мэргэшсэн дадлага туршлага, гүйцэтгэх удирдлагын төлөөлөл, хараат бус гишүүдийн оролцоо нь нэн чухал ач холбогдолтой гэсэн зарчмаар ажилладаг. Банкны тулгарч буй асуудлуудыг ойлгож шийдвэрлэх, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавьж, чиглүүлэхэд ТУЗ-ийн гишүүдийн банкны салбарын мэдлэг боловсрол, туршлага, мэргэжлийн ур чадвар, жендер, харъяаллын тэнцвэртэй байдал чухал гэдгийг хүлээн зөвшөөрч, Банкны стратегийн чиглэлтэй уялдуулан ТУЗ-ийн бүрэлдэхүүн, бүтцийг үнэлж нягталж, өөрчлөх шаардлагатай эсэх талаар дүгнэлт зөвлөмж гаргадаг.

2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар ТУЗ нь нийт 10 гишүүний бүрэлдэхүүнтэй ажилласнаас гүйцэтгэх удирдлагын төлөөлөл болох нэг гишүүн, Хувьцаа эзэмшигчдээс нэр дэвшүүлсэн 5 гишүүн, 3 хараат бус гишүүн байна. ТУЗ-ийн даргын үүргийг хувьцаа эзэмшигч бус, аливаа хувьцаа эзэмшигчийн холбогдох, нэгдмэл сонирхолтой этгээд бус, хараат бус байр суурьтай гишүүн гүйцэтгэдэг. ТУЗ-ийн бүрэлдэхүүнд банкны салбарын олон талын туршлагатай, ур чадвартай гишүүд ажилладаг.

#	Нэр	Албан тушаал	Төлөөлөл
1	Санжай Гүпта	ТУЗ-ийн дарга	Хараат бус
2	Гүмэнжавын Цэвэгжав	ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал	-*
3	Альбертус Браггинк	ТУЗ-ийн гишүүн	ОРИКС
4	Андрезеж Витак	ТУЗ-ийн гишүүн	ЕСБХБ
5	Майкл Мадден	ТУЗ-ийн гишүүн	Ронок Партнерз
6	Нямтайширийн Цэлмүүн	ТУЗ-ийн гишүүн	МАК ХХК
7	Ив Жако	ТУЗ-ийн гишүүн	Канадын Үндэсний Банк
8	Баянсаны Уламбаяр	ТУЗ-ийн гишүүн	Хараат бус
9	Нираж Вэдва	ТУЗ-ийн гишүүн	Хараат бус
10	Морис Лам	ТУЗ-ийн гишүүн	Хараат бус

*Дүрэмд заасны дагуу

Банкны засаглал

ТУЗ-ийн гишүүд



Санжай Гүпта
ТУЗ-ийн дарга

Санжай Гүпта ХасБанк болон түүний толгой компани Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн ТУЗ-ийн даргаар 2019 оны 3 дугаар сарын 28-ны өдөр томилогдсон. ТУЗ-ийн даргаар томилогдохоос өмнө тэрбээр Олон Улсын Санхүүгийн Корпораци (IFC)-аас нэр дэвшиж сонгогдсон ТУЗ-ийн гишүүнээр 2 жил ажиллаж бөгөөд энэ хугацаанд ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүн, Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны гишүүнээр, сүүлийн нэг жилийн хугацаанд тус хорооны даргаар ажиллаж байсан. Санжай Гүпта 2019, 2021 онуудад Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар 2 жилийн бүрэн эрхийн хугацаатайгаар улиран сонгогдсон. ТУЗ-ийн даргаар томилогдоход Санжай Гүпта-гийн ОУСК-ийн төлөөллийн мандат нь дуусгавар болж, тэрбээр бие даасан, аливаа хувьцаа эзэмшигчээс хараат бус байр суурьтай болсон. Санжай Гүпта Банк оф Америка (Bank of America), Креди Агриколь Групп (Credit Agricole Group)-ын Ази, Номхон Далай, Европ, Ойрхи Дорнод болон Африкийн бүс нутаг, БНЭУ дахь салбаруудад удирдах албан тушаал хашиж, олон улсын банкны салбарт 34 жил ажилласан туршлагатай.



Гүмэнжавын Цэвэгжав
ТУЗ-ийн гишүүн ба
Гүйцэтгэх захирал

Гүмэнжавын Цэвэгжав 2019 оны 5-р сарын 8-ны өдрөөс ХасБанкны Гүйцэтгэх захирлаар томилогдож, 2020 оны 4 дүгээр сарын Хувьцаа эзэмшигчдийн хурлаар ХасБанкны гүйцэтгэх захирлын бүрэн эрхийг хэрэгжүүлэх хугацаанд Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнээр сонгогдон ажиллаж байна. Г.Цэвэгжав мөн Тэнгэр Даатгал ХХК-ийн ТУЗ-ийн даргаар ажилладаг. Үүнээс өмнө тэрбээр ХасБанк, ТСН ХХК-ийн хэмжээнд 2011 оноос хойш ХасБанк, ТСН ХХК-ийн Санхүү хариуцсан захирал, Хас Лизинг ХХК-ийн Гүйцэтгэх захирал, ХасБанкны Иргэдийн банк хариуцсан захирал, Ерөнхий захирлаар тус тус ажиллаж байсан. ХасБанк, ТСН ХХК-д ажиллаж эхлэхээс өмнө тэрбээр 2004-2011 онуудад АНУ-д томоохон компаниудад хөрөнгө зохицуулалтын менежер, санхүүгийн шинжээчээр ажиллаж амьдарч байсан.




Нямтайширийн Цэлмүүн
ТУЗ-ийн гишүүн

Нямтайширийн Цэлмүүн нь 2013 онд Хувьцаа эзэмшигчдийн хурлаар ТУЗ-ийн гишүүнээр сонгогдсон бөгөөд 2015, 2017, 2019, 2021 онуудад улиран сонгогдсон. Н.Цэлмүүн ТУЗ-ийн Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүн, Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны гишүүнээр тус тус ажилладаг. Тэрээр Монголын томоохон компаниудын нэг болох Монголын Алт /МАК/ ХХК-ийн Ерөнхийлөгч, ТУЗ-ийн гишүүнээр ажилладаг.



Альбертус Браггинк
ТУЗ-ийн гишүүн

Албертус Браггинк нь ОРИКС Корпораци (ORIX Corporation)-аас нэр дэвшиж, 2020 оны 6-р сараас Хувьцаа эзэмшигчдийн дараагийн хурал хүртэл ХасБанкны ТУЗ-ийн гишүүнээр ТУЗ-ийн шийдвэрээр түр томилогдож, 2021 оны Хувьцаа эзэмшигчдийн хурлаар ТУЗ-ийн Эрсдэлийн удирдлагын хороо, Аудитын хорооны гишүүний хамтаар ТУЗ-ийн гишүүнээр сонгогдсон. Альбертус Браггинк нь Нидерландын олон улсын санхүүгийн байгууллага болох Rabobank-д 30 жил ажилласан туршлагатай мэргэшсэн банкир юм. Тэрбээр мөн Rabobank-аас гадна JP Morgan, Robeco групп, Нидерландын Хөгжлийн Агентлаг (FMO Dutch Development Bank), Нидерландын Friesland банк зэрэг нэр хүндтэй санхүүгийн байгууллагуудад ТУЗ-ийн түвшинд ажиллаж байсан туршлагатай.



Андрезеж Витак
ТУЗ-ийн гишүүн

Андрезеж Витак нь Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (EBRD)-наас нэр дэвшиж, 2019 оны 3 дугаар сард Хувьцаа эзэмшигчдийн хурлаар ХасБанкны ТУЗ-ийн гишүүнээр 2 жилийн хугацаанд сонгогдон ажиллаж байгаад 2021 оны хурлаар дахин 2 жилийн хугацаагаар улиран сонгогджээ. Андрезеж Витак ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны гишүүн, Аудитын хорооны гишүүнээр тус тус ажилладаг. Андрезеж Витак Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банкинд олон жил ажилласан туршлагатай мэргэшсэн банкир бөгөөд одоогоор чанаргүй актив, эрсдэлтэй зээлийн удирдлагын чиглэлээр хэрэгжүүлж буй тодорхой төслүүдэд бие даасан зөвлөхөөр ажиллаж байна. Тэрээр 1997-2007 онд Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банкны Узбекистан дахь Суурин төлөөлөгчийн газрын захирал, Суурин төлөөлөгч, Украин дахь Суурин төлөөлөгчийн газрын Орлогч захирал, Польш, ОХУ, Монгол Улс, хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан орнууд болон Зүүн Европын орнууд дахь байгууллагуудад ТУЗ-ийн гишүүнээр тус тус ажиллаж байв.

Банкны засаглал

Board of directors



Майкл Мадден
ТУЗ-ийн гишүүн

Майкл Мадден 2009 оноос ХасБанкны ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байна. Майкл Мадден 2011, 2013, 2015, 2017, 2019, 2021 онуудад Хувьцаа эзэмшигчдийн хурлаар тус тус улиран сонгогдсон болно. Майкл Мадден ТУЗ-ийн Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны даргаар ажилладаг. Тэрээр 2007 онд байгуулагдсан Ирландын Дублин хотод байрладаг Ронкок компани, Нью Йорк хотод 2011 байгуулагдсан Тенео Капитал, 2015 онд Мьянмарт байгуулагдсан Ронкок Ази буюу Онго компаниудын үүсгэн байгуулагч, удирдах түнш/захирлаар ажилладаг.



Ив Жако
ТУЗ-ийн гишүүн

Ноён Ив Жако нь Канадын Үндэсний Банкнаас нэр дэвшиж, 2016 оны 3 дугаар сард ХасБанкны ТУЗ-ийн гишүүнээр анх сонгогдож, 2018, 2020 онуудад 2 жилийн хугацаатай тус тус улиран сонгогдсон бөгөөд 2022 оны 3 дугаар сарын Хувьцаа эзэмшигчдийн хурлаар түүнийг улируулан сонгох сонгууль явагдана. Ив Жако ТУЗ-ийн Эрсдэлийн удирдлагын хорооны дарга, Аудитын хорооны гишүүнээр ажилладаг. Тэрээр Канадын Үндэсний Банкны олон улсын үйл ажиллагааг хариуцсан Тэргүүн Дэд Ерөнхийлөгч, мөн Канадын Үндэсний Банкны охин компани болох NATCAN International компанийн Дэд захирлаар ажилладаг. Ив Жако мөн Камбоджийн АВА Банк, Ливаны Byblos Банк, Тайландын АТА компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний үүрэгт ажлыг гүйцэтгэдэг.



Нираж Вэдва
ТУЗ-ийн хараат бус гишүүн

Нираж Вэдва 2018 оны 6 дугаар сард ТУЗ-ийн шийдвэрээр ХасБанкны ТУЗ-ийн хараат бус гишүүнээр түр томилогдож, 2019 онд Хувьцаа эзэмшигчдийн хурлаар ТУЗ-ийн хараат бус гишүүнээр 2 жилийн хугацаагаар сонгогдсон бөгөөд 2021 оны Хувьцаа эзэмшигчдийн хурлаар түүнийг дахин 2 жилийн хугацаатайгаар улируулан сонгожээ. Нираж Вэдва ТУЗ-ийн Аудитын болон Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүнээр ажилладаг. Тэрээр 30 гаруй жил банкны өөрчлөн байгуулалт, мэдээллийн технологийн чиглэлээр ажилласан туршлагатай. Нираж Вэдва нь Дубай хотод байрладаг Acceleric FZ LLE мэдээллийн технологийн зөвлөгөөний компанийн үүсгэн байгуулагч, гүйцэтгэх захирал бөгөөд үүнээс өмнө тэрээр Энэтхэг Улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй Тек Махиндра (Tech Mahindra) мэдээллийн технологийн компани, Швейцар Улсын Теменос компанид удирдлагын албан тушаалд, 1987-1999 онуудад Энэтхэгт мэдээллийн технологийн Nucleus Software зэрэг компаниудад ажиллаж байсан ажилласан туршлагатай.



Баянсаны Уламбаяр
ТУЗ-ийн хараат бус гишүүн

Баянсаны Уламбаяр нь 2015 оны 7 сараас ХасБанкны ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдон ажиллаж байна. Б.Уламбаяр 2018, 2020 онуудад Хувьцаа эзэмшигчдийн хурлаар ТУЗ-ийн хараат бус гишүүнээр хоёр удаа улиран сонгогдсон бөгөөд 2022 оны 3 дугаар сарын Хувьцаа эзэмшигчдийн хурлаар түүнийг улируулан сонгох сонгууль явагдана. Б.Уламбаяр ТУЗ-ийн Аудитын болон Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүнээр ажилладаг. Б.Уламбаяр Говь Бизнес Финанс ХХК-ийн үүсгэн байгуулагч түнш, зөвлөхөөр ажилладаг. Тэрээр хөрөнгө оруулалтын банкны чиглэлээр мэргэшсэн олон улсын хэмжээнд Токио хотод Леман Бродерс, Номура Секьюритис зэрэг хөрөнгө оруулалтын банкнуудад ажилласан туршлагатай. Монголд эргэж ирснийхээ дараа тэрээр Драпер Капитал, Композит Капитал, Монет зэрэг хөрөнгө оруулалтын сан, компаниудад зөвлөх болон захирлаар, мөн Алтай Холдинг ХХК-д ерөнхий захирлаар ажилласан байсан.



Морис Лам
ТУЗ-ийн хараат бус гишүүн

Морис Лам нь ХасБанкны ТУЗ-ийн хараат бус гишүүнээр 2019 оны 3 дугаар сард ТУЗ-ийн шийдвэрээр түр томилогдож, 2020 онд Хувьцаа эзэмшигчдийн хурлаар ТУЗ-ийн хараат бус гишүүнээр 2 жилийн хугацаагаар сонгогдсон. Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 3 дугаар сарын хурлаар түүнийг улируулан сонгох сонгууль явагдана. Морис Лам олон улсын банк санхүүгийн салбарт 40 гаруй жил ажилласан туршлагатай. Тэрээр одоо гэр бүлийн бизнесүүдэд зориулсан бизнесийн стратеги, засаглалын чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлдэг Сингапурт байрладаг Stewardship Consulting компанийг үүсгэн байгуулж, захирлаар нь ажиллаж байна. 1999 онд энэ хувийн бизнесийг эхлүүлхээс өмнө тэрээр олон улсын банкны салбарт Нью-Йорк, Сингапур, Токио болон Лондон хотуудад ажиллаж амьдарч байсан.

Банкны засаглал

➤ ТУЗ-ийн үүрэг

ТУЗ-ийн дарга, Гүйцэтгэх захирлын үүрэг

ТУЗ-ийн дарга болон Банкны Гүйцэтгэх захирлын үүргийг өөр өөр хүн гүйцэтгэх ба энэ талаар Банкны дүрэмд тодорхой заагдсан байдаг. ТУЗ-ийн дарга болон Банкны Гүйцэтгэх захирал хоорондоо уялдаа холбоотой, эрх мэдлийн тэнцвэртэй харилцаатай ажиллаж, шийдвэр гаргалтад бие даасан байдалтай оролцдог.

2019 оны 3 дугаар сараас эхлэн ТУЗ-ийн даргаар Санжай Гүпта ажиллаж байна, ТУЗ-ийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж удирдах, ТУЗ-өөс гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, үнэлэх ажлыг удирдах, ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудлыг тодорхойлж боловсруулах, хурлаар асуудал бүрийг зохистой түвшинд хэлэлцэж, гишүүн тус бүрээс хэлэлцүүлэгт оролцож санал гаргах явдлыг дэмжин ажилладаг. ТУЗ-ийн дарга шийдвэр гаргах явцад ТУЗ-ийг удирдаж, ТУЗ-ийн багийн ажиллагааг хангаж ажилладаг. Үүнээс гадна ТУЗ-ийн дарга Гүйцэтгэх захирлыг чиглүүлж, удирдлага зөвлөмжөөр хангаж, хяналт тавьж ажилладаг.

2019 оны 3 сараас эхлэн ХасБанкны Гүйцэтгэх захирлаар Гүмэнжавын Цэвэгжав ажиллаж байна, Гүйцэтгэх захирал нь банкны өдөр тутмын удирдлага, үйл ажиллагааг удирдаж, ТУЗ-өөс батлагдсан стратеги, зорилт, бодлогыг хэрэгжүүлж ажилладаг. Гүйцэтгэх захирал нь стратегийн болон бизнесийн төлөвлөгөө, бүтэц зохион байгуулалт, хяналтын систем, дотоод дүрэм журмыг боловсруулах ажлыг хариуцдаг.

ТУЗ-ийн гишүүний үүрэг

ТУЗ-ийн гишүүн Банкны гүйцэтгэх захирлыг стратегийн удирдлагаар хангах, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг сорих хянах үүрэг гүйцэтгэдэг. Нэр дэвшүүлсэн хувьцаа эзэмшигчийн төлөөлөл болохоос гадна ТУЗ-ийн гишүүн нь нэн тэргүүнд Банк болон нийт хувьцаа эзэмшигчид, нэгдмэл сонирхолтой талуудын ашиг сонирхлын төлөө үнэнч хараат бус байдлаар ажиллах үүрэгтэй.

ТУЗ-ийн хараат бус гишүүний үүрэг

ТУЗ-ийн хараат бус гишүүн Банкны гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлагыг хараат бус байдлаар хянаж, хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, ТУЗ-ийн шийдвэрийн талаар зөрүүтэй байр суурьтай байсан бол энэ тухайгаа мэдээлж, хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулах, тодруулга хийх үүрэг гүйцэтгэдэг.

➤ ТУЗ-ийн гишүүдийг сонгох, улируулан сонгох

ТУЗ-ийн гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар 2 жилийн хугацаатай сонгодог. ТУЗ-ийн гишүүд дахин сонгогдох эрхтэй. Сонгуулийн хугацаа дуусах үед гишүүн үүрэгт ажлаа өгнө эсвэл хувьцаа эзэмшигчдийн хурлаар дахин сонгогдоно. ТУЗ-д орон тоо гарах эсхүл Дүрэмд заасан бусад нөхцөл байдал үүсэх тохиолдолд ТУЗ-ийн гишүүнийг ТУЗ-ийн шийдвэрээр түр томилж, хувьцаа эзэмшигчдийн дараагийн ээлжит хурлаар оруулж батлуулдаг. Түр томилогдсон гишүүн нь ТУЗ-ийн гишүүний бүх эрх, үүргийг эдэлнэ.

ТУЗ-ийн гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, сонгох, улируулан сонгох, чөлөөлөх журам нь Банкны дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны дотоод журам болон ТУЗ-ийн гишүүдийг нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулах журамд тусгагдсан байдаг. Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн Яамны хамтарсан тушаалаар батлагдсан “Банкны ТУЗ-ийн хараат бус гишүүдийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам” болон бусад холбогдох хууль тогтоомжийн заалтыг дагаж мөрдөх үүднээс 2017 онд Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж, хараат бус гишүүний талаарх тусдаа заалт оруулсан.

ТУЗ-ийн дараах гишүүдийг 2022 оны хувьцаа эзэмшигчдийн хурлаар сонгох эсхүл улируулан сонгохоор оруулж батлуулна.

• *Ив Жако (улируулан сонгох)*
• *Б.Уламбаяр (улируулан сонгох)*
• *Моррис Лам (улируулан сонгох)*
• *Олон Улсын Санхүүгийн Корпорациас дэвшүүлэх шинэ нэр дэвшигч (сонгох)*

ТУЗ-ийн Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо нь ТУЗ-ийн бүрэлдэхүүн, ТУЗ-ийн гишүүнд тавигдах шаардлага, гишүүдийг сонгон шалгаруулах журам боловсруулах, ТУЗ-ийн гишүүнд, түүнчлэн хараат бус гишүүнд нэр дэвшигчид ТУЗ-ийн гишүүнд тавигдах шаардлагыг хангасан эсэхийг үнэлэн шалгаж, ТУЗ-д зөвлөмж гаргаж танилцуулах асуудлыг хариуцдаг.

Хуульд заасны дагуу төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшиж байгаа этгээд нь хуульд заасан шалгуурыг хангаж байгаа эсэхийг Банкнаас хүргүүлсэн мэдээлэлд үндэслэн Монголбанк тогтоож, энэ тухай мэдэгддэг. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн дотроос ТУЗ-ийн хурлаар сонгодог.

➤ ТУЗ-ийн хурал

ТУЗ нь Банкны дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны дотоод журмын дагуу үйл ажиллагаагаа явуулдаг. ТУЗ-ийн үйл ажиллагааны гол хэлбэр нь ТУЗ-ийн хурал бөгөөд хурлын шийдвэрийг тогтоолоор баталгаажуулж гаргадаг. ТУЗ-ийн ээлжит хурлын чөлөөт цагт ТУЗ-ийн үйл ажиллагааг онлайн болон холбооны бусад хэрэгсэлээр дамжуулан явуулж эчнээ санал хураалтаар шийдвэр гаргадаг.

2021 онд Ковид цар тахлаас үүдэлтэй хөдөлгөөний хязгаарлалт болон бусад хамгаалалтын арга хэмжээнүүдийн нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөг бууруулах, ТУЗ-ийн үйл ажиллагаа, шийдвэр гаргалтыг тасралтгүй явуулахын тулд ТУЗ нь уян хатан бодлогоо үргэлжлүүлэн хэрэгжүүлж, үйл ажиллагааны цахим хэлбэрт шилжсэн.

- Skype, Webex, Zoom зэрэг харилцааны холбооны хэрэгслүүдээр дамжуулан ээлжит болон бусад хурлуудыг зохион байгуулж хуралдуулсан.
- Ээлжит хурлын чөлөөт цагт онлайн санал хураалтаар шийдвэр гаргах явдлыг түлхүү ашигласан.
- Шийдвэр тогтоолыг цахим хэлбэрээр онлайн санал хураалтаар шийдвэрлэж гаргасан.
- Ээлжит хурлын чөлөөт цагт сар бүр ТУЗ-ийн мэдээллийн чанартай онлайн уулзалтуудыг зохион байгуулсан.

2021 онд ТУЗ-ийн 4 ээлжит, 3 удаагийн ээлжит бус хурал, 12 онлайн санал хураалтын хурлуудыг хуралдуулж, ТУЗ-ийн мэдээлэл солилцох 2 удаагийн онлайн хэлэлцүүлэг зохион байгуулж хуралджээ. Бүх хурлыг цахимаар Webex ба Zoom харилцаа холбооны хэрэгслүүдээр дамжуулан хуралдуулсан.

2021 онд ТУЗ нь 42 тогтоол шийдвэр гаргасан ба үүнээс 4 тогтоол шийдвэрийг ТУЗ-ийн хурлыг хуралдуулалгүйгээр онлайн санал хураалтаар гаргасан болно.

Банкны гүйцэтгэх удирдлагын багийн гишүүд шаардлагатай тохиолдолд ТУЗ-ийн бүх ээлжит хурал, ТУЗ-ийн хороодын болон бусад хуралд оролцож Банкны бизнес, санхүү нягтлан бодох бүртгэл, хянан нийцүүлэлт, засаглал болон банкны үйл ажиллагааны бусад асуудлуудаар шаардлагатай мэдээлэл, тайлбар гаргаж өгдөг.

ТУЗ-ийн хурлын үеэр албан ёсоор харьцаж тайлагнахаас гадна ТУЗ-ийн гишүүд Банкны гүйцэтгэх удирдлагын гишүүдтэй тогтмол албан бус байдлаар харилцах боломжтой байдаг нь удирдлагын баг болон ТУЗ-ийн хооронд нээлттэй хэлэлцүүлэг, мэдлэг туршлага солилцох үйл ажиллагааг хангадаг.

Банкны засаглал

➤ ТУЗ-ИЙН ҮНЭЛГЭЭ

Зохистой засаглалын зарчмын дагуу ТУЗ нь засаглал, үйл ажиллагаагаа сайжруулан ажиллах зорилгоор хамтын гүйцэтгэлийг үнэлэх, дутагдлыг илрүүлэх, үйл ажиллагааг сайжруулах тодорхой арга хэмжээ авахын тулд жил бүр ТУЗ-ийн үйл ажиллагааны үнэлгээ явуулдаг. Үүнээс гадна тодорхой шалгуурыг үндэслэн ТУЗ-ийн гишүүд өөр хоорондын үнэлгээг тус бүр хийдэг.

ТУЗ-ийн үйл ажиллагааны болон гишүүдийн үнэлгээ нь компанийн засаглалын сайн туршлагад тооцогддог бөгөөд ТУЗ-ийг бэхжүүлэх, сул талыг олж илрүүлэх, чадамжийг дээшлүүлэх, үр дүнг нэмэгдүүлэх, бүтцийн талаар гишүүдийн дунд санал солилцох боломж болохоос гадна үүсгэн байгуулагчид, бусад талуудад өөрийн нэр хүндийг өсгөхөд нөлөөлдөг.

2021 онд ТУЗ-аас үйл ажиллагааны болон гишүүдийн үнэлгээ хийж тайлан, үр дүнг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар танилцуулсан болно.

➤ ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙН СУРГАЛТ

ТУЗ-ийн шинээр сонгогдсон гишүүдийг Банкны үйл ажиллагаа, байгууллагын соёлтой танилцуулж, ТУЗ-ийн гишүүдийн үүрэг хариуцлагын талаар мэдээлэл өгөх зорилгоор ТУЗ-ийн гишүүдийг сургалт танилцуулгын дараах хөтөлбөрт хамруулдаг.

- ТУЗ-ийн шинэ гишүүдэд Банкны стратеги, бизнес төлөвлөгөө, дотоод засаглалын баримт бичиг, санхүүгийн тайлан, үйл ажиллагааны болон дотоод хяналтын бодлого, ТУЗ болон түүний хороодын хурлын тэмдэглэл, тогтоол, болон ТУЗ-ийн гишүүдэд шаардлагатай бусад баримт бичиг, холбогдох хууль тогтоомж зэрэг багц баримт бичгүүдийг хүргүүдэг.
- ТУЗ-ийн шинэ гишүүдийг Банкны гүйцэтгэх удирдлагын багийн гишүүдтэй танилцуулах, Банкны санхүүгийн байдал, үйл ажиллагаа, тулгарч буй хүндрэлүүдийн талаар газар дээр танилцуулж хэлэлцэх зорилгоор уулзалтуудыг зохион байгуулдаг.
- Шаардлагатай тохиолдолд гол гол харилцагч, нэгдмэл сонирхолтой талуудтай уулзалт зохион байгуулдаг.

Шинэ гишүүд Банкны Ёс зүйн хэм, хэмжээ ба Сонирхлын зөрчлийн журам, ТУЗ-ийн гишүүдийн үүрэг хариуцлагын заалтуудтай танилцаж, хүлээн зөвшөөрч буйгаа гарын үсэг зурж мэдэгдэх үүрэгтэй.

➤ ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙН ЦАЛИН

ТУЗ-ийн гишүүд ТУЗ, хорооны хуралд оролцох болон бусад үүрэг хариуцлагыг гүйцэтгэхтэй холбоотой цалин авдаг. ТУЗ-ийн гишүүний цалингийн хэмжээг хувьцаа эзэмшигчдийн хурлаар тогтоодог.

Зохистой засаглалын зарчмын дагуу ТУЗ-ийн хараат бус гишүүний ажлын хөлс, урамшууллын хэмжээг ТУЗ-ийн гишүүний ажлын хөлс, урамшууллын хэмжээнээс багагүй тогтоодог.

ТУЗ-ийн гишүүнд хуралд оролцсонтой холбоотой зардлын нөхөн олговор олгодог. Нөхөн олговор олгох журмыг ТУЗ-ийн үйл ажиллагааны дотоод журамд заасан байдаг.

ТУЗ-ийн гишүүн зөвлөх үйлчилгээний хөлс болон өөр бусад шагнал урамшуулал авдаггүй.

➤ ТУЗ-ИЙН ХОРООД

ХасБанкны ТУЗ нь ТУЗ-өөс даалгасан тодорхой үүрэг хариуцлага бүхий 3 байнгын хороотой ба эдгээр хороод нь тодорхой асуудлуудаар мэргэжлийн зөвлөмж гаргаж, ТУЗ-ийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд туслах зорилготой. Хороодын үйл ажиллагаатай холбоотой ерөнхий заалтууд нь ТУЗ-ийн үйл ажиллагааны дотоод журмаар зохицуулагддаг ба тухайн хороонд хамаарах асуудал нь холбогдох хорооны дүрмээр зохицуулагдана. ТУЗ нь дараах байнгын хороодтой.

- Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо;
- Эрсдэлийн удирдлагын хороо;
- Аудитын хороо.

ТУЗ-ийн хороод нь тав буюу түүнээс дээш гишүүнтэй байх бөгөөд тэдгээр нь ТУЗ-ийн гишүүн байна. ТУЗ-ийн гишүүн нь нэгээс дээш хороонд ажиллаж болох бөгөөд Монгол улсын Банкны тухай хуульд заасны дагуу ТУЗ-ийн хараат бус гишүүн нь Эрсдэлийн удирдлагын болон аудитын хороодод заавал ажиллах үүрэгтэй.

Олон улсын зохистой засаглалын зарчим, Монголбанкнаас гаргасан журмын дагуу ТУЗ-ийн Аудитын хороог хараат бус гишүүн даргалдаг, ТУЗ-ийн гишүүн гүйцэтгэх захирал ТУЗ-ийн Аудит, Эрсдэлийн удирдлага, Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороодын гишүүнээр ажилладаггүй.

Хороодын үйл ажиллагааны гол хэлбэр нь хорооны хурал бөгөөд хорооны шийдвэрийг ТУЗ-д танилцуулах зөвлөмж хэлбэрээр гаргадаг. Хороодын ээлжит хурлууд нь ТУЗ-ийн хурлын өмнөх өдөр товлогддог.

2021 онд байнгын хороодын ээлжит хурлыг 4 удаа улирал бүр Webex ба Zoom харилцаа холбооны хэрэгслээр хуралдуулсан. Ээлжит хурлын чөлөөт цагт ТУЗ-ийн хороодын үйл ажиллагааг онлайн болон мэдээллийн бусад хэрэгсэлээр дамжуулан явуулж онлайн санал хураалтаар зөвлөмж гаргаж ажилладаг.

Банкны засаглал

➤ Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо

Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо нь зохистой засаглалын зарчим, бодлого зэрэг компанийн зохистой засаглалын асуудлыг хариуцаж, нэгдмэл сонирхолтой бүх талын эрх ашигт нийцсэн банкны ил тод, тогтвортой үйл ажиллагаа явуулахад чиглэл өгч, мөн хяналт тавихад шаардагдах бүтэц, процесс бүхий зохистой засаглалын тогтолцоог бүрдүүлж ажиллах үүрэгтэй. Уг хороо дараах үндсэн үүрэг хариуцлагатай. Үүнд: (i) ТУЗ-ийн гишүүн болон Гүйцэтгэх захирлын албан тушаалд томилогдох нэр дэвшигчдийг сонгон шалгаруулах, үнэлэх, ТУЗ-д санал болгох, (ii) Гүйцэтгэх захирлын ажлын гүйцэтгэлийн үнэлгээ хийж, цалин урамшууллыг тогтоох, хувьцаанд суурилсан урамшууллын хөтөлбөрт хяналт тавих, ТУЗ-ийн цалин урамшууллын талаар ТУЗ-д санал оруулах, эдгээр болно. Хорооны дүрмийг 2014 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн ТУЗ-ийн ээлжит хурлаар шинэчлэн баталсан.

ГИШҮҮД

*Майкл Мадден, дарга
Андрэж Витак
Санжай Гүпта
Нямтайширийн Цэлмүүн
Альбертус Браггинк*

➤ Эрсдэлийн удирдлагын хороо

Эрсдэлийн удирдлагын хороо нь эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын зохистой тогтолцоог бүрдүүлж, эрсдэлтэй холбоотой асуудлаар ТУЗ-д зөвлөмж гаргах үүрэгтэй. Уг хороо нь эрсдэлийн удирдлагын бодлого, бизнесийн чиглэл бүрийн материалаг эрсдэлийг бууруулах зохистой төлөвлөгөө, эрсдэлийн удирдлагын чиг үүрэг үр дүнтэй байгаа эсэх, эрсдэл хүлээх хязгаар, зээлийн багцын чанар, зээлийг батлах эрх мэдэл, зээлийг сангаас хаах зэрэг үндсэн үүрэг хариуцлагатай. Эрсдэлийн удирдлагын хорооны дүрмийг 2019 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн ТУЗ-ийн ээлжит хурлаар шинэчлэн баталсан.

ГИШҮҮД

*Ив Жако, дарга
Нямтайширийн Цэлмүүн
Альбертус Браггинк
Баянсаны Уламбаяр
(хараат бус гишүүн)
Нираж Вэдва
(хараат бус гишүүн)
Морис Лам
(хараат бус гишүүн)*

➤ Аудитын хороо

Аудитын хороо нь дотоод хяналтын системийн бүрэн бүтэн, зөв зохистой болон үр дүнтэй байдлыг хянах үүрэгтэй. Уг хороо нь хөндлөнгийн аудиторыг томилох, дахин томилох эсвэл чөлөөлөх, дотоод аудитын газрын ажлын гүйцэтгэл, санхүүгийн тайлагналын шаардлага, заалтуудыг мөрдөж буй эсэх, аудитлагдсан болон аудитлагдаагүй жилийн ба хагас жилийн санхүүгийн тайланг нягталж хянах, ердийн бус хэлцлийг хянах, хууль тогтоомжийн өөрчлөлт ба санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг хянах үндсэн үүрэг хариуцлагатай. Аудитын хороо нь Ерөнхий аудиторыг томилдог ба түүний ажлын гүйцэтгэлийг үнэлдэг. Аудитын хорооны дүрмийг 2015 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн ТУЗ-ийн ээлжит хурлаар шинэчлэн баталсан.

ГИШҮҮД

*Морис Лам
(хараат бус гишүүн), дарга
Ив Жако
Андрэж Витак
Мелисса Мой Тиан
Альбертус Браггинк
Нираж Вэдва
(хараат бус гишүүн)
Баянсаны Уламбаяр
(хараат бус гишүүн)*

➤ Сонирхолын зөрчил ба толилуулга

Ёс зүйн хэм, хэмжээ ба Сонирхолын зөрчлийн журам нь сонирхолын зөрчлийг тодорхойлж, сонирхолын зөрчлийг мэдэгдэж шийдвэрлэх журмыг тогтоодог. Үүнд:

- ТУЗ-ийн гишүүд, ажиллагсад нь өөрийн ажил үүргээ гүйцэтгэхдээ аливаа хувийн, санхүүгийн болон бусад сонирхол нөлөөлж болзошгүй тохиолдолд, түүнийгээ мэдэгдэж мэдээлэх;
- ТУЗ-ийн гишүүд Банкнаас хийх гэж буй аливаа хэлцэлтэй холбоотой ямар нэг сонирхолын зөрчилтэй бол энэ талаар тухайн хэлцлийг авч хэлэлцэж буй ТУЗ-ийн хурал дээр мэдэгдэж мэдээлэх,
- ТУЗ-ийн гишүүн аливаа хэлцэл, ажил үйлчилгээ, саналд шууд ба шууд бус сонирхолтой бол ТУЗ-өөр тухайн асуудлыг хэлэлцэж шийдвэр гаргахад санал хураалтад оролцохгүй, ирц бүрдүүлэхгүй байх, эдгээр болно.

2021 онд ТУЗ-ийн болон гүйцэтгэх удирдлагын бүх гишүүд толилуулгын хуудсыг бөглөж, сонирхолын зөрчлийн талаар мэдэгдэж мэдээлсэн. Ил тод байдлыг илүү хангах үүднээс толилуулгын хуудаснуудыг ТУЗ-ийн онлайн портал дээр байршуулж эхэлсэн.

ТУЗ-ийн гишүүд ТУЗ-ийн хурал эхлэхэд, мөн хурлын туршид хэлэлцэх асуудалтай холбоотой аливаа сонирхолын зөрчлийг мэдэгдэж мэдээлэх үүрэгтэй.

➤ Аудит ба тайлагнал

ТУЗ нь Банкны санхүүгийн тайлан үнэн зөв бэлтгэгдсэн, холбогдох хууль тогтоомж, банкны салбарын зохицуулагч байгууллагын шаардлага болон хэрэглэгдэж буй нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн эсэхэд хяналт тавьж баталдаг. Банкны удирдлага нь ТУЗ-өөр батлуулахаар санал болгосон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-д мэдээлэл тайлбар өгөх, ТУЗ-ийг үндэслэлтэй үнэлгээ дүгнэлт хийж шийдвэр гаргах боломжоор хангах үүрэгтэй.

ТУЗ нь хөндлөнгийн аудиторыг сонгох, томилох, тодорхой хугацааны дараа солих өөрчлөх үүрэгтэй ажилладаг. 2021 онд Делойт компанийн оронд хөндлөнгийн аудитороор Эрнст Янг компани аудит хийхээр томилогдсон.

ХасБанк ХХК

Захирлууд ба гүйцэтгэх удирдлагын мэдэгдэл

ХасБанк ХХК-ийн (цаашид “Банк” гэх) Гүйцэтгэх захирал Гүмэнжавын Цэвэгжав болон Санхүү хариуцсан захирал Ганзоригийн Эрдэнэбаяр, бид энэхүү тайлангийн 7-оос 92 дугаар хуудсанд толилуулсан тайлангуудыг холбогдох Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэсэн бөгөөд 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон тайлант жилийн үйл ажиллагааны үр дүн болон мөнгөн гүйлгээг үнэн зөв, шударгаар илэрхийлсэн гэдгийг үүгээр мэдэгдэж байна.



ГҮМЭНЖАВЫН ЦЭВЭГЖАВ
(Гүйцэтгэх захирал)



ГАНЗОРИГИЙН ЭРДЭНЭБАЯР
(Санхүү хариуцсан захирал)

Монгол Улс, Улаанбаатар хот
Огноо: 2022 оны 3 дугаар сарын 25

Хараат бус
аудиторын
тайлан

Хараат бус аудиторын тайлан

ХасБанк ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлд

Дүгнэлт

Бид ХасБанк ХХК (“Банк”)-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх Банкны санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр дээр нэрлэсэн санхүүгийн тайлангууд нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл (“НББОУСЗ”)-өөс баталж гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”)-ын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (“АОУС”)-ын дагуу хийж гүйцэтгэлээ. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагуудыг энэхүү тайлангийн “Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага” хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан “Мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм”-ийн дагуу Банкнаас хараат бус бөгөөд уг дүрэмд заасны дагуу өөрсдийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна

Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор удирдлага болон засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах ба залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтуудад удирдлага хариуцлага хүлээнэ.

Банкны удирдлага нь санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Банкны үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөсөн эсвэл эдгээрээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа удирдлага нь тасралтгүй байх зарчмын дагуу Банкны үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгтэй. Засаглал хариуцсан этгээдүүд нь Банкны санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу тайлагналуудаас санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм.

Зохистой баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч “АОУС”-ын дагуу хийгдсэн аудит нь оршин байгаа материаллаг буруу тайлагналуудыг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу тайлагналууд нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэдгээр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогдоно.

“АОУС”-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас үүсч болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу тайлагналуудын эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх,

өөрсдийн дүгнэлтэд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг ирүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.

- Банкны дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.
- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоолсон тооцооллууд, тэдгээрт холбогдох тодруулгууд нь үндэслэлтэй эсэхийг үнэлэх.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Банкны үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх. Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал Банкны тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)-ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг засаглал хариуцсан этгээдүүдэд мэдэгддэг.

Бусад зүйл

Банкны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайланг өөр аудитор аудитлаж, 2021 оны 3 дугаар сарын 31-ний өдөр тэдгээр санхүүгийн тайланд өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн.

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу Банкны хувьцаа эзэмшигчдийн захиалгаар аудитыг гүйцэтгэн Банкны хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргалаа. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.




ЭРНСТ ЭНД ЯНГ МОНГОЛИА АУДИТ ХХК
Мэргэшсэн нягтлан бодогчид

Гарын үсэг зурсан



Доржбатын Мандахбаяр
Захирал

Баталсан



Адриан Чу
Партнер

Улаанбаатар хот, Монгол Улс
Огноо: 2022 оны 3 дугаар сарын 25

ХАСБАНК ХХК

Ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон жилийн

/Мянган төгрөгөөр/

	2021	2020
	Дахин тайлагнасан*	
Хүү болон түүнтэй адилтгах орлого	332,086,338	381,757,320
Хүү болон түүнтэй адилтгах зардал	(174,330,045)	(262,486,698)
Хүүний цэвэр орлого	157,756,293	119,270,622
Хураамж ба шимтгэлийн орлого	26,944,135	23,288,862
Хураамж ба шимтгэлийн зардал	(8,019,386)	(6,389,820)
Хураамж ба шимтгэлийн цэвэр орлого	18,924,749	16,899,042
Арилжааны цэвэр ашиг	6,194,516	2,053,595
БҮЦАА-д бүртгэсэн бусад санхүүгийн хэрэгслүүдийн цэвэр орлого	3,601,665	3,255,082
Үйл ажиллагааны бусад цэвэр орлого/(зардал)	(374,161)	(8,661,562)
Үйл ажиллагааны нийт орлого	186,103,062	132,816,779
Үнэ цэнийн бууралтын цэвэр зардал	(4,571,200)	(19,925,538)
Үйл ажиллагааны цэвэр орлого	181,531,862	112,891,241
Үйл ажиллагааны зардал	(80,470,954)	(70,279,670)
Хойшлогдсон нөхцөлт хандивын хорогдуулга	1,407,264	1,174,729
Татварын өмнөх ашиг	102,468,172	43,786,300
Орлогын татварын зардал	(27,205,297)	(10,101,675)
Тайлант хугацааны ашиг	75,262,875	33,684,625
Бусад дэлгэрэнгүй орлого (татварын дараах):		
Дараагийн тайлант хугацаанд ашиг, алдагдлын тайлан руу дахин ангилагдахгүй бусад дэлгэрэнгүй орлого:		
Хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн ашиг, татварын дараах	2,653	169,431
Барилга, байшингийн дахин үнэлгээний олз	2,997,142	-
Бусад дэлгэрэнгүй орлого, татварын дараах	2,999,795	169,431
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого	78,262,670	33,854,056

Нэгж хувьцаанд ногдох ашиг (төгрөгөөр):		
Нэгж хувьцаанд ногдох үндсэн ашиг	75.26	33.68
Нэгж хувьцаанд ногдох хорогдуулсан ашиг	75.26	33.68

*Харьцуулсан дүнг жилийн дундуурх нэгтгэлийн үр дүнд дахин тайлагнасан.

2022 оны 3 дугаар сарын 25-ны өдөр Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс олгосон эрхийн дагуу энэхүү тайланг нийтлэхийг зөвшөөрөн гарын үсэг зурав.

ХАСБАНК ХХК

Санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх

/Мянган төгрөгөөр/

	2021	2020 оны 12-р сарын 31	2020 оны 1-р сарын 1
	Дахин тайлагнасан*		Дахин тайлагнасан*
ХӨРӨНГӨ			
Бэлэн мөнгө ба Монголбанк дахь харилцах	248,313,381	179,504,648	571,202,452
Монголбанк дахь заавал байлгах нөөц	214,231,304	186,372,668	213,044,263
БҮЦАА-д бүртгэх санхүүгийн хэрэгслүүд			
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд	49,223,110	75,684,020	99,390,188
Үнэт цаас	76,288,953	42,356,444	34,916,469
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	90,000,608	62,983,322	69,873,744
БҮЦБДО-д бүртгэх санхүүгийн хөрөнгө			
Өмчийн хэрэгслүүд	3,613,197	3,609,660	3,383,754
Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн хөрөнгө			
Банк ба санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, хадгаламж	42,487,278	82,528,044	122,475,712
Өрийн хэрэгслүүд	926,714,515	1,207,367,188	467,741,147
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	1,701,557,761	1,364,714,782	1,824,598,102
Бусад хөрөнгө	60,592,954	58,197,748	55,193,096
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө	133,594	3,033,923	4,705,877
Үндсэн хөрөнгө, ашиглах эрхтэй хөрөнгө	67,214,011	63,559,418	68,574,045
Биет бус хөрөнгө	15,452,521	14,706,533	12,085,606
Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгө	-	21,260,252	31,919,060
Хойшлогдсон татварын хөрөнгө	4,135,441	3,534,627	2,105,695
НИЙТ ХӨРӨНГӨ	3,499,958,628	3,369,413,277	3,581,209,210

ӨР ТӨЛБӨР БА ЭЗНИЙ ӨМЧ			
ӨР ТӨЛБӨР			
БҮЦАА-д бүртгэх санхүүгийн хэрэгслүүд			
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд	371,050	-	-
Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн өр төлбөр			
Репо хэлцэл	-	-	297,898,939
Банк ба санхүүгийн байгууллагын байршуулсан харилцах, хадгаламж	2,691,406	1,938,909	12,229,311
Харилцагчдын харилцах, хадгаламж	2,252,099,731	2,025,470,938	1,843,143,656
Зээлээр авсан санхүүжилт	768,775,737	937,585,863	1,012,101,730
Өрийн үнэт цаас	8,403,663	10,618,643	3,226,701
Хоёрдогч өглөг	-	-	54,415,887
Хойшлогдсон нөхцөлт хандив	9,243,242	10,318,966	8,047,821
Түрээсийн өр төлбөр	5,422,527	3,176,591	4,942,594
Бусад өр төлбөр	64,250,454	58,300,003	63,357,321
Орлогын татварын өглөг	4,705,974	8,771,190	467,132
НИЙТ ӨР ТӨЛБӨР	3,115,963,784	3,056,181,103	3,299,831,092

ЭЗНИЙ ӨМЧ			
Энгийн хувьцаа	100,000,000	58,625,979	58,625,979
Нэмж төлөгдсөн капитал	1,817,773	1,817,773	1,817,773
Нөөцүүд	84,602,413	57,851,872	46,561,682
Хуримтлагдсан ашиг	197,574,658	194,936,550	174,372,684
НИЙТ ЭЗНИЙ ӨМЧ	383,994,844	313,232,174	281,378,118
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗНИЙ ӨМЧ	3,499,958,628	3,369,413,277	3,581,209,210

*Харьцуулсан дүнг жилийн дундуурх нэгтгэлийн үр дүнд дахин тайлагнасан.

2022 оны 3 дугаар сарын 25-ны өдөр Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс олгосон эрхийн дагуу энэхүү тайланг нийтлэхийг зөвшөөрөн гарын үсэг зурав.

ХасБанкны төв байр:
Олон Улсын Худалдааны төв, Жамьян гүний гудамж - 9
Ш/салбар 20А, ш/х-72, Улаанбаатар-14200, Монгол улс

Утас: 7577 1888
Лавлах: 1800 1888
И-мэйл: info@xacbank.mn
Вэб: www.xacbank.mn